

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ БОЛОН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА



**ХУРЛЫН ОГНОО: 2023 оны 6 сарын 22-ны өдрийн 10:00 цаг**

Нова Скошиа муж, Халифакс хот  
1969 Аппер Уотер гудамж, 1300 тоот,  
МкИннес Купер Товер

2023.05.19

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Метрополитан Плэйс,  
99 Вайс Роуд, 1480 тоот  
Дартмауф Нова Скошиа, В3А 4S5

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн (“Хувьцаа эзэмшигчид”) ээлжит хурал 2023 оны 6-р сарын 22-ны өдөр Канад улсын Нова Скошиа муж, Халифакс хотын 1969 Аппер Уотер гудамж, МкИннес Купер Товер, 1300 тоот хаягт 10:00 цагт (Атлантын цагаар) дараах зорилгоор зохион байгуулагдана. Үүнд:

- (i) Компанийн 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг танилцуулах, хуулбарыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн;
- (ii) Компанийн ирэх жилийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн гишүүдийг сонгох;
- (iii) Компанийн ирэх жилийн аудиторыг томилох ба ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олгох;
- (iv) Компанийн хувьцаанд суурилсан урамшууллын цогц хөтөлбөр танилцуулан хэлэлцэх, батлах;
- (v) 2017 оны 6-р сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан Хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөний гэрээг үргэлжлүүлэх эсэхийг хэлэлцэх, батлах;
- (vi) Хурал зохион байгуулагдахаас өмнө хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн бусад хэлэлцэх асуудлууд

Хурлын өмнө хэлэлцэхээр санал болгож буй асуудлуудын дэлгэрэнгүйг Удирдлагын Мэдээллийн Танилцуулга (“Танилцуулга”)-д тусгаж, энэхүү хурлын мэдэгдэл (“Хурлын мэдэгдэл”)-ын хавсралт болгон хүргүүлнэ.

Танилцуулгад тусгаснаас гадна, 2023 оны 5-р сарын 18-ны ажлын өдөр дуусгавар болох үеийн байдлаар бүртгэлтэй Хувьцаа эзэмшигчид энэхүү Хурлын мэдэгдлийг хүлээн авах, түүнчлэн Хурлын үеэр санал өгөх эрхтэй байна. **Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн** хувиар Хуралд төлөөлөх эрхээ баталгаажуулахын тулд хуралд биечлэн оролцох эсхүл оролцохгүй эсэхийг үл харгалзан хавсаргасан саналын хуудасны загварыг бөглөн гарын үсэг зурж, огноог тавьж буцаан илгээнэ. Уг саналын хуудсыг илгээх нь Хуралд биечлэн санал өгөх эрхэд саад учруулахгүй. Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг Компанийн агент “Компьютершэйр Инвестор Сэрвис Инк / Computershare Investor Services Inc” компани нь **2023 оны 6-р сарын 20-ны өдрийн (Атлантын цагаар) 10:00 цагаас өмнө** хүлээн авсан байх ёстой. Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч нь бөглөсөн саналын хуудасны загвараа “Computershare Investor Services Inc.” компани руу дараах байдлаар илгээж болно. Үүнд:

- (a) Битүүмжилсэн дугтуйнд хийж **шуудангаар** илгээх;
- (b) Хавсралт саналын хуудасны загвар дээрх **утасны дугаараар болон цахим шуудангаар** илгээх; мөн
- (c) Computershare Proxy Department, 8th Floor, 100 University Avenue, Toronto, Ontario, M5J 2Y1 хаягт баталгаат шуудангаар, биечлэн эсвэл буухиа шуудангаар ирүүлж болно.

Хувьцаа нь зуучлагчийн нэр дээр бүртгэгдсэн **Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч** нь зуучлагчийн ирүүлсэн зааварчилгааг анхааралтай мөрдөх хэрэгтэй. Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийн загварыг буцаан илгээх дэлгэрэнгүй зааварчилгааг хавсралт танилцуулгын 2-р нүүрнээс авах боломжтой.

Хэрэв та Хуралд зориулсан нэгээс дээш тооны саналын хуудасны загвар болон зааварчилгаа хүлээн авсан бол энэ нь таны хувьцаа нэгээс олон тооны нэр дээр бүртгэгдсэнтэй холбоотой байж болно. Таны бүх хувьцаа саналын эрхтэй байхын тулд хүлээн авах бүх саналын хуудасны загвар ба зааварчилгаа тус бүрт гарын үсэг зурж буцаан илгээх шаардлагатай.

2023 оны 5-р сарын 19-ний өдөр Нова Скошиа муж, Халифакс хот, Дартмауф.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРИЙН ДАГУУ

Петер К. Акерли (*гарын үсэг зурав*)  
Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал

АГУУЛГА

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ БА ХУРЛЫН ДЭГИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ	3
Саналын хуудсыг баталгаажуулах	3
Саналын хуудсыг олгох ба цуцлах	3
Мэдэгдэл-ба-Хандалт	5
Саналын хуудсыг бөглөн, санал өгөх	6
Саналын эрхтэй хувьцаа	6
Үндсэн хувьцаа эзэмшигчид	6
ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ ХУВЬ ХҮН БА ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АШИГ СОНИРХОЛ	6
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	7
Санхүүгийн тайланг танилцуулах	7
ТУЗ-ийн гишүүдийг сонгох	7
Аудиторыг томилох	17
Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр батлах тухай	17
Компанийн Хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн батлах	24
ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	25
Цалин урамшууллын талаар хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ	25
Компанийн цалин урамшууллын бодлого ба журамтай холбоотой эрсдэлийн үнэлгээ	33
Цалин урамшууллын нэгтгэсэн хүснэгт	33
Үүрэгт ажлаас чөлөөлөх ба Хяналт солигдсоны тэтгэмж	35
ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал	36
ҮНЭТ ЦААСНЫ УРАМШУУЛЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨР БАТАЛСАН ҮНЭТ ЦААС	38
Үнэт цаасны урамшууллын төлөвлөгөө	38
Урамшууллын хувьцааны опционы төлөвлөгөө	39
Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөө	41
ТУЗ-ИЙН ГИШҮҮД БА АЛБАН ТУШААЛТНУУДЫН ӨР ТӨЛБӨР	44
МАТЕРИАЛЛАГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВСАН ХҮНИЙ СОНИРХОЛ	44
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	44
Төлөөлөн Удирдах Зөвлөл	44
ТУЗ-ийн эрх, үүрэг	46
Албан тушаалын тодорхойлолтууд	46
Чиг баримжаа олгох ба зогсолтгүй боловсрол	46
Бизнесийн ёс зүй	47
ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх	48
Цалин урамшууллын хороо	49
Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо	49
Дотоод хяналтын хороо	49
Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо	49
Техникийн хороо	49
Бусад хороо	50
Үнэлгээ	50
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ	50
НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ	50
ТАНИЛЦУУЛГЫГ ЗӨВШӨӨРСӨН	50

## ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА 2023 оны 5 сарын 19

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ БА ХУРЛЫН ДЭГИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ЭНЭХҮҮ УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТАНИЛЦУУЛГЫГ ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ ("Компани")-ИЙН УДИРДЛАГА ЭСВЭЛ ТҮҮНИЙ НЭРИЙН ӨМНӨӨС үүнд дагалдах хурлын мэдэгдэл ("Хурлын мэдэгдэл")-ийн дагуу Компанийн хувьцаа эзэмшигчид ("Хувьцаа эзэмшигчид")-ийн ээлжит хурлыг 2023 оны 6-р сарын 22-ны өдөр Нова Скошиа муж, Халифакс хотын 1969 Аппер Уотер гудамж, МкИннес Кулер Товер, 1300 тоот хаягт 10:00 цагт (Атлантын цагаар) эсвэл үүнээс хойш үргэлжлэн явагдах хурал ("Хурал")-д ашиглах САНАЛЫН ХУУДСЫГ БАТАЛГААЖУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН БОЛНО.

#### Саналын хуудсыг баталгаажуулах

Компанийн ТУЗ-ийн гишүүд, албан тушаалтнууд, ажилтнууд болон агентууд саналын хуудсыг баталгаажуулахдаа шуудангаар, мөн түүнчлэн утсаар эсхүл холбоо харилцааны бусад хэлбэрээр боломжит бага зардлаар гүйцэтгэнэ. Саналын хуудсыг баталгаажуулах үнэ төлбөрийг Компаниас төлнө. Мөн Компанийн зүгээс National Instrument 54-101-Тайлан гаргагчийн зүгээс үнэт цаас эзэмшигчтэй харилцах журам ("NI 54-101")-д заасны дагуу саналын хуудастай холбоотой материалыг дамжуулан зуучлагчийн үйлчилгээний үнэ хөлсийг хариуцна.

#### Саналын хуудсыг олгох ба цуцлах

##### Ерөнхий зүйл

Хувьцаа эзэмшигчид нь "Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчид" эсвэл "Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчид" байж болно. Хэрвээ Компанийн энгийн хувьцаа ("Энгийн хувьцаа") нь зуучлагчийн нэр дээр бүртгэлтэй, хувьцаа эзэмшигчийн өөрийн нэр дээр бүртгэлгүй байвал тэдгээрийг "Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчид" гэж нэрлэнэ. Зуучлагч нь ихэвчлэн банк, итгэмжлэгдсэн компани, үнэт цаасны дилер буюу брокер, эсвэл зуучлагч оролцдог клиринг агентлаг байж болно. Дор дурдсан зааварчилгаанд Хурлын үеэр Бүртгэлтэй ба Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчдийн Энгийн хувьцаанд санал өгөх эрхийн ялгааг харуулав.

Саналын хуудасны зааварчилгаанд нэр дурдагдсан хүмүүс нь Компанийн ТУЗ-ийн гишүүд ба албан тушаалтнууд байна. Хувьцаа эзэмшигч нь хавсралт саналын хуудасны загварт нэр дурдагдсан хүмүүсээс өөр иргэн, хуулийн этгээдийг (Хувьцаа эзэмшигч байх албагүй) өөрийн өмнөөс Хуралд эчнээ оролцуулах, төлөөлүүлэх эрхтэй. Хувьцаа эзэмшигч нь өөрийн саналын хуудсыг хэрэгжүүлээгүй тохиолдолд цуцлах эрхтэй. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох, цуцлах асуудлыг шаардлагатай тохиолдолд доорх "Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч" ба "Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч" хэсэгт заасны дагуу хэрэгжүүлнэ.

Хэрэв хувьцаа эзэмшигч нь Хуралд зориулсан нэгээс дээш тооны саналын хуудасны загвар болон зааварчилгаа хүлээн авсан бол энэ нь таны хувьцаа нэгээс олон тооны нэр дээр бүртгэгдсэнтэй холбоотой. Энэ тохиолдолд хүлээн авсан бүх саналын хуудасны загвар ба зааварчилгаа тус бүрд гарын үсэг зурж баталгаажуулан, буцаан илгээх шаардлагатай.

##### Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч

Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч нь Хуралд санал өгөхдөө биечлэн эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр эчнээ өгөх хоёр (2) сонголттой. Хуралд төлөөлөх эрхээ эдлэхийн тулд удирдлагын мэдээллийн танилцуулга ("Танилцуулга")-д дагалдах саналын хуудасны загварыг бөглөж буцаан илгээх шаардлагатай. Саналын хуудсыг илгээснээр Бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчийн Хуралд биечлэн санал өгөх эрхийг хязгаарлахгүй. Саналыг Хурал дээр хураан авч тоолно. Бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч Хуралд оролцох төлөвлөгөөгүй эсвэл өөрийн биеэр санал хураалтад оролцох хүсэлгүй бол итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж саналаа өгч болно.

Канад улс дахь хувьцаа эзэмшигчид саналын хуудсыг Компанийн шилжүүлэгч агент “**Computershare Investor Services Inc.**” компанид **2023 оны 6-р сарын 20-ний өдрийн (Атлантын цагаар) 10:00 цагаас өмнө** илгээсэн байх ёстой. Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч нь бөглөсөн саналын хуудасны загвараа “**Computershare Investor Services Inc.**” компани руу дараах хувилбараар илгээж болно. Үүнд:

- (a) Битүүмжилсэн дугтуйнд хийж шуудангаар илгээх;
- (b) Хавсралт саналын хуудасны загвар дээрх **утасны дугаараар** болон **цахим шуудангаар** илгээх;
- (c) Computershare Proxy Department, 8th Floor, 100 University Avenue, Toronto, Ontario, M5J 2Y1 хаяг руу **баталгаат шуудангаар, биечлэн** эсвэл **буухиа шуудангаар** ирүүлнэ.

Хуралд Бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс төлөөлөн оролцох хувь хүн, хуулийн этгээдийг томилох эрхээ эдлэхийн тулд, тухайн хувьцаа эзэмшигч нь хавсралт саналын хуудасны загварт дурдагдсан нэрсийг дарж, өгөгдсөн хоосон зайд өөрийн томилж буй итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэрийг бичнэ.

Саналын хуудсыг цуцлах эрхээ эдлэхийн тулд, хуулиар зөвшөөрөгдсөн нөхцөлөөс гадна, итгэмжлэл олгосон хувьцаа эзэмшигч нь уг саналын хуудсыг бичгээр цуцалж болох ба хувьцаа эзэмшигч өөрөө эсвэл түүний итгэмжлэгдсэн хуульч, эсвэл хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний итгэмжлэгдсэн албан тушаалтан эсвэл хуульч бичгээр үйлдэж (i) Компанийн бүртгэлтэй хаяг ‘1300-1969 Upper Water Street, McInnes Cooper Tower, Purdy’s Wharf, PO Box 730, Halifax, Nova Scotia B3J 2V1’-г Сьюзан Фрэйзер (D. Suzan Frazer)-д хаяглан, Хурлын өмнөх ажлын сүүлийн өдөр дуусахаас өмнө ирүүлсэн байх; эсхүл (ii) Хурал болж буй өдөр, эсвэл түүний үргэлжилж буй өдрүүдийн аль нэгэнд Хурлын даргад хандан гаргаж болох ба эдгээрийн алинд нь ч саналын хуудасны эрх цуцлагдана.

### **Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчид**

Компанид өөрийн эзэмшлийн хувьцааны талаар тодорхой мэдээллүүдийг зуучлагчаар дамжуулан өгөхөөс татгалзаагүй Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчдийг “**NOBOs**” хэмээн нэрийднэ. Харин Компанид өөрийн эзэмшлийн хувьцааны талаар тодорхой мэдээллүүдээ зуучлагчаар дамжуулан өгөхөөс татгалзсан Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчдийг “**OBOs**” гэнэ.

NI 54-101 стандартын шаардлагын дагуу, Компани нь бүхий л шаардлагатай Хурлын мэдэгдэл, танилцуулга, санал өгөх зааварчилгаа (“**СӨЗ**”) мөн саналын хуудсыг (нийтэд нь “**Хурлын материал**” гэх) NOBOs руу, түүнчлэн шууд бусаар буюу зуучлагчаар дамжуулан OBOs-д илгээнэ. Мөн Компани нь NI 54-101-д заасанчлан зуучлагчид OBOs-д Хурлын материалыг илгээсэн үйлчилгээний үнэ хөлсийг төлнө.

### **OBOs-ийн зуучлагчаас хүлээн авсан Хурлын материал**

Компани нь Хурлын материалын хуулбаруудыг OBOs-д хүргүүлэхээр зуучлагчид хуваарилсан болно. Зуучлагчид нь эдгээр материалуудыг хүлээн авах эрхээсээ татгалзаагүй бөгөөд Энгийн хувьцаанд санал хэрхэн өгөх талаар зааварчилгаа авахыг эрмэлзэж байгаа Компанийн бүх OBOs-д тараах үүрэгтэй. Зуучлагчид Хурлын Материалыг OBOs-д дамжуулахын тулд ихэвчлэн үйлчилгээний компанийг (Broadridge Financial Solutions, Inc. гэх мэт) ашигладаг.

Хурлын материалыг хүлээн авах OBOs-д санал өгөх зааварчилгааг дараах хоёр хувилбарын аль нэгээр өгөх боломжтой байдаг:

- (a) Ихэвчлэн, OBO-д СӨЗ-г өгөх ба үүнийг OBO нь зуучлагчаас ирүүлсэн зааварчилгааны дагуу бөглөж гарын үсэг зурна. Энэ тохиолдолд дээрх Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн хэсэгт дурдсан механизмыг хэрэглэх боломжгүй бөгөөд зуучлагчаас ирүүлсэн зааварчилгааг мөрдөх ёстой.
- (b) Зарим тохиолдолд OBO-д зуучлагчаас ирүүлсэн саналын хуудасны загварт зуучлагч аль хэдийн гарын үсэг зурсан байж болно. Ийм саналын хуудасны загвар нь OBO-ийн эзэмшдэг Энгийн хувьцааны тоонд хязгаарлагдсан байх боловч бөглөгдөөгүй байна. Энэхүү саналын



хуудасны загварт OBO гарын үсэг зурах шаардлагагүй боловч OBO заавал өөрөө бөглөж, дээрх Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн хэсэгт дурдсан байдлаар Computershare Investor Services Inc. (“**Computershare**”) компанид буцаан илгээнэ.

Эдгээр журмуудын зорилго нь OBOs нь өөрийн нэр дээр бүртгэлгүй хэдий ч эзэмшдэг Энгийн хувьцааны саналын эрхэнд итгэмжлэл гаргах боломжийг олгоход оршино. Хуралд биечлэн оролцох, санал өгөх (эсвэл өөр хэн нэгнээр өөрийн нэрийн өмнөөс эчнээ оролцуулах, санал өгүүлэх) хүсэлтэй OBO нь саналын хуудасны загвар болон СӨЗ аль алиныг хүлээн аваад, саналын хуудасны загвар дээр итгэмжлэл олгогдсон хүний нэрийг дарж, OBOs-ийн (эсвэл хэн нэгний) нэрийг өгөгдсөн хоосон нүдэнд бичих ба харин СӨЗ-ийн хувьд зуучлагчаас ирүүлсэн зааварчилгааг дагаж мөрдөнө. **Аль ч тохиолдолд, өөрийн зуучлагчаас Хурлын материал хүлээн авсан OBOs нь зуучлагчаас ирүүлсэн зааварчилгааг анхааралтай мөрдвөл зохино.**

Саналын хуудсыг цуцлах эрхээ эдлэхийн тулд, саналын хуудсыг (эсвэл СӨЗ, хэрэв байгаа бол) бөглөсөн OBO нь зуучлагчийн өгөх зааварчилгааг анхааралтай дагаж мөрдөх шаардлагатай.

Хэрэв зуучлагч OBO-оос тодорхой хувьцааны саналын эрхийн талаар зааварчилгаа аваагүй эсвэл аливаа хөрөнгийн биржийн болон бусад дүрэм журмын улмаас, эсвэл Хурлын өмнө тулгарсан нэг ба түүнээс олон асуудлын улмаас зуучлагч тэдгээр хувьцаанд санал өгөх хүсэлгүйн улмаас зуучлагчаас буцаасан "санал өгөхгүй" саналын хуудас нь дээрх шалтгааны улмаас санал өгөх эрхгүй бөгөөд санал өгсөн ч тоологдохгүй. Гэсэн хэдий ч “санал өгөхгүй” Энгийн хувьцаа эзэмшигч нь хурлын ирц бүрдсэн эсэхийг тогтооход ирцийн тоонд тоологдоно.

### **NOBOs-ийн Компаниас хүлээн авсан Хурлын материал**

NI 54-101-аар зөвшөөрөгдсөний дагуу, Компани нь NOBO-ийн нэрсийн жагсаалтыг ашиглан уг жагсаалтад байгаа NOBOs-д Хурлын материалыг тараана. Хэрэв та NOBO бөгөөд Компанийн шилжүүлэгч агент Computershare-ээс эдгээр материалууд танд шууд ирсэн бол, үнэт цаасны хуулийн шаардлагын дагуу таны өмнөөс зуучлагчаас таны нэр хаяг болон Энгийн хувьцааны эзэмшлийн талаарх мэдээллийг авсан гэсэн үг юм.

Үүний үр дүнд Компанийн бүх NOBO-д Computershare-ээс СӨЗ-ны хуулбар илгээгдэнэ. СӨЗ-г бөглөөд өгөгдсөн дугуйнд хийж, Computershare руу буцааж явуулах хэрэгтэй. Саналаа утсаар болон интернетээр СӨЗд заасны дагуу өгөх боломжтой. Утсаар болон интернетээр санал өгөхтэй холбоотой дүрэм журам, зааварчилгааг СӨЗ-д тусгасан болно. Computershare нь Компанийн NOBOs-уудын ирүүлсэн СӨЗ-ны дүнг нэгтгэн гаргах ба Computershare-ийн хүлээн авсан СӨЗ-г төлөөлөх хувьцааны талаар Хуралд зохих зааварчилгааг гаргана.

Эдгээр материалыг танд шууд хүргүүлснээр, Компани нь (зуучлагч таны өмнөөс Энгийн хувьцаа эзэмшээгүй бол) (i) эдгээр материалыг танд шууд хүргэх; мөн (ii) санал өгөх зааварчилгааг бүрэн өгөх үүргийг хүлээнэ. Зуучлагч таны өмнөөс Энгийн хувьцаа эзэмшдэг бол тухайн хувьцаанд санал өгөх эрхийг танд шилжүүлснээр та Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн нэгэн адилаар энэхүү баримт бичигт багтсан саналын хуудасны загварыг бөглөж саналын зааварчилгааг хүргүүлэх боломжтой болно. Саналын хуудасны загварыг хэрхэн буцаан илгээх, хуралд оролцох өөр хувь хүн эсхүл хуулийн этгээд томилох, итгэмжлэлээ цуцлах эрхийн тухай зааварчилгаатай “*Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч*” гарчгийн дор байгаа мэдээллээс танилцана уу.

Хувьцаа нь зуучлагчийн нэр дээр бүртгэлтэй Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч нь Хуралд санал өгөхөд шууд хүлээн зөвшөөрөгдөхгүй байж болох ч, Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч нь Хуралд Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, Энгийн хувьцаанд санал өгч болно. Хуралд оролцож, Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувиар өөрийн Энгийн хувьцаанд санал өгөх хүсэлтэй Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч нь саналын хуудасны загвар дээрх хоосон нүдэнд өөрийн нэрийг бичих шаардлагатай ба брокероос өгсөн зааварчилгааны дагуу брокертоо (эсвэл брокерийн агент) буцаан илгээх ёстой.

### **Мэдэгдэл-ба-Хандалт**

Компани нь Хурлын материалыг Бүртгэлтэй болон Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчдэд NI 54-101 ба NI 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага-д заасан мэдээллийн мэдэгдэл-ба-хандалтын журмын дагуу илгээгээгүй болно.

### Саналын хуудсыг бөглөн, санал өгөх

Сонголтыг тодорхой тусгаснаар Энгийн хувьцаанд саналын хуудсаар санал өгөх, санал өгөхөөс татгалзах, эсрэг санал өгөх, мөн өгсөн чиглэлийн дагуу санал асуулга ба санал хураалтад оролцоно. **Хэрэв сонголтгүй байхаар тусгасан бол саналын хуудас нь олгогдсон эрхийн хүрээнд саналын хуудасны загварт тусгасан бүхий л асуудлыг дэмжиж санал өгсөнд тооцно. Мөн энэхүү саналын хуудсанд олгогдсон эрхээр санал өгөх, санал өгөхөөс татгалзах, Хурлын мэдэгдэлд тусгасан асуудлуудад нэмэлт ба өөрчлөлт оруулах эсвэл Хурлын мэдэгдэлд тусгайлан дурдагдаагүй боловч Хурлын өмнө гарч ирсэн өөр бусад асуудлуудад эсрэг санал өгөх эрхийг эдэлнэ.**

Удирдлагын зүгээс одоогийн байдлаар Хурлын мэдэгдэлд тусгасан асуудлуудад нэмэлт ба өөрчлөлт оруулах эсэх мөн түүнчлэн Хурлын мэдэгдэлд тусгагдаагүй өөр бусад асуудал Хурлын үеэр хэлэлцэх талаар мэдээлэл байхгүй байна. Гэвч Хурлаас өмнө нэмэлт асуудлууд гарч ирвэл энэ нь Компанийн удирдлагаас санал өгөх зөвлөмжийн дагуу битүүмжилсэн баримт бичигт нэр нь дурдагдсан хүмүүсийн хүсэлт юм.

### Саналын эрхтэй хувьцаа

Компани нь хязгааргүй тооны Энгийн хувьцаа гаргах эрхтэй бөгөөд өнөөгийн байдлаар эргэлтэд гаргасан нийт хувьцааны тоо 344,400,376 ширхэг байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ” буюу “Зөвлөл”) нь Хурлын бүртгэлийн өдөр (“Бүртгэлийн өдөр”)–ийг 2023 оны 5-р сарын 18-ний ажлын өдрөөр дуусгавар болохоор тогтоосон. Энэхүү Бүртгэлийн өдөр дуусгавар болохоос өмнө бүртгэгдсэн Хувьцаа эзэмшигчид Хуралд санал өгөх эрхтэй бөгөөд Хурал болохоос 10 өдрийн өмнө тухайн Хувьцаа эзэмшигч нь Энгийн хувьцаа эзэмшдэг талаарх хангалттай нотолгоо гаргаж, улмаар Хуралд санал өгөх эрхтэй Хувьцаа эзэмшигчийн жагсаалтад уг Хувьцаа эзэмшигчийн нэрийг багтааснаар Хуралд санал өгөх эрхтэй болно. Санал өгөх эрхтэй Хувьцаа эзэмшигчид гар өргөн санал өгснөөр нэг саналд тооцох ба нэгж хувьцаанд нэг саналын эрх ногдоно.

Нийт энгийн хувьцааны 5%-аас дээш хувийг төлөөлөх санал өгөх эрхтэй хоёр ба түүнээс дээш тооны хувьцаа эзэмшигч Хуралд биечлэн оролцсоноор Хурлын ирцийг бүрдсэнд тооцно.

### Томоохон хувьцаа эзэмшигчид

Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнуудад байгаа мэдээллээр Компанийн эргэлтэд гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг шууд ба шууд бусаар эзэмшдэг, эсвэл хяналт тавьдаг эсвэл чиглүүлдэг хувь хүн болон хуулийн этгээд доор дурдагдсанаас бусдаар байхгүй болно.

Овог нэр, оршин суугаа хаяг	Энгийн хувьцааны тоо ширхэг	Энгийн хувьцааны хувь
2176423 Ontario Ltd. (Эрик Спротт)	61,225,488	17.8%

## ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ ХУВЬ ХҮН БА ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АШИГ СОНИРХОЛ

2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойш Компанийн үнэт цаасыг шууд ба шууд бусаар эзэмших замаар Компанийн ТУЗ-д гишүүнээр эсвэл гүйцэтгэх албан тушаалтнаар томилогдсон, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн материаллаг ашиг сонирхол бүхий этгээд, мөн түүнтэй холбоотой этгээд байхгүй, иймээс ТУЗ-ийн гишүүдийг сонгохоос бусдаар энэ талаар Хуралд хэлэлцэж шийдвэрлэх асуудал байхгүй.

## ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

### Санхүүгийн тайланг танилцуулах

Хурлын үеэр Компанийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт болон Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

### ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Компанийн дүрэмд заасанчлан ТУЗ (“Зөвлөл”) нь гурваас (3) багагүй ба арваас (10) ихгүй тооны гишүүдээс бүрдэх ба жил бүр сонгогдоно. Компанийн дүрэмд ТУЗ дэх гишүүдийн тоог ТУЗ тогтооно гэж заасан. Зөвлөл нь одоогоор найман (8) гишүүнтэй. Зөвлөлөөс ирэх жилд найман (8) гишүүнтэй байх нь тохиромжтой гэж үзсэн бөгөөд Хурал дуусахад хүчин төгөлдөр найман (8) гишүүнтэй байхаар тогтсон. Өмнөх жилийн ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон гишүүдийн гуравны нэг (1/3) хүртэл тооны гишүүдийг томилох эрхийг Зөвлөлд олгосон.

Доор дурдсан, нэр бүхий хүмүүс нь Компанийн одоогийн ТУЗ-ийн гишүүд юм. Нэр дэвшигчид нь удирдлагын үзэж байгаагаар Компанийн ирэх жилийн үйл ажиллагааг удирдах чадвартай хүмүүс бөгөөд хэрэв сонгогдвол ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлыг хаших хүсэл эрмэлзэлтэй байгаагаа бүгд илэрхийлсэн болно. Сонгогдох гишүүн бүрийн албан тушаал хаших хугацаа нь ирэх жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл эсвэл албан тушаалаасаа өөр байдлаар чөлөөлөгдөх хүртэл үргэлжилнэ.

**Үүгээр баталгаажсан саналын хуудас нь Энгийн хувьцааг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчид санал өгөхөөс татгалзахыг тусгайлан зааварчлаагүй бол дор дурдсан жагсаалтад нэр нь бичигдсэн нэр дэвшигчийн төлөө санал өгнө.** Удирдлагын зүгээс эдгээр нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлыг хаших чадамжгүй гэж үзэх үндэслэлгүй бөгөөд, хэрэв Хурлын өмнө ямар нэгэн өөр учир шалтгаан гарвал удирдлагын зүгээс санал гаргах ба Энгийн хувьцааг төлөөлөн гүйцэтгэсэн саналын хуудасны загварт итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн үзэл бодлоор өөр нэр дэвшигчид санал өгч болно.



**Петер К.Акерли**

Компанийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал



Канад улс, Нова  
Скошиа

ТУЗ-ийн гишүүн  
болсон огноо:  
2003.02.25

Гүйцэтгэх  
захирал ба  
ТУЗийн гишүүн

Петер Акерли нь эрдсийн хайгуул, байгууллагын санхүүжилт, төсөл хөгжүүлэлт болон нээлттэй хувьцаат компанийн удирдлагаар 30 гаруй жил ажилласан туршлагатай удирдах албан тушаалтан юм. Тэрээр Эрдэнэ Ресурсийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 2003 оны 3 сараас хойш Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Акерли нь ажил мэргэжлийнхээ он жилүүдийн ихэнхэд нь Хойд, Өмнөд Америк, Ази тивийн орнуудад ажилласан ба тэр дундаа Монгол Улсад молибден зэсийн томоохон ордын нөөцийг баталгаажуулах, Алтан Нар алтны ордыг нээж, нөөцийг тогтоох, Баян Хөндий алтны төслийг нээн илрүүлэх зэрэг ажлуудад техникийн багийг удирдан ажилласан геологич юм. Мөн байгууллагын нэгдэн нийлэх үйл ажиллагаа, хувь нийлүүлэх болон санхүүжилтийн чиглэлээр 20 гаруй жилийн арвин туршлагатай бөгөөд 2004 онд Компани Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болсноос хойш дээр дурдсан санхүүжилтүүд болон үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан. Петер Акерли нь Темекс Ресурсиз Корпорацийн (“Temex Resources Corp”) Удирдах зөвлөл болон компанийг Лейк Шор Гоулд Корпорацид (“Lake Shore Gold Corp”) худалдах үйл ажиллагааны Тусгай хороонд ажиллан, зөвлөгөө өгч байсан. Мөн Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Морейн Ресурсиз Корпорацийн (“Morien Resources Corp”) захирлаар ажиллахдаа Донкин Коул (“Donkin Coal”), Блэк Пойнт Аггрегейт (“Black Point Aggregate”) төслүүдийг зарах үйл ажиллагаанд оролцон эзэмшлийн хувьцааг нөөцийн төлбөр болгон хөрвүүлсэн. Түүнчлэн Нова Скошиа мужид амжилттай хэрэгжиж буй Катапулт манлайллын хөтөлбөрийг санаачлан, тэргүүлэх дэмжигч компани болгох эхлэлийг тавьсан. Акерли Халифакс дахь Сэнт Мэригийн (Saint Mary’s University) их сургуулийг геологич мэргэжлээр (BSc) бакалаврын зэрэгтэй төгсөж (1988), 2012 оны 12 дугаар сард Байгууллагын Захирлуудын хүрээлэнгийн Аудитын хорооны сургалтыг дүүргэсэн.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хурал	6 / 6	100%
Техникийн хорооны хурал	1 / 1	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Morien Resources Corp. (TSX-V)

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналбн тоо #	120,337,823	0	120,337,823
Саналын хувь %	100.00%	0.00%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	3,006,849	1,776,760	4,783,609	\$1,626,427
2022.05.19	2,846,849	1,742,052	4,588,901	\$1,766,727

**Др. Анна Биолик**  
ТУЗ-ийн гишүүн



Канад улс,  
Бритиш  
Колумб

ТУЗ-ийн  
гишүүн болсон  
огноо:  
2016.06.14

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

Др. Анна Биолик – Др. Биолик төр ба хувийн хэвшлийн салбарт 30 гаруй жил ажиллаж буй туршлагатай, Төв Азийн бизнес, дипломат харилцааны чиглэлээр мэргэшсэн Канадын тэргүүлэгч мэргэжилтнүүдийн нэг. Тэрбээр 2010-2012 онд Канадын Гадаад хэрэг, Олон улсын худалдааны яамны Номхон далайн бүс хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2012 онд төрийн албанаас чөлөөлөгдсөн. Др.Биолик 2014 оноос бие даасан зөвлөхөөр ажиллаж, дэлхийн бизнес стратеги, худалдааны дипломат харилцааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Аллам Эдвайзори Групп (“Allam Advisory Group”)-ийн Дэд ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлын албыг хашиж болсон байна. Тэрбээр Канад Улсаас Монгол Улсад суусан анхны Элчин сайд бөгөөд 2008 онд Канадын бүрэн эрхт элчин сайдын яамыг байгуулж байв. Др.Биолик өмнө нь Канад Улсаас Казахстан, Кыргызстан болон Тажикистан улсад суух Элчин сайдаар, Оросын Холбооны Улсын Санкт Петербург хотноо суух Ерөнхий консулаар тус тус томилогдон ажиллаж байсан. Түүнчлэн тэрбээр олон улсын харилцаа, парламентын асуудлаар Канадын Амбан захирагчийн Ахлах зөвлөх, Канадын шууданд Европыг хариуцсан маркетингийн менежер, Инвестмент Партнершипс Канад (“Investment Partnerships Canada”)-д Ахлах менежер, Олон улсын бизнес хөгжүүлэх төвд Захирал зэрэг албан тушаалыг хашиж байв. Хөгжиж буй зах зээл дэх Канадын компаниудтай ойр хамтран ажиллаж байсан, олон улсын худалдааны чиглэлээр өндөр туршлагатай Др.Биолик нь 2013-2019 хооронд Бритиш Колумбын Викториа дахь Роял Роудс их сургууль (Royal Roads University)-ийн Хөтөлбөр, судалгааны зөвлөлийн бие даасан гишүүн, Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн Канадын зөвлөлийн даргаар ажиллаж байсан. Др. Биолик Монреалийн их сургууль (“University of Montreal”)-д докторын (Ph.D) зэрэг хамгаалсан бөгөөд Англи, Франц, Орос, Польш хэлтэй.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хороо	6 of 6	100%
Компанийн засаглал, мэдээлэл гаргах бодлогын хороо	1 of 1	100%
Аудит ба эрсэдлийн удирдлагын хороо	4 of 4	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Байхгүй

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналын тоо #	120,337,823	0	120,337,823
Саналын хувь %	100.00%	0.00%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	146,462	467,779	614,241	\$208,842
2022.05.19	131,462	345,243	476,705	\$183,531

**Жон П. Бюри**

Ерөнхийлөгч, Petroleum Corporation of Canada Exploration Ltd.

Ерөнхийлөгч, Petroleum Corporation of Canada Limited



Канад улс,  
Онтарио

ТУЗ-ийн  
гишүүн болсон  
огноо:  
2004.08.25

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

Жон Бюри нь хөрөнгө оруулалтын банк, байгууллагын санхүүгийн чиглэлээр 40 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрбээр 1976 оноос хойш Канада Эксплорэйшн Лимитедийн Петролиум Корпораци (“Canada Exploration Limited”, “Petroleum Corporation”) -ийн (Петрекс) Ерөнхийлөгчийн албыг хашиж буй. Жон Бюри Петрексийн туслалцаатай байгуулагдаж, санхүүжсэн Энерплас Энержи Сервисес Лтд. Компани (“Enerplus Energy Services Ltd”) -ийн Дэд захирлаар (1986-2000) ажиллаж байснаас гадна Левеск Бюбин Жеоффрион Инк. (“Levesque Beaubien Geoffrion Inc”) (одоогийн Үндэсний Санхүүгийн банк), А.Е Амис энд Компани (“A.E Ames & Company”) / Доминион Секюритиз Амис (“Dominion Securities Ames”) болон Дэ Фөрст Бостон Корпораци (“The First Boston Corporation”) зэрэг байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан. Тэрбээр МакГилл Их сургууль (“McGill University”) -ийг Бакалаврын (B.A) зэрэгтэй, Торонтогийн Их сургууль (“University of Toronto”) -ийн Хуулийн сургуулийг эрхзүйн бакалавр (LL.B) зэрэгтэй тус тус дүүргэсэн, Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээч (CFA) юм. Мөн Morien Resources Corp (TSX-V) -ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хороо	4 / 6	67%
Компанийн засаглал, мэдээлэл гаргах бодлогын хороо	1 / 1	100%
Аудит ба эрсэдлийн удирдлагын хороо	4 / 4	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Morien Resources Corp. (TSX-V)

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
<b>Саналын тоо #</b>	120,037,823	300,000	120,337,823
<b>Саналын хувь %</b>	99.75%	0.25%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
<b>2023.05.18</b>	7,373,290	674,919	8,048,209	\$2,736,391
<b>2022.05.19</b>	7,373,290	602,605	7,975,895	\$3,070,720

**Т. Лэйтон Крофт**

Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, Carolina Rush Corporation (TSX-V)



АНУ, Хойд  
Каролина

ТУЗ-ийн  
гишүүн болсон  
огноо:  
2015.07.02

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн ба  
ТУЗ-ийн дарга

Лэйтон Крофт нь дэлхийн хэмжээнд ТББ, дунд болон томоохон групп компаниудад 29 жил удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай удирдагч. Тэрээр аж ахуйн нэгж байгуулах, манлайлах, төсөл хэрэгжүүлэх, оролцогч талуудын цогц менежмент, төр хувийн хэвшлийн түншлэл, стратегийн харилцаа холбоо, компанийн засаглал, БОНУ чиглэлээр мэргэшсэн туршлагатай. Түүний Монгол дахь туршлага нь 1994 онд АНУ-ын Энх тайвны корпусын сайн дурын ажилтнаар ажилласан гурван жилийн хугацаанд Монголын баруун өмнөд хэсэгт орших Баянхонгор аймагт хоёр жил ажиллаж байсан үеэс эхтэй. Тэрээр Өмнөд Солонгос, Индонез, Хонконг, Сингапурт ажиллаж амьдарч байсан ба Монгол Улсад 15 жил бүтэн цагаар ажиллаж амьдарч байсан. Лэйтон Крофт нь Оюу Толгой ХХК, Айвенхоу Майнз, Рио Тинто, Пибоди Энержи, Дьюк Энержи зэрэг компаниудад гүйцэтгэх захирал болон зөвлөхөөр ажиллаж байсан. Лэйтон нь 2015 оны 6 сараас Эрдэнэ Ресурсийн Хараат бус ТУЗ-ийн гишүүн байсан ба 2019 оноос хойш ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Мөн тэрээр Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хороо болон Компанийн засаглал, мэдээлэл гаргах бодлогын хорооны гишүүн. 2017 оны 4-р сараас хойш АНУ-ын зүүн өмнөд хэсэгт алтны хайгуул хийх чиглэлээр ажилладаг Канадын уул уурхайн компани Каролина Раш Корпорацийн (TSXV: RUSH) (хуучнаар Pancontinental Resources Corp.)-н ерөнхийлөгч, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2022 оны 1-р сараас хойш Лэйтон нь Онтарио дахь никелийн хайгуулын уул уурхайн компани Voltage Metals Corp (CSE: VOLT)-ийн хараат бус ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Лэйтон нь Чапел Хилл дахь Хойд Каролинагийн их сургууль (“University of North Carolina”), Вермонт дахь Олон улсын сургууль, Тафтс их сургууль (“Tufts University”)-ийн Хууль, Дипломат харилцааны Флетчер сургуулийг тус тус дүүргэсэн. Тэрээр Хойд Каролина мужийн Шарлотт хотод амьдардаг.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хороо	6 / 6	100%
Компанийн засаглал, мэдээлэл гаргах бодлогын хороо	1 / 1	100%
Аудит ба эрсэдлийн удирдлагын хороо	4 / 4	100%
Цалин урамшууллын хороо	1 / 1	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Carolina Rush Corporation (TSX-V)  
Voltage Metals Corporation (CSE)

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналын тоо #	120,037,823	300,000	120,337,823
Саналын хувь %	99.75%	0.25%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	1,228,478	471,832	1,700,310	\$578,105
2022.05.19	1,228,478	406,090	1,634,568	\$629,309

**Кеннет В.МакДоналд**

Ерөнхийлөгч, Fisher Transport Limited



Кеннет МакДоналд 2019 оны 6-р сард ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон. Кеннет МакДоналд 2016 оноос 2019 оны 5-р сар хүртэл Эрдэнэ Ресурсийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. Мөн тэрээр 2003 оны 3-р сараас 2019 оны 5-р сар хүртэл Эрдэнэ Ресурсийн Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байсан. 1992 оны 9-р сараас эхлэн МакДоналд Фишер Транспорт Лимитед компанийн ерөнхийлөгчөөр ажиллаж байна. МакДоналд 1996-2006 онд Каоклей Ресурсиз Инк. Корпораци (“Kaoclay Resources Inc.”)-ийн санхүү хариуцсан дэд ерөнхийлөгчийн албыг хашиж байжээ. Тэрбээр 1985 оноос өмнө Канадын нягтлан бодох бүртгэлийн томоохон фирмүүдийн нэгт мэргэшсэн нягтлан бодогч, ахлах менежерээр тус тус ажиллаж, 1985-1992 оны 9 дүгээр сарыг хүртэл ашигт малтмалын чиглэлээр төрийн болон хувийн компаниудад санхүү хариуцсан дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. МакДоналд Сэнт Мэригийн их сургууль (“St Mary’s University”)-ийг 1977 онд бакалаврын (BCom) зэрэгтэй дүүргэж, 1980 онд мэргэшсэн нягтлан бодогч болсон.

Канад улс, Нова  
Скошиа

ТУЗ-ийн гишүүн  
болсон огноо:  
2019.06.20

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хурал	6 / 6	100%
Цалин урамшууллын хороо	1 / 1	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Байхгүй

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналын тоо #	120,037,823	300,000	120,337,823
Саналын хувь %	99.75%	0.25%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	2,102,781	278,930	2,381,711	\$809,782
2022.05.19	2,102,781	226,338	2,329,119	\$896,711

**Камерон МакРэй**

Гүйцэтгэх захирал, Tarva Investment & Advisory  
ТУЗ-ийн дарга, Kincora Copper Limited



Шинэ Өмнөд  
Вэльс,  
Австрали

ТУЗ-ийн  
гишүүн болсон  
огноо:  
2018.03.14

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

Камерон МакРэй 2018 оны 3 дугаар сард ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон. Тэрбээр гурван тивийн дөрвөн улсад уул уурхайн бүрэн хөгжүүлэлт хийж, уул уурхайн компаниудыг удирдаж байсан туршлагатай удирдах албан тушаалтан юм. Камерон Рио Тинтод 28 жил ажиллах хугацаандаа Монгол Улсад Оюу Толгой ХХК-ийн Захирал, Рио Тинтогийн Монгол Улсыг хариуцсан захирлын албыг тус тус хашиж байсан бөгөөд энэ үед 6 тэрбум ам.долларын Оюу Толгой зэс-алтны уурхайн бүтээн байгуулалт, нээлтийг төлөвлөгөөт хуваариас нь өмнө эхлүүлж, зөвхөн бүтээн байгуулалтын ажилд 15,000 гаруй хүнийг ажлын байраар хангаж байсан. Камерон бүтээн байгуулалтын шинэ (greenfield) болон сайжруулалтын (brownfield) төслүүд, бизнесийн цогц өөрчлөлт, шинэчлэлтийн төслүүдийг амжилттай удирдаж, компанийн түвшинд арилжаа/нэгдэн нийлэх ажиллагааг удирдан явуулж байсан арвин туршлагатай. Тэрээр Оюу Толгойд ажиллахаасаа өмнө Өмнөд Африк дахь Ричардс Бей Минералс (“Richards Bay Minerals”)–д Гүйцэтгэх захирал (2008-2010), Зимбабве улсын Мурова Даймондс (“Murowa Diamonds”)–д Ерөнхий захирал (2006-2007), Австрали дахь Хайл Крик (“Hail Creek”)–ийн коксжих нүүрсний өргөжүүлэлтийн төсөлд Төслийн захирлаар тус тус ажиллаж байв. 2004 оноос өмнө Компанийн болон Бизнесийн нэгжийн түвшинд үйл ажиллагаа, төслүүдийн хөгжүүлэлтийг удирдан ажиллаж байсан. Камерон 1995 онд CRA болон RTZ–ийн нэгдэх, цаашлаад давхар бүртгэлтэй Рио Тинто компани болох 29 тэрбум австрали долларын хэлцэл, үйл ажиллагааг зохион байгуулсан багийн голлох гишүүн байсан. МакРэй нь ДиТиПи Партнерс (“DTP Partners”) компанийн хамтран үүсгэн байгуулагч бөгөөд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Кинкора Коппер (Kincora Copper Limited, KCC on the TSX-V and ASX) компанийн ТУЗ-ийн дарга юм. Мөн тэрээр Монголын Бизнесийн Зөвлөлийн зөвлөх (Дэд захирал асан) болон Урлагийн зөвлөлд удирдах албан тушаалуудыг хашдаг. Камерон Австрали, Африк улсуудад боловсрол эзэмшсэн бөгөөд Худалдаа болон Бизнесийн удирдлагын магистр (Монаш Маунт Элиза бизнесийн сургууль, 1991) (“Monash mount Eliza, 1991”) зэрэгтэй.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хурал	6 / 6	100%
Техникийн хорооны хурал	1 / 1	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Kincora Copper Limited (TSX-V and ASX)

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналын тоо #	120,326,301	11,522	120,337,823
Саналын хувь %	99.99%	0.01%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	744,778	211,462	956,240	\$325,122
2022.05.19	578,111	178,593	756,704	\$291,331



**Дэвид В. Мошер**  
ТУЗ-ийн гишүүн



Канад улс,  
Нова Скошиа

ТУЗ-ийн  
гишүүн болсон  
огноо:  
2016.06.14

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

Дэвид В.Мошер нь олон улсын уул уурхайн салбарт 35 гаруй жил ажилласан туршлагатай удирдах албан тушаалтан юм. Тэрээр 1992-2008 онд Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Канад, Африк, Орос улсад алтны хайгуул, олборлолт, боловсруулалт хийдэг Хай Ривер Гоулд Майнз Лтд. Компани (“High River Gold Mines Ltd”)-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Энэхүү компанийг удирдах хугацаандаа Оросын алтны хоёр уурхайн нэгдэх үйл ажиллагааны хэлцлийг хийж байсан ба Буркина Фасогийн засгийн газартай уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж байсан. Мөн компанийг өргөжүүлэн тэлэхэд шаардлагатай 300 сая долларын санхүүжилт босгож, хоёр ил уурхайн (Буркина Фасо дахь Тапарко “Tarako” алтны уурхай, Орос дахь Березитовый “Berezitovy” алтны уурхай) хөгжүүлэлтийг удирдан чиглүүлж ажиллажээ. Дэвид Панконтинентал Майнинг Лимитед компани (“Pancontinental Mining Limited”)-ийн төслийн менежерээр ажиллаж байх хугацаандаа багийн гишүүдтэйгээ хамтран тухайн үед дэлхийд хамгийн томд тооцогдох ураны ордыг (Австралийн хойд хэсэгт орших Жабилука орд) илрүүлэн нээсэн байна. Мөн Камбиор Инк. (“Cambior Inc”) зэрэг компаниудын удирдах зөвлөлд ажиллаж байсан. Сүүлийн жилүүдэд тэрбээр төрийн болон хувийн хэвшлийн ашигт малтмалын компаниудад бүтцийн өөрчлөлт хийх, дахин санхүүжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ба одоогийн байдлаар Каролина Раш корпораци (“Carolina Rush Corporation”) (TSX-V), Пелангио Эксплорэйшн Инк. (“Pelangio Exploration Inc”) (TSX-V) зэрэг хайгуул, олборлолтын хэд хэдэн компанийн захирлаар ажиллаж байна. Дэвид Акадиа их сургууль (“Acadia University”)-ийг геологийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй (BSc) дүүргэсэн.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хурал	6 of 6	100%
Цалин урамшууллын хороо	1 of 1	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

Harvest Gold Corporation (TSX-V)  
Carolina Rush Corporation (TSX-V)  
Pelangio Exploration Inc. (TSX-V)  
Roscan Minerals Corporation (NEX)

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналын тоо #	120,337,823	0	120,337,823
Саналын хувь %	100.00%	0.00%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	812,067	500,657	1,312,724	\$446,326
2022.05.19	812,067	393,232	1,205,299	\$464,040

**Хэдли Виддап**

Хөрөнгө оруулалтын менежер, Lion Selection



Мелбурн,  
Австрали улс

ТУЗ-ийн  
гишүүн болсон  
огноо:  
2019.09.30

ТУЗ-ийн хараат  
бус гишүүн

Хэдли Виддап нь уул уурхай, геологи, уул уурхайн хөрөнгө оруулалтын салбарт 21 гаруй жил ажилласан туршлагатай геологич юм. Хэдли нь Мт Кэйт Никелийн уурхай (“Mt Keith Nickel Mine, WA”), Олимпик Дам Зэс-Ураны уурхай (“Olympic Dam CopperUranium Mine, SA”), Мт Иса уурхайн цогцолбор ба Ст Ивэс алтны уурхай (“Mt Isa Mining complex, Qld” ба “St Ives Gold Mine, WA”)-н нэг хэсэг: Блэк Стар Цайрын ил уурхай (“Black Star Open cut zinc project”)-н геологийн багт ажиллаж байсан. Тэрээр 2007 онд Лайон Селекшн Групп-ийн хөрөнгө оруулалтын багт нэгдэж, хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагчтай харилцах чиглэлээр ажилласаар ирсэн. Лайон Селекшн Групп нь Австралийн Мельбурн хотод төвтэй, хөгжүүлэлтэд чиглэсэн уул уурхайн хөрөнгө оруулалтын сан бөгөөд энэхүү сан нь сүүлийн жилүүдэд Эрдэнэ Ресурсийн хувьцааг эзэмшиж байна. Хэдли нь Австрали улсад Мельбурнийн Их Сургуулийг геологич мэргэжлээр, хүндэт дипломтой төгссөн (2000) бөгөөд хэрэглээний санхүүгийн чиглэлээр магистрийн зэрэг хамгаалсан (2011). Тэрээр Лайон Селекшн Групп-д хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Лайон Менежер компанийн гүйцэтгэх захирал ба хувьцаа эзэмшигч юм. Хэдли нь Австралид бүртгэлтэй (“Plutonic Limited”) компанийн захирлаар ажилладаг.

**2022 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирц**

ТУЗ-ийн хурал	5 / 6	83%
Техникийн хорооны хурал	1 / 1	100%

**Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бусад хувьцаат компанийн ТУЗ-д ажилласан эсэх**

EganStreet Resources (ASX)  
Kasbah Resources Limited (ASX)

**2022 оны ХЭХ-ын санал хураалтын дүн**

	Дэмжсэн	Татгалзсан	Нийт
Саналын тоо #	120,313,323	24,500	120,337,823
Саналын хувь %	99.98%	0.02%	100.00%

**Эзэмшдэг хувьцааны тоо ширхэг, VaR үнэлгээ**

Огноо	Энгийн хувьцаа	ИОХЭ	Нийт үнэт цаас	Эрсдэл тооцсон үнэлгээ
2023.05.18	Nil	160,019	160,019	\$54,406
2022.05.19	Nil	127,150	127,150	\$48,953

Нэр дэвшиж буй ТУЗ-ийн гишүүдийн тухай мэдээлэл:

- 2022.05.19 болон 2023.05.18 өдрүүдээр өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоо ширхгийн тухай мэдээллийг Эрдэнэ Ресурс-д хамааралгүйгээр оруулсан.
- Энгийн хувьцаа, ИОХЭ-ийн зах зээлийн үнэлгээ нь 2023.05.18-нд нэгж тус бүр нь \$0.34, 2022.05.19-нд нэгж тус бүр нь \$0.385 буюу тухайн өдрүүдийн Торонтогийн Хөрөнгийн Биржийн хаалтын үнээр тооцоолсон.

### **Олонхын саналын бодлого**

Компани олонхын саналын бодлогыг ("Бодлого") батлан, хэрэгжүүлж эхэлсэн. Уг Бодлогод зааснаар ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь түүнийг дэмжсэн саналаас илүү олон тооны татгалзсан санал авсан тохиолдолд хурлын дараа ТУЗ-ийн даргад огцрох хүсэлтээ өгөх үүрэгтэй. Энэхүү Бодлогыг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн тоо нь сонгогдох гишүүний тоотой тэнцүү сонгуульд авч хэрэгжүүлнэ.

2022 оны 8-р сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр болсон Канадын Бизнесийн Байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дагуу хурлаар болон ирээдүйд өрсөлдөөнгүй сонгуульд ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо "дэмжсэн" эсвэл "эсрэг" гэсэн санал хураах болно. Ингэснээр Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгоход дээрх бодлого хамаарахгүй болно.

### **Үйл ажиллагаа зогсоох тогтоол, дампуурлын тухай**

Энэхүү танилцуулга гарах хугацаа болон түүнээс өмнөх 10 жилийн хугацаанд Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүү хариуцсан захирал нь:

- (i) үйл ажиллагаа зогсоох тогтоол, тушаал, эсвэл түүнтэй адилаар үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу 30 болон түүнээс дээш хоногоор компанийн үйл ажиллагааг зогсоох шийдвэр, тогтоолыг ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнууд хүлээн авч байгаагүй; эсвэл
- (ii) зогсоох тогтоол, тушаал, эсвэл түүнтэй адилаар үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу 30 болон түүнээс дээш хоногоор ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнуудыг компанийн үйл ажиллагаанд оролцох чадварыг зогсоох, хориглосон шийдвэр, тогтоолыг аливаа ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнууд хүлээн авч байгаагүй.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь:

- (i) энэхүү танилцуулга гарах хугацаанд болон түүнээс 10 жилийн өмнөх хугацаанд ажил үүргээ гүйцэтгэж буй хүрээнд дампуурал зарлах, төлбөрийн чадваргүйг зарлах эсвэл аливаа хууль тогтоомжийн хүрээнд тэдний хөрөнгийг хадгалахаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, зээл олгогч, хүлээн авагч, түүний менежертэй холбоотойгоор маргаан, хэлцэл болон зөвшилцлийг хийж байгаагүй; эсвэл
- (ii) энэхүү танилцуулга гарах хугацаанд болон түүнээс 10 жилийн өмнөх хугацаанд дампуурал зарлах, төлбөрийн чадваргүйг зарлах, эсвэл тэдний хөрөнгийг хадгалж буй итгэмжлэгдсэн төлөөлөгч, менежер, зээл олгогч, хүлээн авагчтай холбоотойгоор ямар нэгэн өргөдөл гомдол гарч байгаагүй.

### **Торгууль ба Шийтгэл**

Компаниас санал болгож буй гишүүд нь: (i) үнэт цаасны зохицуулагч байгууллагаас эсхүл үнэт цаасны хууль журамтай холбоотойгоор шүүхээс торгууль ба шийтгэл оногдуулаагүй, эсхүл (ii) санал болгож буй гишүүнд саналаа өгөх эсэхэд үнэт цаас эзэмшигчийн зүгээс шийдвэр гаргахад чухал гэж харгалзан авч үзэхүйц аливаа шүүхийн байгууллагаас оногдуулсан ямарваа нэгэн торгууль ба шийтгэлгүй этгээд байна.

## Аудиторыг томилох

Кэй Пи Эм Жи (“KPMG LLP”), мэргэшсэн нягтлан бодогчид нь компанийг үүсгэн байгуулагдсанаас хойш аудитораар ажиллаж байна. Удирдлагаас KPMG LLP-г дахин томилох саналтай байна. Хурлын үеэр Хувьцаа эзэмшигчдээс KPMG LLP-г ирэх жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл томилох, түүний урамшууллыг ТУЗ-өөс тогтоох санал гаргана.

**Санал өгч буй хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн төлөөлөгчид татгалзсан санал өгөх зааварчилгаа өгөөгүй бол, бүгд KPMG LLP-г аудитораар томилохын төлөө санал өгсөнд тооцогдоно. KPMG LLP-г Компанийн аудитораар томилон, баталгаажуулахын тулд өөрийн биеэр болон саналын хуудсаар оролцож байгаа Хувьцаа эзэмшигчдийн 50-аас дээш хувийн санал шаардлагатай.**

## Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр батлах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувьцаа эзэмшигчид болон Торонтогийн хөрөнгийн бирж (“TSX”)–ийн эцсийн зөвшөөрөл авснаар компанийн ТУЗ–ийн гишүүд, ажилчид, зөвлөхүүд болон охин компаниудын ТУЗ–ийн гишүүд, ажилчид, зөвлөхүүд (“хамтад нь **оролцогчид**”)–ийн урамшууллын хүрээнд хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр (“ХСУБХ”)–ийг батлахаар төлөвлөж байна. Хэрэв хөтөлбөр батлагдвал, энэхүү тайланд танилцуулж буй Опцион төлөвлөгөө болон ИОХЭ төлөвлөгөөг орлоно (“хамтад нь **Залгамж халааны төлөвлөгөө**”). Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг хувьцаа эзэмшигчид баталснаар Залгамж халааны төлөвлөгөөний дагуу урамшуулал ирээдүйд олгогдохгүй. Гэвч Залгамж халааны төлөвлөгөөг одоогоор олгогдсон, хэрэгжүүлэх боломжтой болон хэрэгжүүлэх явцад ашиглах зорилгоор үргэлжлүүлэн ашиглана. Төлөвлөгөөгөөр олгосон урамшууллын хэрэгжилт дуусгавар болоход Залгамж халааны төлөвлөгөө цаашид хүчин төгөлдөр бус болно.

Хурлаар Хувьцаа эзэмшигчид нь Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг батлаагүй тохиолдолд Залгамж халааны төлөвлөгөө нь хүчинтэй хэвээр байх бөгөөд хувьцаа эзэмшигчид Залгамж халааны төлөвлөгөөг орлох төлөвлөгөө эсвэл төлөвлөгөөнүүдийг батлах хүртэл Компани нь урамшууллыг Залгамж халааны төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэн олгоно.

## Хөтөлбөрийн тухай ба Зорилго

2023 оны 5 сарын 17-нд ТУЗ нь ХСУБХ-ийг хянан, хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталснаар хүчин төгөлдөр болох нөхцөлтэйгөөр шийдвэр гаргасан бөгөөд энэхүү хөтөлбөр нь Залгамж халааны төлөвлөгөөг орлоно. ХСУБХ нь доор заасан нөхцөлүүдийн дагуу опцион (“Опцион” буюу “Options”) хязгаарлалт бүхий хувьцааны нэгж (“ХБХН” буюу “RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг компани нь харьцангуй уян хатан байдлаар олгох боломжтой болно. ХСУБХ хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан тохиолдолд ирээдүйд олгогдох хувьцаанд суурилсан урамшуулал нь дээрх хөтөлбөрийн дагуу олгогдох бөгөөд Залгамж халааны төлөвлөгөөний дагуу хувьцаанд суурилсан урамшууллыг хурлын өдрөөр дуусгавар болгон, олгохгүй. Залгамж халааны төлөвлөгөө нь зөвхөн одоо хүчин төгөлдөр хувьцаанд суурилсан урамшууллын хувьд хүчин төгөлдөр хэвээр байна. Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон хувьцаанд суурилсан урамшуулал хэрэгжин, хугацаа дууссан тохиолдолд Залгамж халааны төлөвлөгөө хүчингүй болно.

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн зорилго нь компани болон түүний охин компаниудад буй чадварлаг ТУЗ–ийн гишүүд, Ажилтнууд ба Зөвлөхүүдийг татах, тэдгээрийг идэвхжүүлэх, урт хугацаанд хамтран ажиллах, компанийн урт хугацааны зорилго болон амжилтад оруулсан хувь нэмрийг нь ТУЗ–өөс тухай бүр үнэлж уг Хөтөлбөрийн дагуу урамшуулах, мөн тэдгээр ТУЗ–ийн гишүүд, Ажилтан ба Зөвлөхүүд хувьцаа эзэмших замаар урт хугацааны хөрөнгө оруулалт хийж, өмчийн эзэн болох боломжийг бүрдүүлэхэд оршин.

## **Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн үндсэн нөхцөлүүд**

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн нөхцөлүүдийн хураангуйг доор танилцуулав. Хөтөлбөртэй Хавсралт “А”-аас танилцана уу.

### **Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрт хамаарах хувьцаа**

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр нь тодорхой нөхцөлүүдийн дагуу (энгийн хувьцааг нэгтгэх, хуваах зэргийг багтаан) Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллыг багтаан урамшууллыг хэрэгжүүлэх, баталгаажуулах зэрэгт гаргаж болох энгийн хувьцааны дээд хэмжээг заасан эргэлтийн хөтөлбөр бөгөөд Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллыг оролцуулан, урамшууллын хүрээнд компанийн гаргах энгийн хувьцааны хэмжээ нийт гаргасан болон эргэлтэд байгаа хувьцааны 10%-иас ихгүй байна.

### **Орон тооны бус ТУЗ-ийн гишүүдийн оролцооны хязгаар ба урамшууллын хязгаарлалт**

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрт дараах тохиолдолд энгийн хувьцааны нийт тоо дор дурдсанаас хэтрэхгүй: (а) Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон урамшууллыг оруулаад компанийн үнэт цаасанд суурилсан төлбөрийн зохицуулалтын дагуу Дотоод мэдээлэл эзэмшигчид гаргах хувьцаа компанийн гаргасан энгийн хувьцааны арван хувь (10%) (b) Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон урамшууллыг оруулаад компанийн үнэт цаасанд суурилсан төлбөрийн зохицуулалтын дагуу Дотоод мэдээлэл эзэмшигчид аливаа нэг (1) жилийн хугацаанд гаргах хувьцаа компанийн гаргасан энгийн хувьцааны арван хувь (10%).

Түүнээс гадна, ХСУБХ нь компанийн ажилтан, зөвлөх бус (орон тооны бус) ТУЗ-ийн гишүүнд олгох урамшуулал нь хүчин төгөлдөр болсноор компанийн санхүүгийн нэг жилийн хугацаанд (i) орон тооны бус ТУЗ-ийн гишүүнд олгосон өдрийн опционы бодит үнэлгээ нь \$100,000 кан.доллараас хэтрэхгүй байх, (ii) орон тооны бус ТУЗ-ийн гишүүнд олгосон компанийн хувьцаанд суурилсан бүх урамшууллын (опционы бодит үнэ цэнийг оруулан) олгосон өдрийн бодит үнэлгээ нь \$150,000 кан.доллараас хэтрэхгүй байх боловч дараах тохиолдолд хамаарахгүй (а) бэлэн мөнгөн төлбөрийн оронд хүлээн авч буй урамшуулал ба (b) орон тооны бус ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-д ороход олгосон нэг удаагийн урамшуулал.

Аливаа худалдаж авсан компанийн хувьцаанд суурилсан бусад урамшуулал болон эргэлтэд буй хувьцааны опцион авах эсвэл орлох урамшуулал нь ХСУБХ-ийн хүрээнд гаргах боломжтой энгийн хувьцааны хэмжээг бууруулахгүй.

### **Хөтөлбөрийн удирдлага**

Хөтөлбөрийг Хөтөлбөрийн удирдагч удирдан зохицуулах бөгөөд анхлан ТУЗ тодорхойлно. Ирээдүйд хөтөлбөрийг ТУЗ удирдан зохион байгуулах, эсвэл холбогдох ТУЗ-ийн хороодод шилжүүлж болох бөгөөд энэхүү хороо нь Цалин урамшууллын хороо байна. Хөтөлбөрийн удирдагч нь хөтөлбөрийн дагуу урамшуулал олгох оролцогчдыг тодорхойлно, үүнд: урамшуулал олгох хугацаа, урамшуулал олгох эрхийг тодорхойлох, олгох хувьцааны нэгж тоо, олгогдох Урамшууллын дагуу гаргах энгийн хувьцаанд аливаа хориг, хязгаарлалтууд тавигдах эсэх болон хэрвээ тавигдах бол тухайн хориг, хязгаарлалтын шинж чанар зэрэг хүчин зүйлд үндэслэн Урамшууллыг эзэмших, хэрэгжүүлэх хугацааг урагшлуулах, эсхүл эрхээсээ татгалзах болон цуцлах нөхцөлүүд хамаарна.

Хөтөлбөрийн удирдагч нь хөтөлбөрийг тайлбарлах, холбоотой удирдамж болон бусад дүрэм, журмыг батлан бусад бүх шийдвэрүүдийг гаргах гэх арга хэмжээг авч ажиллана.

### **Оролцох эрх**

Бүх ТУЗ-ийн гишүүд, Ажилтнууд болон Зөвлөхүүд Хөтөлбөрт оролцох эрхтэй байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу Урамшуулал хүлээн авах эрхтэй аливаа ТУЗ-ийн гишүүн, Ажилтан, Зөвлөхийг зөвхөн Хөтөлбөрийн удирдагчийн шийдвэр, үзэмжид үндэслэн тодорхойлно.

## Урамшууллын төрлүүд

ХСУБХ-ийн дагуу Опцион, хязгаарлалт бүхий хувьцааны нэгж, гүйцэтгэлд уялдсан хувьцааны нэгж болон ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн урамшууллыг хэрэгжүүлж болно. Доор тайлбарласан бүх урамшуулал нь Хөтөлбөрийн удирдагчаас тодорхойлсон нөхцөл, хязгаарлалт, хэрэгжүүлэх үнэ, эрх, төлбөр тооцоо гэх нөхцөлд хамаарах бөгөөд дуусах хугацааг гэрээнд тусгаж болно. Мөн ХСУБХ-д заасан хязгаарлалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Хөтөлбөрийн удирдагч нь энгийн хувьцааны урамшуулал олгох, түргэсгэх, хойшлуулах, цуцлах, өөрчлөх болон тогтоосон нөхцөлөөс татгалзах боломжтой.

## Опцион

Опцион нь тухайн опцион эзэмшигч компаниас тодорхойлж гаргасан нөөцийн энгийн хувьцааг олгосон өдрийн ханшаар хэрэгжүүлэх эрхийг олгодог. Хөтөлбөрийн удирдагчийн сонголтоор урамшууллыг энгийн хувьцаа, бэлэн мөнгө эсвэл тэдгээрийн хослолоор олгож болно. Ашигтай дүнтэй (In-the-money amount) тэнцүү дүнгээр бэлэн мөнгөөр төлбөрийг хийх боломжтой (доор дурдав). Хөтөлбөрийн удирдагч нь опцион олгох үед хэрэгжүүлэх үнийг тодорхойлох бөгөөд хэрэгжүүлэх ханш нь олгосон өдрийн Торонтогийн хөрөнгийн бирж дэх энгийн хувьцааны арилжааны 5 өдрийн жигнэсэн дундаж ханш (**зах зээлийн үнэ**)-аас багагүй байна. ХСУБХ-ийн дагуу хугацааг хурдасгасан опционы дуусах хугацаа нь өөрчлөгдөхгүй. Хөтөлбөрийн удирдагч нь опционтой холбоотой эрх олгох нөхцөлүүдийг тодорхойлох эрхтэй. Опционы эрх олгогдсоноор Хөтөлбөрийн удирдагч өөрөөр заагаагүй тохиолдолд опционы хугацаа дуустал хэрэгжүүлэх боломжтой байна. Опцион олгох үед Хөтөлбөрийн удирдагч нь ХСУБХ-д зааснаар хязгаарлалтын нөхцөлүүдийг нэмэх боломжтой, тухайлбал тодорхой гүйцэтгэлд суурилсан эрх олгох нөхцөл зэрэг. ХСУБХ-өөр олгогдсон урамшууллын хугацааг тодорхой заагаагүй боловч дуусах хугацаа (хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авах эсвэл арилжаа царцаасан хугацаанд опционы хугацаа дууссан тохиолдолд хамаарахгүй) 5 жилээс багагүй байна.

Хөтөлбөрийн удирдагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрвээ Хөтөлбөрийн удирдагч зөвшөөрвөл Оролцогч нь Хэрэгжүүлэх мэдэгдлийг өгч Опционыг хэрэгжүүлэхийн оронд компанид тухайн Опционыг буцаан шилжүүлэн өгөхөөр (“**Бэлэн бусаар хэрэгжүүлэх**” буюу “**Cashless Exercise**”) сонгож болох ба (i) Опционыг (эсвэл түүний зарим хэсгийг) хэрэгжүүлэх өдрөөр тухайн Опцион (эсвэл түүний зарим хэсэг)-ыг хэрэгжүүлэхэд гаргах Хувьцааны зах зээлийн үнээс (ii) тухайн Хувьцаанд хамаарах буцаан шилжүүлэх өгөх Опционы (эсвэл түүний зарим хэсгийн) нийт Хэрэгжүүлэх үнийг хассан дүнтэй Ашигтай дүнг (“**Ашигтай дүнг**” буюу “**In-the-Money Amount**”) тэнцүү төлбөрийг компаниас авч болно. Оролцогч нь ийнхүү Бэлэн бусаар хэрэгжүүлэх талаарх мэдэгдлийг хэрэгжүүлэх Опционы тоо болон компаниас шаардсан бусад мэдээллийг оруулан компанид бичгээр гаргаж өгнө. 8.3 дахь хэсэгт заасныг харгалзан компани нь Ашигтай дүнг хэрэгжүүлэх өдрийн байдлаарх Хувьцааны үнээр хувааж тодорхойлсон тоо хэмжээ бүхий Хувьцааг (хамгийн ойрын бүхэл тоогоор илэрхийлсэн) Оролцогчид хүргүүлэн Ашигтай дүнг төлбөрийг төлнө.

## Хязгаарлалт бүхий хувьцааны нэгж

Хязгаарлалт бүхий хувьцааны нэгж (“ХБХН” буюу “RSU”) нь тодорхой эрх олгох хугацааны дараа компанийн бүртгэлд оруулсан энгийн хувьцаатай тэнцэх нэгжийг эзэмшигчид олгох энгийн хувьцаатай дүйцсэн нэгж юм. Хөтөлбөрийн удирдагч нь энэхүү ХСУБХ-ийн заалт, бусад нөхцөлийн дагуу ХБХН-ийг аливаа Оролцогчид татварын жилд тухайн Оролцогчийн үзүүлсэн үйлчилгээ (“ХБХН-ийн Үйлчилгээний Жил”)-тэй холбоотой урамшуулал болон түүнтэй ижил төстэй төлбөртэй холбогдуулан олгож болно.

ХСУБХ-ийн хүрээнд хэдийд ч олгосон ХБХН нь (a) Хөтөлбөрийн удирдагчийн тодорхойлсон ХБХН-ээр төлөх урамшуулал болон ижил төстэй төлбөрийн хэмжээ, (b) (i) олгогдсон өдрөөр энгийн хувьцааны зах зээлийн үнэ болон (ii) Хөтөлбөрийн удирдагчийн өөрийн үзэмжээр тодорхойлсон дүнгийн аль ихэд хувааж (бутархайг багтаан) тооцно. Хөтөлбөрийн удирдагч ХБХН-ын тооцоо хийх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд тухайн нөхцөл болзол нь АНУ-ын Татвар төлөгчийн талаарх 409А хэсэгт холбогдох байдлаар нийцсэн байна.

Төлбөр тооцоог хийсний дараа оролцогчид Хөтөлбөрийн удирдагчийн сонгон, баталснаар эрх бүхий ХБХН хүлээн авах эрхтэй: (a) бүрэн төлөгдсөн, дахин үнэлэгдэхгүй нэг энгийн хувьцаа, (b) бэлнээр төлбөр хийх, эсхүл (c) хувьцаа болон бэлэн төлбөрийн хослуулан олгох. Бэлнээр төлбөр тооцоог авах ХБХН-ийн хувьд



бэлнээр авах ХБХН-ийн тоог тооцоо хийх өдрийн Хувьцааны Зах зээлийн үнээр үржүүлж компаниас Оролцогчид төлөх аливаа бэлэн төлбөрийг тооцно.

Хөтөлбөрийн удирдагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ХБХН-ийн үйлчилгээний жилээс хойш гурав дахь хуанлийн жилийн сүүлийн Ажлын өдрөөс хойш ХБХН-тэй холбоотойгоор аливаа тооцоо хийх өдөр тохиохгүй, энгийн хувьцаа гаргахгүй бөгөөд бэлэн төлбөр төлөхгүй.

### **Гүйцэтгэлд Уялдсан Хувьцааны Нэгж**

Гүйцэтгэлд Уялдсан Хувьцааны Нэгж (“ГУХН” буюу “PSU”) нь компанийн нөөцийн бүртгэлд оруулан, гүйцэтгэлд суурилсан тодорхой шалгуурыг хангасны дүнд эзэмшигчид ГУХН нэгж тус бүрд нэг энгийн хувьцаа (эсвэл түүний үнэлгээтэй тэнцэх) авах эрх юм. Гүйцэтгэлийн зорилгыг хангах үүднээс зорилт, гүйцэтгэлийн мөчлөгийн хугацаа, ГУХН олгох хэмжээ, Оролцогчийн үйлчилгээг цуцалсны нөлөө болон ГУХН-ийн дагуу хийх төлбөр, шилжүүлгийн хэмжээг Хөтөлбөрийн удирдагч тодорхойлох бөгөөд эдгээрийн Урамшууллын Гэрээнд тусгана. Хөтөлбөрийн удирдагч энэхүү ХСУБХ-ийн заалт болон өөрийн шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл болзлын дагуу аливаа Оролцогчид татварын жилд тухайн Оролцогчийн үзүүлсэн үйлчилгээ (“**ГУХН-ийн Үйлчилгээний Жил**” буюу “**PSU Service Year**”)-тэй холбоотой урамшуулал болон түүнтэй ижил төстэй төлбөртэй холбогдуулан ГУХН-ийг тухай бүр олгож болно.

Төлбөр тооцоог хийсний дараа оролцогчид Хөтөлбөрийн удирдагчийн сонгон, баталснаар эрх бүхий ГУХН хүлээн авах эрхтэй: (а) бүрэн төлөгдсөн, дахин үнэлэгдэхгүй нэг энгийн хувьцаа, (б) бэлнээр төлбөр хийх, эсхүл (с) хувьцаа болон бэлэн төлбөрийн хослуулан олгох. Бэлнээр төлбөр тооцоог авах ГУХН-ийн хувьд бэлнээр авах ГУХН-ийн тоог тооцоо хийх өдрийн Хувьцааны Зах зээлийн үнээр үржүүлж компаниас Оролцогчид төлөх аливаа бэлэн төлбөрийг тооцно. Хөтөлбөрийн удирдагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ГУХН-ийн үйлчилгээний жилээс хойш гурав дахь хуанлийн жилийн сүүлийн Ажлын өдрөөс хойш ГУХН-тэй холбоотойгоор аливаа тооцоо хийх өдөр тохиохгүй, энгийн хувьцаа гаргахгүй бөгөөд бэлэн төлбөр төлөхгүй.

### **Ирээдүйд Олгогдох Хувьцааны Эрх**

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSU”) нь компанийн нөөцийн бүртгэлд оруулан, ирээдүйд олгох тодорхой шалгуурын дараа эзэмшигчид ИОХЭ тус бүрд нэг энгийн хувьцаа авах эрх юм. ТУЗ болон ТУЗ-ийн хороонд санхүүгийн жилд ажилласан ТУЗ-ийн гишүүнд олгох цалин урамшууллыг ТУЗ тодорхойлох бөгөөд нийт цалин урамшууллын тодорхой хэсгийг ИОХЭ-ээр төлөх боломжтой. ТУЗ-ийн гишүүн бүр ХСУБХ-ийн хүрээнд хүлээн авах ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллын тодорхой хэсгийг ИОХЭ-ийг хүлээн авах саналаа өгөх боломжтой. ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллын хүрээнд олгох ИОХЭ-ийн тоо хэмжээ (бутархай ИОХЭ багтаасан) (а) ИОХЭ-ээр төлөгдөж буй ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллын хэмжээ, (б) олгосон өдрийн энгийн хувьцааны зах зээлийн үнэлгээг хувааж тооцно. Хөтөлбөрийн удирдагч энэхүү ХСУБХ-ийн заалт болон өөрийн шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл болзлын дагуу аливаа Оролцогчид тухай бүр олгож болно.

Хөтөлбөрийн удирдагч ИОХЭ-ийг олгон эзэмшүүлэх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд олгосон ИОХЭ (ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллын тодорхой хэсэг болсон хэсгийг оролцуулан)-ийг олгомогц хүчин төгөлдөр болно.

Төлбөр тооцоог хийсний дараа оролцогчид Хөтөлбөрийн удирдагчийн сонгон, баталснаар эрх бүхий ИОХЭ хүлээн авах эрхтэй: (а) Нөөцөөс гаргасан бүрэн төлөгдсөн, дахин үнэлэгдэхгүй нэг энгийн хувьцаа, (б) бэлнээр төлбөр хийх, эсхүл (с) хувьцаа болон бэлэн төлбөрийн хослуулан олгох. Бэлнээр төлбөр тооцоог авах ИОХЭ-ийн хувьд бэлнээр авах ИОХЭ-ийн тоог тооцоо хийх өдрийн Хувьцааны Зах зээлийн үнээр үржүүлж компаниас Оролцогчид төлөх аливаа бэлэн төлбөрийг тооцно. Хөтөлбөрийн удирдагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ИОХЭ-ийн үйлчилгээний жилээс хойш нэг хуанлийн жилийн сүүлийн Ажлын өдрөөс хойш ИОХЭ-тэй холбоотойгоор аливаа тооцоо хийх өдөр тохиохгүй, энгийн хувьцаа гаргахгүй бөгөөд бэлэн төлбөр төлөхгүй.

### Ногдол ашигтай дүйцүүлэх

Хөтөлбөрийн удирдагч өөрөөр тодорхойлсноос бусад тохиолдолд ХБХН, ГУХН ба ИОХЭ-ийн Урамшуулал нь нэмэлт ХБХН, ГУХН ба ИОХЭ хэлбэрээр тухайн ХБХН, ГУХН ба ИОХЭ-д тооцогдох ногдол ашигтай дүйцүүлэх төлбөрийг Хувьцаанд төлөх энгийн бэлэн ногдол ашгийн төлбөрийн өдрөөр тооцон авах эрхийг багтаана. Тухайн ногдол ашигтай дүйцүүлэх төлбөрийг (а) Хувьцаа бүрд хуваарилан төлөх ногдол ашгийн дүнг ногдол ашиг төлөх бүртгэлийн өдрөөр Оролцогчийн эзэмшиж байгаа ХБХН, ГУХН ба ИОХЭ-ийн тоогоор үржүүлэх дүнг (b) ногдол ашиг төлөх өдрөөрх Зах зээлийн үнэд хувааж тооцох ба бутархайг хоёр оронгоор тасална.

### Арилжааг түр зогсоох үе

Хэрвээ арилжааг түр зогсоох үе үйлчилж байхад Урамшуулал дуусгавар болсон бол Урамшуулал дуусгавар болох хугацааг арилжааг түр зогсоох үе цуцлагдсан өдрийн дараах 10 ажлын өдрөөр сунгана.

### Хөдөлмөрийн Харилцаа эсвэл Үйлчилгээг Цуцлах

Хөтөлбөрийн удирдагч өөрөөр заагаагүй тохиолдолд ажлаас чөлөөлөгдөх, шалтгаангүйгээр халагдах, хөгжлийн бэрхшээл, нас барах, тэтгэвэрт гарах зэрэг явдлууд Оролцогчдод үзүүлэх нөлөөллийг хүснэгтэд харуулав:

<b>Хөдөлмөрийн гэрээг сайн дураар цуцалсан (ТУЗ-ийн гишүүн багтахгүй)</b>	Оролцогчийн Цуцлах өдрөөр хэрэгжүүлээгүй, буцаан шилжүүлэн өгөөгүй, тооцоо хийгээгүй Опцион ба бусад Урамшуулал нь, эзэмшүүлсэн эсэхээс үл хамааран, Цуцлах өдрөөр даруй хураагдаж, хүчингүй болно.
<b>Хөдөлмөрийн гэрээг шалтгаангүйгээр цуцалсан (ТУЗ-ийн гишүүн багтахгүй)</b>	Эзэмшүүлээгүй байгаа бүх Опцион ба бусад Урамшуулал нь Цуцлах өдрөөр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (а) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (b) Цуцлах өдрөөс хойш 90 хоногийн дараах өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Хэрвээ дээрх өгүүлбэрийн (а) ба (b)-д заасны аль өмнө тохисон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд Цуцлах өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд тооцоо хийх сүүлийн өдрийг баримтална.
<b>Хөгжлийн бэрхшээл</b>	Цуцлах өдрөөр Оролцогчид эзэмшүүлээгүй байгаа Оролцогчийн аливаа Урамшууллыг тухайн өдөр эзэмшүүлнэ. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (а) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (b) Цуцлах өдрөөс хойш эхний жил тохиох өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд Цуцлах өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд тооцоо хийх сүүлийн өдрийг баримтална.
<b>Нас барсан</b>	Нас барсан өдрөөр Оролцогчид эзэмшүүлээгүй байгаа Оролцогчийн аливаа Урамшууллыг тухайн өдөр эзэмшүүлнэ. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогчийн өв залгамжлагч буюу хуулийн дагуух төлөөлөгч нь (а) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (b) нас барсан өдрөөс хойш эхний жил тохиох өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Хэрвээ дээрх өгүүлбэрийн (а) ба (b)-д заасны аль өмнө тохисон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд нас барсан өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог Оролцогчийн өв залгамжлагч буюу хуулийн дагуух төлөөлөгчтэй хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд тооцоо хийх сүүлийн өдрийг баримтална.

<p><b>Тэтгэвэрт гарсан</b></p>	<p>(i) Оролцогчийн компани, охин компанид үргэлжлүүлэн үзүүлэх үйлчилгээнд үндэслэн эзэмшүүлэх, эсхүл хэрэгжүүлж болохуйц болох аливаа Урамшууллыг Оролцогчийн Цуцлах өдрөөр эзэмшүүлэх ба (ii) өмнө нь эзэмшүүлээгүй байгаа бөгөөд Гүйцэтгэлийн зорилтыг хангаснаар эзэмшүүлэх аливаа Урамшууллыг тухайн Гүйцэтгэлийн зорилтыг бодитоор хангаснаар эзэмших эрх нь үргэлжилнэ. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (a) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (b) Цуцлах өдрөөс хойш 90 хоногийн дараах өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Хэрвээ дээрх өгүүлбэрийн (a) ба (b)-д заасны аль өмнө тохиосон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Дээрх (i)-д заасны дагуу эзэмшүүлсэн Урамшууллын хувьд (Опционоос бусад) Оролцогч тэтгэвэрт гарсан өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд тооцоо хийх сүүлийн өдрийг баримтална. Дээрх (ii)-д заасны дагуу эзэмшүүлсэн Урамшууллын хувьд (Опционоос бусад) Оролцогч компани болон охин компанид үйлчилгээ үзүүлсэн хэвээр байсан бол тооцоо хийх байсантай адил хугацаанд тухайн Урамшууллын тооцоог хийнэ.</p>
<p><b>Нас барсан, Хөгжлийн бэрхшээлтэй болсон, эсхүл Тэтгэвэрт гарснаас бусад шалтгаан</b></p>	<p>(i) бүх эзэмшүүлээгүй Урамшуулал Цуцлах өдрөөр нэн даруй хураагдаж, хүчингүй болно, (ii) эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (a) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (b) Цуцлах өдрөөс хойш 90 хоногийн дараах өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болох ба эсхүл дээрх өгүүлбэрийн (a) ба (b)-д заасны аль өмнө тохиосон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болох ба (iii) Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд Цуцлах өдрийн дараа 90 хоногийн дотор тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд тооцоо хийх сүүлийн өдрийг баримтална.</p>

### Хяналт өөрчлөгдөх

Хөтөлбөрийн удирдагчийн зөвшөөрлөөр Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд:

- (a) Хяналт өөрчлөгдөхтэй холбоотойгоор, гэхдээ энэхүү Хөтөлбөр болон Урамшууллын гэрээнд өөрөөр заасныг үл харгалзан Хөтөлбөрийн удирдагч нь Оролцогчийн зөвшөөрөлгүйгээр шаардлагатай гэж үзсэн аливаа арга хэмжээг авч болох ба үүнд дараах орно: (i) аливаа олгосон Урамшууллыг Хяналт өөрчлөгдөхөд оролцсон, эсхүл үүнээс үүдэн бий болсон этгээдийн адил үнэлгээ бүхий бусад үнэт цаас, эрхэнд Хөтөлбөрийн удирдагч үзэмжээрээ тодорхойлсноор шилжүүлэх, солих, (ii) Хяналт өөрчлөгдөх үйл явдал болмогц, эсхүл болохоос өмнө олгосон Урамшууллыг бүхэлд нь болон хэсэгчлэн эзэмшүүлэх, хэрэгжүүлэх, төлөх, түүнтэй холбоотой хязгаарлалтыг хүчингүй болгох болон Хөтөлбөрийг удирдагчийн тодорхойлсноор тухайн Хяналт өөрчлөгдөх үйл явдал болмогц, эсхүл болохоос өмнө Урамшууллыг цуцлах, (iii) хэлцэл хийх өдрийн байдлаарх Урамшууллыг хэрэгжүүлж, тооцоо хийх, Оролцогчийн эрхийг хэрэгжүүлэхэд авах дүнтэй тэнцүү дүнгээр тооцон Урамшууллыг цуцалж бэлнээр, эсхүл хөрөнгөөр төлөх (эргэлзээ төрүүлэхгүйн үүднээс, хэрвээ хэлцэл хийх өдрөөр Урамшууллыг хэрэгжүүлж, тооцоо хийх, Оролцогчийн эрхийг хэрэгжүүлэхэд төлбөр авах нөхцөл үүсээгүй гэж Хөтөлбөрийн удирдагч шударгаар үзсэн тохиолдолд Урамшууллыг аливаа нөхөн төлбөргүйгээр цуцалж болно), (iv) эзэмшигчид сөргөөр нөлөөлөхгүй бол ТУЗ-ийн үзэмжээр сонгосон бусад эрх, хөрөнгөөр тухайн Урамшууллыг солих, эсхүл (v) Дээрх арга хэмжээг хослуулан авах.
- (b) Компани, охин компани болон Оролцогчийн хооронд бичгээр байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Хяналт өөрчлөх үр дагавартай хэлцэл хийснээс хойш 12 сарын дотор хэрвээ Оролцогчийн хөдөлмөр эрхлэлт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон ТУЗ-ийн гишүүнээр ажиллахыг Шалтгаангүйгээр компани, охин компани цуцалсан бол:
  - (i) Цуцлах өдрөөр Оролцогчийн эзэмшээгүй байгаа аливаа Урамшууллыг нэн даруй эзэмшүүлэх, ба
  - (ii) Оролцогчийн эзэмшиж байгаа аливаа Урамшууллыг (a) тухайн Урамшууллын дуусгавар болох өдөр эсхүл (b) Цуцлах өдрөөс хойш 90 дэх хоногийн аль түүрүүлж тохиосон хугацааны дотор Оролцогч нь хэрэгжүүлэх, буцаан шилжүүлэх болон тооцоо хийж болно.

- (с) Хөтөлбөрийн удирдагч өөрөөр тодорхойсноос бусад тохиолдолд хэрвээ Хяналт өөрчлөх үйл явдлаас шалтгаалан Хувьцааг Торонтогийн хөрөнгийн биржид арилжаалахаа больсон бол компани нь Хяналт өөрчлөх хэлцэл хүчин төгөлдөр болох үед энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг бүхэлд нь буюу хэсэгчлэн цуцлах ба ингэхдээ Хяналт өөрчлөх хэлцэл хүчин төгөлдөр болсны дараа боломжит хугацаанд Хөтөлбөрийн удирдагчийн тодорхойлсон дүн буюу тухайн Оролцогчийн эзэмшиж байгаа Урамшууллын зах зээлийн бодит үнэлгээтэй тэнцүү дүнгээр төлбөр төлнө. АНУ-ын Татвар төлөгчид олгосон Урамшууллын тооцоог Хяналт өөрчлөх үйл явдал болсноос хойг 90 хоногийн дотор хийнэ.

Хяналт өөрчлөгдөх гэдэгт: (а) гаргасан саналын эрхтэй энгийн хувьцааны 50-аас дээш хувийг хувь хүн болон бүлэг этгээд авах аливаа хэлцэл, (b) Компанийн хөрөнгийг бүхлээр нь эсхүл хөрөнгийн дийлэнхийг худалдах, (с) Компанийг татан буулгах, (d) Компанийг нэгтгэх, нийлүүлэх, хувьцаа солилцох, хөрөнгийг худалдах, хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулах болон бусад байдлаар аливаа этгээд худалдан авах хэлцэл, (e) ТУЗ-ийн гишүүдийг бүрдүүлж буй хувь хүмүүс (“**Эрх бүхий ТУЗ**”) ТУЗ-ийн олонхыг бүрдүүлэхээ аливаа шалтгаанаар больсон. Хэрвээ шинэ гишүүнийг томилох, эсхүл томилохоор Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн гишүүнийг Эрх бүхий ТУЗ-ийн дийлэнхийн саналаар баталсан бол шинэ гишүүнийг Эрх бүхий ТУЗ-ийн гишүүн гэж үзэх, (f) ТУЗ-аас Компанийн хяналтын өөрчлөлт гэж тодорхойлон үзсэн аливаа бусад үйл явдлуудыг багтаана.

### **Урамшууллыг шилжүүлэхгүй байх**

Хөтөлбөрийн удирдагч зөвшөөрсөн, эсхүл Оролцогч нас барснаар гэрээслэлээр болон хуулиар өв залгамжлагчид зарим эрх тодорхой хэмжээгээр шилжиж болохоос бусад тохиолдолд сайн дураараа болон хуулиар шаардсан эсэхээс үл хамааран Урамшууллыг аливаа байдлаар шилжүүлэхгүй ба шилжүүлэн авагч ямар нэг байдлаар тухайн Урамшууллын аливаа эрхийг хэрэгжүүлэхээр оролдвол тухайн шилжүүлэг хиймэгц, эсхүл оролдмогц Урамшуулал цуцлагдаж, хүчин төгөлдөр биш болно. Оролцогч нас барснаар өв залгамжлагчид зарим эрх тодорхой хэмжээгээр шилжсэн бол тухайн өв залгамжлагч Урамшууллыг хэрэгжүүлэх хугацаа Оролцогчийн нас барснаас хойш нэг жилээс хэтрэхгүй.

### **Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах**

Хөтөлбөрийн удирдагч өөрийн үзэмжээр хэрвээ шаардлагатай гэж үзвэл Компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж, зөвшөөрөл авахгүйгээр энэхүү Хөтөлбөр болон Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг өөрчлөх, нэмэлт оруулах, солих, түдгэлзүүлэх болон цуцалж болно (а) Хөтөлбөрийн удирдагч Үнэт цаасны тухай хууль тогтоомж, Хөрөнгийн биржийн шаардлагыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд Хөтөлбөр болон түүний дагуу олгосон Урамшууллыг өөрчлөх, нэмэх, түдгэлзүүлэх болон цуцлах нь Оролцогчийн эрх ашгийг ноцтой хөндөхгүй бөгөөд Оролцогчийн зөвшөөрөлгүйгээр түүний үүргийг ноцтой нэмэгдүүлэх ёсгүй, (b) АНУ-ын Төлөгчийн эзэмшиж байгаа Урамшууллыг өөрчилснөөр Дотоод орлогын хуулийн 409А хэсэгт заасан орлогод хамаарах болбол тухайн өөрчлөлт нь АНУ-ын Татвар төлөгчийн зөвшөөрлийг авахаас бусад тохиолдолд эхнээсээ хүчин төгөлдөр бус гэж тооцогдоно.

Дээр дурдсанаас үл хамааран Торонтогийн хөрөнгийн биржийн дүрмийн дагуу Хөтөлбөрт дараах нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөл шаардлагатай:

- (a) Компани ба түүний хөрөнгөд нөлөөлөх хэлцэл хийх үед зохих өөрчлөлтийг Хөтөлбөрийн удирдагч хийж болохыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд Хөтөлбөрийн дагуу гаргахаар хадгалсан Хувьцааны тоог өсгөх;
- (b) Дотоод мэдээлэл эзэмшигчид гаргасан буюу гаргах Хувьцааны хувь хэмжээний хязгаарлалтыг өсгөх, эсхүл хасах;
- (c) Компани ба түүний хөрөнгөд нөлөөлөх хэлцэл хийх үед зохих өөрчлөлтийг Хөтөлбөрийн удирдагч хийж болохыг Хөтөлбөрийн заалтуудын дагуу зөвшөөрснөөс бусад тохиолдолд Дотоод мэдээлэл эзэмшигчийн эзэмшиж буй Опционы Урамшууллыг хэрэгжүүлэх үнийг багасгах;
- (d) Дотоод мэдээлэл эзэмшигчийн эзэмшиж буй Опционы хугацааг анхны дуусгавар болох өдрөөс хойш сунгах, болон
- (e) Өөрчлөлт оруулах.

Дээр дурдсанаас бусад тохиолдолд Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулахдаа Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл авах шаардлагагүй. Үүнд дараах зүйлс орно (үүгээр хязгаарлагдахгүй): (a) Урамшуулал тус бүрийг эзэмшүүлэх ерөнхий заалтуудад өөрчлөлт оруулах, (b) Ажил, үйлчилгээгээ дуусгавар болгосонтой холбогдуулан урамшууллыг хугацаанаас нь өмнө цуцлах тухай заалтад өөрчлөлт оруулах, (c) Оролцогчдыг хамгаалах тухай компанийн гэрээнд нэмэлт оруулах, (d) Олон улсын оролцогчдын талаар нэмэлт, өөрчлөлт оруулах, (e) Оролцогчийн оршин суугаа аль ч улсын хууль тогтоомжийн өөрчлөлтийн үр дүнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүд, (f) Аливаа тодорхой бус байдал, доголдол, үл нийцэх заалт, бичиг хэргийн дутагдал, алдааг арилгах, засах нэмэлт өөрчлөлтүүд, (g) Холбогдох хууль тогтоомж эсвэл Торонтогийн хөрөнгийн биржийн дүрэм, бодлогын дагуу Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл шаарддаггүй үндсэн болон бусад аливаа нэмэлт өөрчлөлт.

### **Хэджингийн эсрэг бодлого**

Урамшууллыг хүлээн авснаар Оролцогч бүр Урамшууллын зах зээлийн үнэ цэнийг бууруулах урьдчилан төлсөн хувьсах форвард гэрээ, хувьцааны своп, зах зээл, эсвэл солилцооны сангийн нэгж зэрэг санхүүгийн хэрэгслийг худалдан авах эрх хязгаарлагдахыг хүлээн зөвшөөрсөн болно.

### **Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг баталгаажуулах**

Торонтогийн хөрөнгийн бирж нь хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авснаар ХСУБХ-ийг батлах зөвшөөрлийг өгсөн. ХЭХ-аар хувьцаа эзэмшигчдээс Хавсралт В-д хавсаргасан “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр”-ийн тогтоолыг батлах.

Саналын хуудсанд тогтоолыг батлахаас эсрэг санал өгөхийг зааварчлаагүй тохиолдолд хүлээн авсан бүх итгэмжлэл нь ХСУБХ-ийг баталгаажуулахын төлөө санал өгсөнд тооцно. ХСУБХ-ийг баталгаажуулахад биечлэн оролцсон болон эчнээ санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 50%-иас дээш санал авсан байх шаардлагатай.

### **Компанийн Хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн батлах**

Компани нь 2008 оны 3-р сарын 14-нд Компьютершэйр Инвестор Сервисез Инк (“Computershare Investor Services Inc”) (“Эрхийн төлөөлөгч”)-тэй хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөг (“Эрхийн төлөвлөгөө”) боловсруулж, баталсан бөгөөд энэхүү хэлэлцээрийг 2011 оны 6-р сарын 23-нд, 2014 оны 6-р сарын 19-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн 2017 оны 6-р сарын 14-нд хэлэлцээрт өөрчлөлт оруулсан. ХЭХ-аар Компани нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрхийн төлөвлөгөөний хэлэлцээрийг үргэлжлүүлэх батлахаар санал авч байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрхийн төлөвлөгөөний хэлэлцээрийн үндсэн зорилго: (i) Энгийн хувьцаа эзэмшигчид болон ТУЗ нь энгийн хувьцааны хувьд гаргасан үнийн саналыг үнэлэх, үнэлэхтэй холбоотой хангалттай цаг хугацаатай байх; (ii) үнийн саналтай холбоотойгоор ТУЗ-д үнэ цэнийг үнэлэх, үнэ цэнийг нэмэгдүүлэх хувилбаруудыг боловсруулах хангалттай хугацаа олгох; (iii) энгийн хувьцааг худалдан авахтай холбоотой аливаа тендерт хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, шударга байдлыг дэмжиж ажиллах; (iv) хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд ТУЗ-д дэмжлэг үзүүлэх; (v) Канад Улсын компанийн хувьцааны хяналтыг багцыг эзэмших, худалдан авах дүрэм журамтай нийцэж байгааг баталгаажуулах багтана.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрхийн төлөвлөгөөний хэлэлцээр нь боломжит худалдан авагчийг Канад улсын тендер, худалдан авалтын журмын дагуу буюу тендер нь шударга, ТУЗ-ийн зөвшөөрлийг авсан байх зэрэг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тодорхой стандартуудыг хангасан байхыг шаарддаг. Энэхүү зөвшөөрөгдсөн тендер нь холбогдох үнэт цаасны тухай хууль тогтоомж болон бусад нөхцөл шаардлагын дагуу боловсруулсан тендерийн материал байх шаардлагатай бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулж, баталгаажуулсан эрхийн төлөвлөгөөнд заасан хамгийн богино хугацааны турш нээлттэй байх шаардлагатай.

Хэрэв тендер нь зөвшөөрөлтэй тендерийн шаардлагыг хангаагүй, эсвэл олон нийтэд арилжаалагдаж буй нийт энгийн хувьцааны 20% болон түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд хувьцаа эзэмшигч тодорхой хөнгөлөлтийн хүрээнд эрхээ хэрэгжүүлэн, нэмэлт энгийн хувьцааг зах зээлийн үнээс хямдралтай үнээр худалдан авах эрх үүснэ. Үр дүнд, эрхийн дийлэнх хэсгийг хэрэгжүүлсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн



хөрөнгө оруулалт, худалдан авалт хийж буй хөрөнгө оруулагчийн хувь хэмжээ их хэмжээгээр хорогдох боломжтой.

Энэхүү хураангуйг нэмэлт өөрчлөлт оруулж, баталгаажуулсан хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөнд үндэслэн тодорхойлсон. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрхийн төлөвлөгөөний хэлэлцээрийн хуулбарыг SEDAR дахь компанийн хуудас, эсвэл Компанийн хаягаар: Нова Скошиа, Вайс Роуд 99, 1480 тоот, утас: (902) 423-6419, email: info@erdene.com зэрэгт хүсэлт гарган хүлээн авах боломжтой.

## **Хувьцаа эзэмшигчид эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн мөрдөхийг батлах**

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөг ХЭХ-аар үргэлжлүүлэн мөрдөхөөр батлаагүй тохиолдолд ХЭХ зохион байгуулагдсан өдрөөр хугацаа дуусна. Эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг Торонтогийн Хөрөнгийн Бирж нь ХЭХ-аар батлуулах болон бусад стандарт шаардлагад нийцүүлэх нөхцөлтэйгөөр зөвшөөрсөн.

ХЭХ-аар хувьцаа эзэмшигчдээс санал хурааж, дараах тогтоолын (“Хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөний хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай тогтоол”) төслийн дагуу батална:

### **ДАРААХ ЕРӨНХИЙ ТОГТООЛЫГ ГАРГАХ НЬ:**

1. Компани нь 2017 оны 6-р сарын 14-нд Компьютершэйр Инвестор Сервисез Инк (“Computershare Investor Services Inc”) (“Эрхийн төлөөлөгч”)-тэй хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөний хэлэлцээрийг (“Эрхийн төлөвлөгөө”) боловсруулж, баталсныг үргэлжлүүлэн мөрдөж, дахин баталж баталгаажуулах;
2. Компанийн ажилтанд эрхийн төлөвлөгөөг хүчин төгөлдөр хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа баримт бичиг, гэрээ, зөвшөөрөл, сонгууль эсвэл бусад хэрэгслүүдийг тохиролцох, эцэслэх, гүйцэтгэх, хүргэх болон цаашдын бүх үйл ажиллагааг гүйцэтгэх эрхийг олгож, үүгээр албан тушаалтан нь аливаа гэрээ, баримт бичиг, зөвшөөрөл, сонгууль эсвэл бусад хэрэгслүүдийг тохиролцох, арга хэмжээ авах зэрэгт итгэмжлэн, баталж байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүд хувьцаа эзэмшигчдийг одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн батлахыг зөвлөж байна. Хэрэв саналын хуудасны эрхийн төлөвлөгөөг батлахын эсрэг санал өгөх заавар агуулаагүй тохиолдолд санал нь эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн баталж буй саналд тооцогдоно. Эрхийн төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр болон саналын хуудсаар өгч, нийт саналын 50%-иас дээш хувийг авснаар батална. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөний хэлэлцээр батлагдаагүй тохиолдолд одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрхийн төлөвлөгөө цуцлагдан, түүний дагуу олгогдсон эрх хүчингүй болно.

## **ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ**

### **Цалин урамшууллын талаар хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ**

#### **Нэр бүхий гүйцэтгэх албан тушаалтан**

Холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу Компани нь дараах “нэр бүхий гүйцэтгэх албан тушаалтан”-уудын цалин урамшууллын хэмжээг тайлагнах ёстой:

- (a) Гүйцэтгэх захирал;
- (b) Санхүү хариуцсан захирал;
- (c) Хамгийн сүүлд дууссан санхүүгийн жилийн байдлаар тухайн санхүүгийн жилд \$150,000-аас дээш цалин авсан Гүйцэтгэх захирал ба Санхүү хариуцсан захирлаас бусад гурван хамгийн өндөр цалинтай гүйцэтгэх албан тушаалтнууд, эсхүл ойролцоо албан тушаал хашиж буй хувь хүн; мөн



- (d) Дээрх (c) хэсэгт зааснаар нэр бүхий гүйцэтгэх албан тушаалтан боловч тухайн санхүүгийн жилийн эцсийн байдлаар Компанийн гүйцэтгэх албан тушаал, эсхүл түүнтэй төстэй албан тушаал хашиж байгаагүй хувь хүн.

2022 оны 12-р сарын 31-нээр дууссан санхүүгийн жилд Компанид дөрвөн Нэр бүхий гүйцэтгэх албан тушаалтан хамгийн өндөр цалин урамшуулал авсан, үүнд: Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал (“Гүйцэтгэх захирал”), Дэд ерөнхийлөгч ба Санхүү хариуцсан захирал (“Санхүү хариуцсан захирал”), Хайгуул хариуцсан дэд ерөнхийлөгч болон Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгч (нийтэд нь “Удирдлага” гэх) багтаж байна.

### **Цалин урамшууллын хорооны үүрэг**

Компанийн Цалин урамшууллын хороо (“Цалин урамшууллын хороо”) нь Гүйцэтгэх захирал болон бусад гүйцэтгэх албан тушаалтнуудын цалин урамшууллын багцыг хянах, түүнчлэн өөрчлөх саналыг ТУЗ-д гаргана. Цалин урамшууллын хороо нь санал гаргахдаа тухайн хувь хүний ажлын гүйцэтгэл, өөр бусад компаниуд ахлах албан тушаалтандаа өгч байгаа цалин урамшуулал, хувьцааны урамшуулал зэргийг харгалзаж үзнэ. Цалин урамшууллын хороо нь бусад гүйцэтгэх ажилтнуудын цалинг хянахдаа өдөр тутам тэдэнтэй харилцаж ажилладаг Гүйцэтгэх захирлаас санал бодлыг нь авахыг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн Цалин урамшууллын хороо нь Зөвлөлөөр батлуулахаар хүсэлт гаргасан Компанийн хувьцааны опционы төлөвлөгөө ба бусад үнэт цаасны урамшуулал олгохтой холбоотой аливаа саналыг хянах үүрэгтэй.

Цалин урамшууллын хороо нь одоогийн байдлаар Кеннет МакДоналд (Хорооны дарга), Дэвид Мошер ба Хедли Виддап нараас бүрдэх ба эдгээр гишүүд нь NI-58-101 Компанийн засаглалын үйл ажиллагааны ил тод байдлын стандартаар хараат бус гэж үзнэ. Цалин урамшууллын хорооны гишүүд бүгд салбартаа 25-аас дээш жил ажилласан туршлагатай бөгөөд өмнө нь ажиллаж байсан байгууллагадаа цалин урамшууллын бодлогыг хянах ба хэрэгжүүлэхэд гар бие оролцож байсан туршлагатай. Гишүүд нь уул уурхайн салбартай шууд холбоотой олон нийтийн байгууллага болон хувийн компаниудад нэр хүнд бүхий өндөр албан тушаал хашиж байсан.

### **Зах зээлийн харьцуулсан судалгаа**

Нэр бүхий гүйцэтгэх албан тушаалтнуудын цалин урамшууллын саналыг гаргахдаа Цалин урамшууллын хороо нь Компанитай ижил төстэй, харьцуулж болохуйц компаниудын гүйцэтгэх захирал болон удирдах албан тушаалтнуудын цалин урамшууллыг харьцуулж, судалж үзнэ. Харьцуулалт хийх байгууллагуудыг (“Ижил төстэй компаниуд”) ерөнхий салбарын хувьд ижил (хайгуул болон хөгжүүлэлтийн салбар), олон нийтэд үнэт цаасыг гарган арилждаг болон зах зээлийн үнэ цэн болон үйл ажиллагааны цар хүрээний хувьд төстэй компаниудаас сонгон судална.

2020 онд удирдлагаас Ascot Resources Ltd., Bluestones Resources Inc., Filo Mining Corp., Gold Standard Ventures Corp., Kincora Copper Ltd., Liberty Gold Corp., Marathon Gold Corp., Midas Gold Corp., Nighthawk Gold Corp., Orezone Gold Corp., Pure Gold Mining Inc., Steppe Gold Ltd., Wallbridge Mining Company Ltd and Xanadu Mines Ltd. судалгаа хийсэн. 2021 онд удирдлага: Ascot Resources Ltd., Bluestones Resources Inc., Entrée Resources Ltd., Gold Standard Ventures Corp., Kincora Copper Ltd., Liberty Gold Corp., Marathon Gold Corp., Orezone Gold Corp., Pure Gold Mining Inc., Sabina Gold & Silver Corp., Steppe Gold Ltd., Wallbridge Mining Company Ltd and Xanadu Mines Ltd. компаниуд багтсан. 2022 онд ижил төстэй компаниудад: Ascot Resources Ltd., Bluestones Resources Inc., Entrée Resources Ltd., Gold Standard Ventures Corp., Kincora Copper Ltd., Liberty Gold Corp., Marathon Gold Corp., Orezone Gold Corp., Pure Gold Mining Inc., Sabina Gold & Silver Corp., Steppe Gold Ltd., Wallbridge Mining Company Ltd and Xanadu Mines Ltd. зэрэг компаниуд багтан, нэг бүлэг болгож цалингийн судалгаа хийсэн

Хэдийгээр ижил төстэй компаниудын өнгөрсөн цаг үеийн жишиг харьцуулалт боловч цаашид үргэлжлүүлэн судалгаа хийх ба нийт цалин урамшууллыг тодорхойлох хүчин зүйл, болон бусад зах зээлийн бодит байдлын хүчин зүйлүүд, мөн санхүүгийн боломжтой байдал зэргийг харгалзан үзэх болно.

**Мөнгөн тэмдэгт**

Энэ танилцуулгад байгаа "\$" буюу "доллар" нь өөрөөр заагаагүй бол Канад долларыг илэрхийлнэ.

**Цалин урамшууллын хөтөлбөрийн зорилго**

Эрдэнэ Ресурсийн удирдах ажилтны цалин урамшууллын хөтөлбөр нь шилдэг, авьяаслаг гүйцэтгэх ажилтнуудын хүсэл сонирхлыг татах, тогтвортой ажиллуулах, урам зориг өгснөөр зохих эрсдэлийг үүрэх боловч ёс зүйтэйгээр Компанийн бизнесийн зорилго ба зорилгод хүрэхийн төлөө зохиогдсон болно. Компанийн цалин урамшууллын хөтөлбөрийн үндсэн зорилго бол:

- (i) Эрдэс баялгийн салбарт Эрдэнэ Ресурстай ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувьд өрсөлдөхүйц цалин урамшууллыг олгох;
- (ii) Компанийн амжилт ба санхүүд онцгой ач холбогдолтой удирдах ажилтнуудын хүсэл сонирхлыг татах, урам зориг өгөх, тогтвортой ажиллуулах;
- (iii) Амжилт бүтээлийг хувь хүний өөрийн амжилт ба Компанийн үйл ажиллагаа ба санхүүгийн зорилгод тулгуурлан урамшууллын мөнгөн дүнг өөр өөрөөр тогтоох;
- (iv) Удирдлагын ашиг сонирхол Хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны ашиг сонирхолтой нийцэж байх;
- (v) Нийт цалин урамшууллын багцыг Компанийн хөгжлийн өнөөгийн үе шат ба санхүүгийн эх үүсвэр нөөц бололцоог харгалзаж тогтоосон байх.

**Удирдах ажилтны цалин урамшууллын хөтөлбөрийн элемент**

Компанийн удирдах ажилтны цалин урамшууллын хөтөлбөр нь гүйцэтгэлд тулгуурласан бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолтой нийцэхүйц бүтэцтэй байна. Эрдэнэ Ресурсийн цалин урамшуулал дараах зургаан элементээс бүрдэнэ: (i) үндсэн цалин; (ii) жилийн эцсийн бонус; (iii) хувьцааны опцион; (iv) Ирээдүйд олгогдох хувьцааны эрх; (v) тэтгэмжүүд; мөн (vi) мөнгөн урамшуулал. Цалин урамшууллын элементүүдийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй тайлбарласан.

Components	Element	Form	Period	Program Objectives and Details
<b>ТОГТМОЛ</b>	Үндсэн цалин	Мөнгөн	Жилээр	Удирдах ажилтны хариуцлагын түвшин, туршлага, зах зээлд өрсөлдөхүйц байдал, мөн ерөнхий гүйцэтгэлийг харгалзана
	Богино хугацаат үнэт цаас	Мөнгөн	Жилээр	Урьдчилан тодорхойлсон санхүүгийн болон үйл ажиллагааны тавьсан зорилтуудад хүрсэнтэй холбогдуулна
	Урт хугацаат үнэт цаас	Опцион	Урт хугацаат	Хувьцаа эзэмшигчийн нийт үнэ цэнийг өсгөснийг дэмжиж урамшуулна.
<b>ХУВЬСАХ</b>	Урт хугацаат үнэт цаас	ХХН	Урт хугацаат	Хувьцаа эзэмшигчийн нийт үнэ цэнийг өсгөснийг дэмжиж урамшуулна.
	Тэтгэмж	Компанийн тэтгэмжийн төлөвлөгөө	Жилийн ба урт хугацаат	Эрүүл мэнд, шүд, хөдөлмөрийн чадвар алдах эрсдэлийн даатгалын хураамжууд багтана.
	Мөнгөн урамшуулал	Мөнгөн	Жилээр	Хязгаарлагдмал тооны хувийн ашиг орлого, үүнд мэргэжлийн хөлс болон ачаалалтай ажилласны тэтгэмж багтана.

ТУЗ нь Цалин урамшууллын хорооны санал болгосны дагуу, нэр бүхий удирдлагын цалин урамшууллын багцад үнэлгээ хийхдээ цалин урамшууллын бүрдлийг нэг бүрчлэн харгалзан авч үзнэ. ТУЗ нь Цалин урамшууллын хорооны санал дээр тулгуурлах бөгөөд хэрэв цалин, бонус, опционы хэмжээ зэргийг тогтоохдоо бие даасан зөвлөхөөр ямар ч үед ажиллуулсан Компанийн цалин урамшуулал үргэлж зохистой бөгөөд өрсөлдөхүйц хэмжээнд байх ёстойг анхааран шийдвэр гаргана.

### **Үндсэн цалин**

Нэр бүхий Удирдлагын цалинг бүлэг дотроо салбар болон хэмжээний хувьд, мөн үйл ажиллагааны түвшинтэй нь харьцуулахад өрсөлдөхүйц албан тушаалтнуудын цалин хөлсний жишгээр тогтооно. Хувь хүний нөхцөл байдал, тухайлбал нэр бүхий Удирдлагын хийх ажлын цар хүрээ, газарзүйн байршил, мөн түүний ур чадвар, туршлага, тогтвор суурьшилтай ажиллаж чадах эсэх эрсдэлүүд зэргийг харгалзан үзнэ. Компанийн санхүүгийн гүйцэтгэл нэр бүхий Удирдлагын хувийн гүйцэтгэлд хамаарах нэг хүчин зүйл мөн. Нэр бүхий Удирдлагын үндсэн цалинг Цалин хөлсний хороо жил бүр хянах ба Гүйцэтгэх захиралтай зөвлөлдөнө. Компани дотор үүрэг хариуцлага солигдсонтой холбогдуулан, хувийн гүйцэтгэл, Компанийн үйл ажиллагааны үр дүн, зах зээл дээр цалингийн түвшинд ерөнхий өөрчлөлт орсонтой уялдуулан үндсэн цалингийн хэмжээг өөрчилж болно. Нэр бүхий Удирдлага цалингаа бүхлээр нь эсхүл хэсэгчлэн Ирээдүйд олгогдох хувьцааны эрх хэлбэрээр авах сонголт хийж болно (доорх “Хувьцаанд суурилсан цалин (Ирээдүйд олгогдох хувьцааны эрх)” хэсгээс харна уу). Нэр бүхий удирдах албан тушаалтнууд нь цалингийн оронд ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг авахаар сонгосон тохиолдолд авах цалингийн хэмжээн дээр 20%-ийн нэмэгдэл бүхий ИОХЭ-г хүлээн авна

### **Гүйцэтгэлийн бонус**

2017 онд ТУЗ нь гүйцэтгэх захирал, санхүү хариуцсан захирал болон гүйцэтгэх удирдах албан тушаалтны цалин урамшууллыг нь хянаж байх ба хөдөлмөрийн гэрээгээр ажиллах удирдах албан тушаалтнуудад зориулан (тус бүрийг нь “Ахлах албан тушаалтан” гэх) бонусын төлөвлөгөө баталж, энэ нь 2016 оны санхүүгийн жилээс хүчин төгөлдөр болсон. Одоогоор төлөвлөгөөний байдлаар хоёр ахлах албан тушаалтан, гүйцэтгэх захирал, мөн санхүү хариуцсан захиралтай. Энэхүү төлөвлөгөөний дагуу ахлах албан тушаалтан тус бүр хувийн зорилтуудаа бэлтгэж, гүйцэтгэх захиралд тухайн санхүүгийн жилийн нэгдүгээр улирлын эхэнд танилцуулах үүрэгтэй. Гүйцэтгэх захирал эхлээд ахлах албан тушаалтан бүрийн тавьсан зорилтуудыг хянах ба Цалин урамшууллын хорооны дарга гүйцэтгэх захирлын зорилтыг хянана. Ахлах албан тушаалтнуудын зорилтуудыг Цалин урамшууллын хороонд хянуулахаар нэгдүгээр улиралд илгээх ба шаардлагатай гэж үзвэл ТУЗ-өөс эцсийн зөвшөөрөл авахаар санал хүргүүлнэ.

Компанийн бонусын бодлогын дагуу тэдгээр зорилтуудыг биелүүлсэн гүйцэтгэлээр нь ахлах албан тушаалтнуудын бонусыг тооцоолно. Зорилгоо биелүүлсэн амжилтад үндэслэн ахлах албан тушаалтны бонусын 75%-ийг зорилгоо биелүүлсэн амжилт, үр дүнд үндэслэж олгох ба үлдэгдэл 25% нь S&P/TSX Глобал Алтны Индексстэй харьцуулсан энгийн хувьцааны үнийн өсөлттэй уялдуулан бодож олгоно. Бонусын дүнгийн дээд хэмжээ зорилго, зорилтуудаа биелүүлсэн гүйцэтгэлээр жинлэгдэх бөгөөд ахлах албан тушаалтны зорилгын ангиллыг дор харуулав.

**Эрдэнэ Ресурсийн ахлан албан тушаалтны бонусын төлөвлөгөө  
Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур**

Нэр ба албан тушаал	Гүйцэтгэлийн ерөнхий зорилгууд			Гүйцэтгэлийн хувийн жин							% нийт
	Бонусын дээд хэмжээ- Жилийн цалингийн хувиар	Хувьцааны үнийн жин	Хувийн гүйцэтгэлийн хувь	Багийн хөгжил	Санхүү, худалдан авалт M&A хөгжил ба гүйцэтгэл	Үйл ажиллагаа, зөвшөөрөл, хууль тогтоомж, ЗГ-н хамшлаа	Хайгуулын амжилт, нөөц/баялаг бүртгүүлэх	Төсөв, Хугацаат Үе, хуулийн хэрэгжилт	Дотоод харилцаа холбоо	XXЭАБООН	
<b>Гүйцэтгэх захирал</b>	60%	25%	75%	20%	20%	15%	20%	5%	15%	5%	100%
<b>Дэд ерөнхийлөгч бөгөөд Санхүү хариуцсан захирал</b>	40%	25%	75%	20%	30%	10%	0%	20%	15%	5%	100%

Гүйцэтгэх захирал нь ахлах албан тушаалтнуудын тавьсан зорилт, түүний биелэлтийг (өөрийн гүйцэтгэлээс бусдыг) хянана. Ийнхүү хянан үзсэний дараа өөрийнхөөсөө бусад ахлах албан тушаалтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний хувь болон бонусын хэмжээний саналыг Цалин урамшууллын хороонд дэвшүүлнэ. Цалин урамшууллын хорооны дарга гүйцэтгэх захирлын гүйцэтгэлийг хянаад гүйцэтгэлийн үнэлгээний хувь болон бонусын хэмжээний саналыг Цалин урамшууллын хороонд дэвшүүлнэ.

Ахлан албан тушаалтны бонусыг тооцохдоо энгийн хувьцааны үнийн өсөлт бууралтад тулгуурлах ба өмнөх жилийн Компанийн зах зээлийн өдөр тутмын дундаж үнэлгээний өөрчлөлтийн хувийг өмнөх жилийн S&P/TSX Глобал Алтны Индексийн өдөр тутмын дундаж балансын өөрчлөлтийн хувьтай харьцуулна. Харьцаа тэнцүү байвал ахлах албан тушаалтан 25%-ийн талыг бонус болгон авна. Компанийн зах зээлийн өдөр тутмын дундаж үнэлгээний өөрчлөлтийн хувь S&P/TSX Глобал Алтны Индексийн өдөр тутмын дундаж балансын өөрчлөлтийн хувиас давсан 5% тутамд 1%-аар нэмэгдэх бөгөөд энэ нь хамгийн дээд хязгаар болох 25% хүртэл өснө. S&P/TSX Глобал Алтны Индексийг Компанийн хөрөнгөөр бус, харин уул уурхайн олон төрлийн хөрөнгөтэй компаниудын гүйцэтгэлийн үзүүлэлтийг өргөн хүрээнд хэмждэг жишиг үзүүлэлт гэдэг утгаар нь сонгож авсан.

Эцэст нь бонусын төлөвлөгөөний дагуу олгогдох аливаа төлбөрийг ТУЗ өөрийн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ. Бонусын төлбөрийг батлахын өмнө ТУЗ нь ерөнхий зах зээл, салбарын нөхцөл байдал, ялангуяа, бие даасан зөвлөхүүдийн аль ч үед боловсруулсан хараат бус цалин хөлсний дүн шинжилгээг анхаарч үзнэ.

Ахлах албан тушаалтны урамшууллын төлөвлөгөөнөөс гадна, Цалин урамшууллын хороо нь нэр бүхий удирдах албан тушаалтанд олгох мөнгөн урамшууллын хэм хэмжээг санал болгох эрхтэй.

2020 онд Гүйцэтгэх захирал болон Санхүү хариуцсан захирал нь жилийн үндсэн цалингийн ойролцоогоор 42% болон 27%, 2021 онд Гүйцэтгэх захирал болон Санхүү хариуцсан захирал нь жилийн үндсэн цалингийн ойролцоогоор 52% болон 24%-ийн урамшууллын эрх тус тус авсан. 2022 онд Гүйцэтгэх захирал болон Санхүү хариуцсан захирал нь жилийн үндсэн цалингийн ойролцоогоор 55% ба 37% -ийн урамшуулал авсан нь бие даасан гүйцэтгэлийн зорилгын дийлэнх хэсгийг биелүүлсэнтэй холбоотой юм. "Ахлах албан тушаалтны цалин урамшуулал – цалин урамшууллын нэгтгэсэн хүснэгт" гэсэн гарчгийн доорх хүснэгтэд байгаа тэмдэглэлийг үзнэ үү.

### **Опционд суурилсан урамшуулал**

Урамшууллын хувьцааны опционы стратегийн хэрэглээ нь Компанийн цалин урамшууллын төлөвлөгөөний суурь юм. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь Компанийн удирдлага, албан тушаалтнууд, ажилтнууд, зөвлөхүүд Компанийнхаа хувьцааг авахыг нь дэмжих Компанийн болон түүний хамаарал бүхий этгээдүүдийн сонирхлыг нэмэгдүүлэх, ингэснээр Компанид өөрсдийн эзэмшлийн ашиг сонирхлыг нэмэгдүүлэх, Компанитайгаа холбоотой хэвээр үлдэх, ийнхүү урамшуулал үзүүлэх нь тэднийг Компанийн нэрийн өмнөөс онцгой хичээл зүтгэл гаргаж ажиллахыг дэмжих зорилготой. Төлөвлөгөө нь Компанийн амжилтад чухал ач холбогдолтой өндөр ур чадвартай ажилчдын хүсэл сонирхлыг татах, урамшуулах, урт хугацаанд ажиллуулах чухал хэрэгсэл хэвээр байна. Төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг "Өмчийн урамшууллын төлөвлөгөөний дагуу олгохоор батлагдсан үнэт цаас-Урамшууллын хувьцааны опционы төлөвлөгөө"-г үзнэ үү.

Нэр бүхий удирдлагад олгох хувьцааны опционыг Цалин урамшууллын хороо болон ТУЗ-өөс батална. Нэр бүхий удирдлагад олгох хувьцааны опционыг хэрхэн олгохыг Цалин урамшууллын хороо болон ТУЗ нь дараах хүчин зүйлүүдийг харгалзан тогтоох ба үүгээр хязгаарлагдахгүй: (i) Нэр бүхий удирдлагын өмнө нь эзэмшиж байсан опционы тоо; (ii) Нэр бүхий удирдлага ба Компанийн бусад удирдах албан тушаалтнуудын эзэмшиж байгаа опционуудын баланс; (iii) Нэр бүхий удирдлагын нийт цалин урамшууллын багцын бүрдэлд эзлэх опционы үнэ цэн багтана.

### **Хувьцаанд суурилсан урамшуулал (Ирээдүйд олгогдох хувьцааны эрх)**

Компани 2012 онд Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөө ("ИОХЭ"-ийн Төлөвлөгөө)-г хэрэгжүүлж эхэлсэн ба ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд үндсэн цалингаа бүхэлд нь эсвэл хэсэгчлэн Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("ИОХЭ") авах боломжтой болсон.

Үүнээс гадна, Цалин урамшууллын хороо нь ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу өөрийн шийдвэрээр ИОХЭ-ийн урамшуулал олгох эрх мэдэлтэй. Энэхүү опцион төлөвлөгөөний дагуу өөрийн эрх мэдлийн хүрээнд урамшуулал олгох үйл ажиллагаа нь дээр дурдсан "Опционд суурилсан шагнал" хэсэгт дурдсан бодлогод нийцүүлэн хийгдэнэ.

ИОХЭ-ийн Төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг "Өмчийн урамшууллын төлөвлөгөөний дагуу олгохоор батлагдсан үнэт цаас-Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөө"-г үзнэ үү.

### **Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр**

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг баталж, Залгамж халааны төлөвлөгөөг орлуулахыг хувьцаа эзэмшигчдэд санал болгож байна. ХСУБХ нь Опцион, ХБХН, ГУХН болон ИОХЭ гэх хувьцаанд суурилсан урамшууллыг олгох уян хатан байдлыг Компанид олгоно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус хөтөлбөрийг баталбал хувьцаанд суурилсан урамшууллын ирээдүйд олгох бүх төрлийн урамшууллыг ХСУБХ дагуу, эсхүл зөвшөөрсний дагуу хэрэгжүүлэх бөгөөд цаашид Залгамж халааны төлөвлөгөөний дагуу урамшуулал олгохгүй. Залгамж халааны төлөвлөгөө нь зөвхөн тус төлөвлөгөөний дагуу олгосон хүчинтэй байгаа урамшууллын хувьд хүчин төгөлдөр байна. Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллын хугацаа дуусах үед тус төлөвлөгөө хүчингүй болно.

Одоогийн байдлаар ХСУБХ-ийн дагуу олгох урамшууллыг Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгохтой адил байдлаар зохицуулахаар төлөвлөж байна. ХСУБХ-ийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй "Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр" гэх хэсгээс танилцана уу.

### **Тэтгэмжүүд**

Гүйцэтгэх захирал, санхүү хариуцсан захирал болон бусад нэр бүхий удирдлага нь Компанийн тэтгэмжийн хөтөлбөрт хамрагддаг. Тэтгэмжийн хөтөлбөрт ижил төрлийн байгууллагуудын нэгэн адилаар эрүүл мэнд, шүд болон амь насны даатгал зэргийг багтаасан.

### **Нэмэлт урамшуулал**

Компани нь хязгаарлагдмал тооны мөнгөн урамшууллыг тодорхой албан тушаалтнуудад олгодог бөгөөд энэ нь нийт урамшууллын хувьд материаллаг бусад тооцогддог. Үүнээс дэд ерөнхийлөгч н.Жон Лёнс нь Монгол


Улсад оршин суудаг тул нэмэлт урамшуулал авдаг. Жишээлбэл, Компани өөрийн салбарын байгууллагуудын автомашины зогсоолын төлбөр, гишүүнчлэл зэргийг төлдөг. Компани эдгээр шагнал урамшууллыг ажилтны хүсэл сонирхлыг татах, урт хугацаагаар ажиллах, урамшуулах арга хэрэгсэл болгодог.

### Цалин урамшууллыг ойлгоход туслах бусад хүчин зүйлс

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрт тусгагдсан хэджингээс хамгаалах бодлогыг эс тооцвол, Компанид одоогоор нэр бүхий удирдлага эсвэл Компанийн захирлуудыг үнэт цаасны зах зээлийн үнийн бууралтад нөхөн төлбөр олгодог даатгалын сан хэлбэрийн солилцооны сангийн нэгжүүд, хүүгийн баталгаа, өмчийн солилцоо, итгэл үнэмшил бүхий урьдчилан төлсөн хувьсах форвард гэрээ зэрэг санхүүгийн хэрэгслийг шууд ба шууд бусаар эзэмших буюу худалдаж авахыг хориглосон дүрэм журам байхгүй. Гэсэн хэдий ч нэр бүхий Удирдлага ба ТУЗ-ийн гишүүд эдгээр төрлийн санхүүгийн хэрэгслийг худалдаж аваагүй байна.

### Гүйцэтгэлийн график


Дараах графикууд нь сүүлийн нэг, гурав, таван жилийн хугацаанд компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг S&P/TSX Global Gold Index болон VanEck Vectors Junior Gold Miners ETF зэрэг харьцуулах боломжтой индексүүдтэй харьцуулан харуулсан.



Энгийн хувьцаа нь 2022 оны 1-р сарын 1-нээс эхлэн 2022 оны 12-р сарын 31 хүртэл жилд дунджаар 37%-аар өссөн. Үүнтэй харьцуулсан S&P / TSX Global Gold Index ижил хугацаанд жилд 3%, The VanEck Vectors Junior Gold Miners ETF нь 14% буурсан байна.


Дараах шугаман графикт 2020 оны 1-р сарын 1-ээс, тухайн өдөр хувьцаанд \$100-ийн хөрөнгө оруулалт хийснээр тооцон 2022 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Компанийн Хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг S&P/TSX Global Gold Index болон VanEck Vectors Junior Gold Miners ETF дэх ижил дүнтэй хөрөнгө оруулалтын өгөөжтэй харьцуулсан байна.





Энгийн хувьцаа нь 2020 оны 1-р сарын 1-нээс эхлэн 2022 оны 12-р сарын 31 хүртэл жилд дунджаар 21%-аар өссөн бөгөөд нийт өсөлт нь 63% байна. Үүнтэй харьцуулсан S&P / TSX Global Gold Index ижил хугацаанд жилд 2%-аар өсөж, нийт өсөлт 7% байсан. Мөн The VanEck Vectors Junior Gold Miners ETF энэ хугацаанд жилд 5%-аар буурч нийт бууралт 16% болсон байна.

Дараах шугаман графикт 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн, тухайн өдөр хувьцаанд \$100-ийн хөрөнгө оруулалт хийснээр тооцон 2022 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Компанийн Хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг S&P/TSX Global Gold Index болон VanEck Vectors Junior Gold Miners ETF дэх ижил дүнтэй хөрөнгө оруулалтын өгөөжтэй харьцуулсан байна.



Энгийн хувьцаа нь 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн 2022 оны 12-р сарын 31 хүртэл жилд дунджаар 10%-аар буурсан бөгөөд нийт бууралт нь 52% болсон байна. Үүнтэй харьцуулсан S&P / TSX Global Gold Index ижил хугацаанд жилд 8%-аар өсөж, нийт өсөлт 40% болсон байна. Мөн The VanEck Vectors Junior Gold Miners ETF энэ хугацаанд жилд 0%-аар өсөж, нийт өсөлт 1% болсон байна.

Дээр дурдсанчлан нэр бүхий удирдлагын цалин урамшууллыг тогтооходоо хэд хэдэн хүчин зүйл, гүйцэтгэлийн элементийг харгалзан үзнэ. Хувьцаа эзэмшигчийн нийт хуримтлагдсан өгөөж урамшууллыг тодорхойлох нь

гүйцэтгэлийн нэг хэмжүүр бөгөөд хувьцааны үнийн өсөлтийг S&P/TSX Глобал Алтны Индекстэй харьцуулсан нь ахлах албан тушаалтан бүрт 25%-тай тэнцэх бонус олгох нөхцөл болсон. Гэвч дээрхээс гадна удирдах албан тушаалтны урамшууллыг хянах, бонусыг тооцоолох өөр бусад олон хүчин зүйлүүд бий. Иймд өгөгдсөн хугацаанд хуримтлагдсан нийт хувьцаа эзэмшигчдийн өгөөж нь удирдах албан тушаалтнуудын шагнал урамшууллын түвшинд шууд хамаатай гэж ойлгож болохгүй.

### Компанийн цалин урамшууллын бодлого ба журамтай холбоотой эрсдэлийн үнэлгээ

Цалин урамшууллын хороо нь Компанийн удирдах албан тушаалтнуудад зориулсан цалин урамшууллын төлөвлөгөө болон хөтөлбөрийг Компанийн бизнесийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэх болон энэхүү хөтөлбөр, төлөвлөгөөтэй холбоотой эрсдэлд үнэлгээ хийсэн. Цалин урамшууллын хороо нь цалин урамшууллын бодлого ба журам нь Компанид материаллаг сөрөг нөлөө учруулахуйц аливаа эрсдэл үүсгэхгүй хэмээн дүгнэсэн.

Цалин урамшууллын хороо нь удирдах албан тушаалтны цалин урамшуулал ба компанийн урамшууллын төлөвлөгөө ба хөтөлбөрийг зохиох болон хянах явцдаа тухайн төлөвлөгөө ба хөтөлбөрийг Цалин урамшууллын хорооны удирдлага дор, эсхүл уг хороогоор хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлүүдийг тооцож үзсэн.

### Цалин урамшууллын нэгтгэсэн хүснэгт

Дараах хүснэгт нь 2020, 2021, 2022 онуудын 12-р сарын 31-ний жилийн эцсийн байдлаар нэр бүхий удирдлагад төлсөн цалин урамшууллын дүнг харуулсан.

Нэр ба үндсэн албан тушаал	Он	Цалин <sup>(1)</sup> (\$)	Опционы шагнал <sup>(2)</sup> (\$)	Хувьцаанд суурилсан урамшуулал <sup>(3)</sup> (\$)	Жилийн урамшууллын төлөвлөгөө <sup>(4)</sup> (\$)	Бусад бүх урамшуулал <sup>(5)</sup> (\$)	Нийт цалин урамшуулал (\$)
Петер К.Акерли,	2022	357,490	83,500	3,471	197,835	Nil	642,296
Ерөнхийлөгч & Гүйцэтгэх захирал <sup>(7)</sup>	2021	331,301	78,000	6,626	175,000	Nil	590,927
	2020	308,013	124,200	5,033	132,520	Nil	569,766
Роберт Женкинс, Дэд ерөнхийлөгч ба Санхүү хариуцсан захирал	2022	214,435	50,100	8,577	79,115	Nil	352,227
	2021	198,725	48,750	27,033	50,000	Nil	324,478
	2020	184,757	69,750	4,033	50,290	Nil	308,830
Майкл Х.Гиллиз, Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч	2022	198,540	26,200	25,000	25,000	Nil	274,740
	2021	188,168	29,000	25,000	25,000	Nil	267,168
	2020	179,207	39,000	25,000	25,000	Nil	268,207
Жон М.Л.Лёнс <sup>(6)</sup>	2022	264,961	32,750	35,000	35,000	110,548	478,259
Зөвшөөрөл, Стратеги хариуцсан дэд ерөнхийлөгч	2021	208,275	36,250	35,000	35,000	84,803	399,328
	2020	175,826	48,750	25,000	30,000	81,477	361,053

Тэмдэглэл:

- Энэхүү хүснэгтэд мөнгөн урамшууллын оронд нэр бүхий удирдлагад олгосон нийт урамшууллын хэмжээг үзүүлэв. Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("ИОХЭ") нь олгогдсон өдрөө нийт энгийн хувьцааны ИОХЭ нь 5 өдрийн арилжааны хэмжээнд жигнэсэн дундаж үнээр тооцож олгогдоно. 2020 онд н.Акерли, н.Женкинс нь мөнгөн урамшууллын оронд \$25,167, \$20,166 ИОХЭ хүлээн авсан. 2021 онд н.Акерли, н.Женкинс нь мөнгөн урамшууллын оронд \$33,130, \$35,014-ын ИОХЭ хүлээн авсан. 2022 онд н.Акерли, н.Женкинс нь мөнгөн урамшууллын оронд \$17,354, \$42,887-ын ИОХЭ хүлээн авсан.
- Энэхүү хүснэгтэд 2020, 2021, 2022 онуудад нэр бүхий удирдлагад олгосон хувьцааны опционы нийт төлбөрийн дүнг харуулна. Опционд суурилсан урамшууллыг Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Black-Scholes аргыг ашиглан дараах таамаглалуудыг ашиглан үнэлнэ: 2020 онд: Ногдол ашиг хуваарилагдахгүй, эрсдэлгүй хүүгийн түвшин 0.3%, хүлээгдэж буй хэлбэлзэл 70%, мөн хүлээгдэж буй хугацаа 3.7 жил. 2021 онд: Ногдол ашиг хуваарилагдахгүй, эрсдэлгүй хүүгийн түвшин 0.7%, хүлээгдэж буй хэлбэлзэл 63%, мөн хүлээгдэж буй хугацаа 3.6 жил. 2022 онд Ногдол ашиг хуваарилагдахгүй, эрсдэлгүй хүүгийн түвшин 3%, хүлээгдэж буй хэлбэлзэл 62%, мөн хүлээгдэж буй хугацаа 3.6 жил. 2020 онд \$0.21 нэг опцион, мөн 2021 онд нэг опцион \$0.17. 2022 онд нэг опцион \$0.15 байсан. Нэр бүхий удирдлагууд 2020 онд 470,000, 2021 онд 100,000 опцион, 2022 онд 0 опционыг тус тус хэрэгжүүлсэн
- 2020, 2021, 2022 онуудад ИОХЭ төлөвлөгөөний хүрээнд Цалин урамшууллын хороо нь тодорхой хэмжээний ИОХЭ-г урамшуулал болгон олгосон
- 2020, 2021 болон 2022 онуудад н.Акерли болон н.Женкинс-д бонус олгосон. 2020, 2021 болон 2022 онд н.Гиллиз, н.Лёнсд Компанийн ахлах албан тушаалтны бонусын төлөвлөгөөний дагуу тооцож бонус олгосон.
- Нэр бүхий удирдах албан тушаалтны үндсэн цалингийн 10%-иас дээш эсвэл \$50,000-аас дээш мөнгөн урамшууллыг багтаасан. Мөнгөн урамшуулал ба тэтгэмжийн багцийг н.Лёнсд олгосон нь Монгол Улсад ажиллаж амьдарч байгаа зардлуудтай холбогдуулан олгосон. Нэр бүхий удирдах албан тушаалтны мөнгөн урамшуулал нь нийт цалин урамшууллын материаллаг бүрэлдэхүүн биш юм.
- Н. Лёнс 2021 онд Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгчөөр томилогдсон. Энэ өдрөөс өмнө н.Лёнс Компанийн зохицуулалт, стратеги хариуцсан дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.
- Н.Акерли ТУЗ-ийн гишүүний үүрэг гүйцэтгэсэнээр аливаа урамшуулал авдаггүй.

Хувьцаанд суурилсан ба Опционд суурилсан урамшуулал

**Хувьцаанд суурилсан урамшуулал ба Опционд суурилсан урамшууллын үлдэгдэл**  
Доорх хүснэгт нэр бүхий Удирдлагын 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар бүх үлдэгдэл опционд суурилсан шагнал ба хувьцаанд суурилсан шагналыг харуулж байна.

Нэр	Опционд суурилсан урамшуулал				Хувьцаанд суурилсан урамшуулал		
	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны тоо (#)	Опцион хэрэгжүүлэх үнэ (\$)	Опцион хугацаа дуусах огноо	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны үнэлгээ (\$) <sup>(1)</sup>	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны тоо (#)	Хэрэгжүүлээгүй хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн зах зээлийн үнэ цэн (\$)	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны үнэлгээ(\$) <sup>(2)</sup>
Петер К.Акерли, Ерөнхийлөгч & Гүйцэтгэх захирал	500,000	0.31	2027.08.09	32,000	N/A	N/A	506,377
	400,000	0.37	2026.06.23				
	400,000	0.49	2025.08.27				
	100,000	0.22	2025.05.13				
	300,000	0.20	2024.06.20				
Роберт Женкинс, Дэд ерөнхийлөгч ба Санхүү хариуцсан захирал	1,000,000	0.40	2023.06.14	15,000	N/A	N/A	214,831
	300,000	0.31	2027.08.09				
	250,000	0.37	2026.06.23				
	250,000	0.49	2025.08.27				
	150,000	0.20	2024.06.20				
Майкл Х.Гиллиз, Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч	150,000	0.27	2023.10.15	12,750	N/A	N/A	151,418
	200,000	0.31	2027.08.09				
	200,000	0.37	2026.06.23				
	200,000	0.49	2025.08.27				
	150,000	0.20	2024.06.20				
Жон М.Л.Лёнс, Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгч	150,000	0.40	2023.06.14	8,500	N/A	N/A	107,499
	250,000	0.31	2027.08.09				
	250,000	0.37	2026.06.23				
	100,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				

Тэмдэглэл:

- (1) Хэрэгжүүлээгүй байгаа мөнгөөр илэрхийлсэн опционы үнэ цэн TSX биржийн Энгийн хувьцааны 2022 оны жилийн эцсийн хаалтын ханш \$0.285 болон опционыг зарах үнийн зөрүү юм.
- (2) Баталгаажсан ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар үлдэгдэл ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тоо ширхгийг TSX биржийн Энгийн хувьцааны 2021 оны жилийн эцсийн хаалтын ханш \$0.285-аар үржүүлж тооцно.
- (3) Нэр бүхий удирдлага 2020 онд 470,000 опцион, 2021 онд 100,000 опцион, 2022 онд 0 опцион тус тус хэрэгжүүлсэн.
- (4) Бүх опционд болон хувьцаанд суурилсан шагналууд олгогдсон даруй баталгаажсан.

Урамшууллын төлөвлөгөөний шагнал – Баталгаажсан ба хэрэгжүүлсэн үнэ цэн 2022 онд

Нэр	Опционд суурилсан шагнал – баталгаажсан үнэ цэн 2022 онд (\$)	Хувьцаанд суурилсан шагнал – баталгаажсан үнэ цэн 2022 онд (\$)	Үнэт цаасны бүс урамшууллын төлөвлөгөө урамшуулал – 2022 онд олсон үнэ (\$)
Петер К.Акерли, Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал	Nil <sup>(1)</sup>	20,825 <sup>(2)</sup>	Nil
Роберт Женкинс Дэд ерөнхийлөгч, Санхүү хариуцсан захирал	Nil <sup>(1)</sup>	51,464 <sup>(2)</sup>	Nil
Майкл Х.Гиллиз, Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч	Nil <sup>(1)</sup>	25,000 <sup>(2)</sup>	Nil
Жон М.Л.Лёнс, Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгч	Nil <sup>(1)</sup>	35,000 <sup>(2)</sup>	Nil

Тэмдэглэл:

- (1) 2022 оны 8 сарын 9-нд нэр бүхий удирдлагад нэгж бүр нь \$0.31 хэрэгжих нийт 1,250,000 опцион олгосон бөгөөд нэн даруй баталгаажсан. 2022 оны 8-р сарын 9-ны байдлаар энгийн хувьцааны зах зээлийн үнэ 5 өдрийн нийт хэмжээнд жигнэсэн дундаж үнээр \$0.31 байсан.
- (2) Баталгаажсан үнэ цэн баталгаажсан (олгосон өдөр) өдрийн энгийн хувьцааны зах зээлийн үнэнд суурилсан. 2022 онд н.Акерли, н.Женкинс, н.Гиллиз болон н.Лёнс нарт нийлсэн дүнгээр 413,967 ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон бөгөөд нэн даруй баталгаажсан. Энгийн хувьцааны зах зээлийн үнэ 5 өдрийн нийт хэмжээнд жигнэсэн дундаж үнээр \$0.32 байсан.

**Үүрэгт ажлаас чөлөөлөх ба Хяналт солигдсоны тэтгэмж**

Компани одоогоор нэр бүхий удирдлага үүрэгт ажлаас сайн дураар чөлөөлөгдөх, тэтгэвэрт гарах, халагдах эсхүл Компанийн хяналт солигдох, Компанийн хяналт солигдсонтой холбоотой нэр бүхий удирдлагын үүрэг хариуцлага өөрчлөгдөх зэрэг тохиолдолд тэтгэмж авах эрхийн талаар аливаа нөхөн төлбөрийн төлөвлөгөө, гэрээ зохицуулалт байхгүй байна.

Гэвч дараах нөхцөлүүд н.Женкинс, н.Гиллиз, н.Лёнс нартай байгуулсан хөдөлмөрийн гэрээний нөхцөлөөр, хэрэв Компанийн санаачилгаар тэднийг ажлаас халсан тохиолдолд, тэд Компанид ажилласан жил тутамд нэг сарын мэдэгдэл, эсхүл мэдэгдлийн төлбөр, гурваас (3) дээш сарын цалин, мөн Компанид ажилласан жил тутамд нэг (1) сарын үндсэн цалин авах нөхцөлтэй. Хэрэв н.Акерлиг Компанийн санаачилгаар шалтгаангүйгээр ажлаас халсан тохиолдолд, гэрээг цуцалснаас хойш 12 сарын хугацаанд олгох байсан цалин болон бонустай тэнцэх хэмжээний тэтгэмж болон даатгалын тэтгэмжийг зургаан (6) хугацаанд үргэлжлүүлэн олгоно. Түүнээс гадна н.Женкинс, н.Гиллиз, н.Лёнс нар нь Компанитай хийсэн гэрээний дагуу дээрх албан тушаалтнууд Баянхөндий алтны төслийн олборлолтыг амжилттай эхлүүлэх үед албан тушаалдаа хэвээр байвал 2019 оны үндсэн цалинтай 100% тэнцэх хэмжээний урамшуулал авах эрхтэй. Энэхүү үйл ажиллагаанаас өмнө дээрх албан тушаалтнууд шалтгаангүйгээр хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон тохиолдолд урамшууллыг хувь тэнцүүлэн олгоно.

Н.Акерли, н.Женкинс нартай хийсэн хөдөлмөрийн гэрээний нөхцлөөр Компанийн хяналт солигдсон тохиолдолд, тэд Компанитай хийсэн гэрээгээ цуцалж болно. Хэрэв тэгсэн тохиолдолд, Компани н.Акерлигийн хувьд гэрээг цуцалснаас хойш 24 сарын хугацаанд олгох байсан цалин болон бонустай тэнцэх хэмжээний нийт мөнгөн дүнгээр тэтгэмж олгох ба н.Женкинсийн хувьд гэрээг цуцалснаас хойш 18 сарын хугацаанд олгох байсан цалин болон бонустай тэнцэх хэмжээний нийт мөнгөн дүнгээр тэтгэмж олгох; мөн.

Хэрэв Компаниас н.Акерлигийн гэрээг нас барсан эсхүл хөдөлмөрийн чадвараа алдсантай холбоотой цуцалбал, гэрээг цуцалснаас хойш 12 сарын хугацаанд олгох байсан цалин болон бонустай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно.

Хэрэв нэр бүхий удирдлага тодорхой шалтгааны улмаас халагдвал Компаниас хөдөлмөрийн гэрээний дагуу ажилласан хугацаанд нь хуримтлагдсан олговол зохих одоогийн цалинг тооцож олгоно.

Хэрэв нэр бүхий удирдлага 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр гэрээ нь цуцлагдсан бол Компани ажлаас чөлөөлсөн өдрөөс хүчин төгөлдөр тооцож хуримтлагдсан цалин дээр нэмж доорх дүнг олгоно:

Нэр	Гэрээ цуцлах нөхцөл									
	Өөрийн хүсэлтээр		Шалтгаангүйгээр гэрээ цуцлах		Өөрийн хүсэлтээр		Нас барах, ажлын чадвар алдах		Өөрийн хүсэлтээр	
	Бэдэн	ИОХЭ <sup>(3)</sup>	Бэдэн	ИОХЭ <sup>(3)</sup>	Бэдэн	ИОХЭ <sup>(3)</sup>	Бэдэн	ИОХЭ <sup>(3)</sup>	Бэдэн	ИОХЭ <sup>(3)</sup>
Петер К.Акерли <sup>(1)</sup>	Nil	506,377	555,325	506,377	Хуримтлагдсан одоогийн жилийн цалин	506,377	555,325	506,377	1,061,626	506,377
Роберт Женкинс	Nil	214,831	128,730	214,831	Хуримтлагдсан одоогийн жилийн цалин	214,831	Nil	214,831	417,913	214,831
Майкл Х.Гиллиз	Nil	151,418	314,355	151,418	Хуримтлагдсан одоогийн жилийн цалин	151,418	Nil	151,418	Nil	151,418
Жон М.Л. Лёнс <sup>(2)</sup>	Nil	114,146	157,109	107,499	Хуримтлагдсан одоогийн жилийн цалин	107,499	Nil	107,499	Nil	107,499

Тэмдэглэл:

(1) Шалтгаангүй ажлаас халах эсхүл хяналт солигдвол, Компани н.Акерлигийн гэрээг цуцалснаас хойш 6 сарын хугацаанд тэдний группийн даатгалыг хэрэв байгаа бол үргэлжлүүлэх; хэрэв Компани тэднийг холбогдох шалтгааны улмаас ажлаас халсан

- тохиолдолд тухайн даатгалын тэтгэмжийг үргэлжлүүлэх боломжгүй бол Компаниас н.Акерлигийн даатгалд төлөгдвөл зохих төлбөрийг төлөхийг шаардахгүй.
- (2) н.Лёнсийн гэрээний хугацаа 2023 оны 4-р сарын 30-нд дуусахаар заагдсан. Энэхүү гэрээнд үргэлжлүүлэн сунгагдах заалт орсон бөгөөд энэхүү мэдээллийг бэлтгэх явцад н.Лёнс нь Компанийн ажилтан хэвээр байгаа болно. Мөн н.Лёнс гэрээ цуцалсантай холбоотой нүүлгэлтийн тэтгэмж авах эрхтэй.
- (3) Компанийн сонголтоор ИОХЭ-үүдийг эргүүлэн авч энгийн хувьцааны оронд мөнгөн хэлбэрээр олгож болно.

### ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал

Дараах хүснэгтэд 2022 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилийн нэр бүхий удирдлагаас бусад ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин урамшууллын дүн:

Нэр	Авсан төлбөр <sup>(1)</sup> (\$)	Хувьцаанд суурилсан шагнал <sup>(2)</sup>		Опционд суурилсан шагнал <sup>(3)</sup> (\$)	Бусад урамшуулал (\$)	Бүгд (\$)
		ИОХЭ үнэ цэн (\$)	ИОХЭ тоо #			
Др. Анна Г.Биолик	22,000	14,400	45,259	20,875	Nil	57,275
Жон П.Бюрн	22,000	12,000	37,778	20,875	Nil	54,875
Т.Лэйтон Крофт	46,000	20,000	62,963	20,875	Nil	86,875
Кэннет МакДоналд <sup>(4)</sup>	21,000	11,000	34,630	20,875	Nil	52,875
Камерон МакРэй	16,000	10,000	31,481	20,875	Nil	46,875
Дэвид В.Мошер	18,000	13,600	42,963	20,875	Nil	52,475
Хэдли Виддап	15,000	10,000	31,481	20,875	Nil	45,875

Тэмдэглэл:

- (1) Цалин урамшууллын дүнд ТУЗ-ийн цалин урамшуулал ба хороодын уулзалтын урамшууллууд багтсан. Бэлэн мөнгөний урамшууллын оронд ТУЗ-ийн гишүүдийн сонголтоор хүлээн авсан ИОХЭ багтана. ИОХЭ-ийг үнэ цэнийг олгосон өдрөөс хойш таван өдрийн жигнэсэн дундаж үнээр ("VWAP") үнэлдэг. Др Биолик бэлэн мөнгөний урамшууллын оронд 22,000 ам.долларын үнэлгээ бүхий ИОХЭ авахаар сонгосон. Н.Бюрн бэлэн мөнгөний урамшууллын оронд 10,000 ам.долларын үнэлгээ бүхий ИОХЭ авахаар сонгосон. Н. Крофт бэлэн мөнгөний урамшууллын оронд 5,000 ам.долларын үнэлгээ бүхий ИОХЭ авахаар сонгосон. Н.МакДоналд бэлэн мөнгөний урамшууллын оронд 5,000 ам.долларын үнэлгээ бүхий ИОХЭ авахаар сонгосон. Н.Мошер бэлэн мөнгөний урамшууллын оронд 18,000 ам.долларын үнэлгээ бүхий ИОХЭ авахаар сонгосон.
- (2) Авсан төлбөрт ТУЗ-ийн гишүүдийн хувьцаанд суурилсан нөхөн төлбөр багтаж байгаа боловч сонголтоор авсан ИОХЭ-г оруулахгүй. ИОХЭ нь олгосон өдөр баталгаажих бөгөөд олгосон өдрөөс хойш таван өдрийн жигнэсэн дундаж үнээр ("VWAP") үнэлнэ. ТУЗ-ийн гишүүд нь ажлаас гарах, тэтгэвэрт гарах зэрэг Компаниас аливаа шалтгаанаар гарах тохиолдолд компанийн сонголтоор энгийн хувьцаагаар эсвэл бэлэн мөнгөөр эргэн худалдаж авна. 29-р хуудасны Урамшууллын төлөвлөгөө – 2022 онд баталгаажсан, хэрэгжүүлсэн үнэ цэнийн мэдээллээс ТУЗ-ийн гишүүдэд олгосон ИОХЭ-ийн үнэ цэн болон тоо хэмжээг харна уу.
- (3) Бүх опцион 5 жилийн хугацаатай байсан бөгөөд олгогдох үедээ бүрэн баталгаажсан байсан. Компани үнэт цаасанд суурилсан урамшууллыг Black-Scholes аргаар дараах таамаглалуудыг ашиглан үнэлнэ: Ногдол ашиг хуваарилахгүй, эрсдэлгүй хүүгийн түвшин 2.85%, хүлээгдэж буй хэлбэлзэл 58.9%, мөн хүлээгдэж буй хугацаа 5 жил. Энгийн хувьцаа худалдаж авах опционы хэрэгжүүлэх үнэ нь олгосон өдрийн байдлаар зах зээлийн үнийн дүнтэй тэнцүү. 2022 онд олгосон опционы бодит үнэ нэг опцион \$0.167. 2022 онд ТУЗ-ийн гишүүд нийт 0 опцион хэрэгжүүлсэн.
- (4) Авсан төлбөрт ТУЗ-ийн хороодын уулзалтын урамшуулал болох \$2,000 багтсан.

2022 оны 1 сарын 1-ээс 2022 оны 12 сарын 31-нд хараат бус, удирдлагын бүрэлдэхүүнд багтдаггүй ТУЗ-ийн гишүүд нь жилд \$10,000 үнэлгээ бүхий ИОХЭ (улиралд \$2,500 үнэлгээ бүхий ИОХЭ) хүлээн авах, жилд \$10,000 мөнгөн урамшуулал (улиралд \$2,500 үнэлгээ бүхий мөнгөн урамшуулал) хүлээн авах эрхтэй бөгөөд ТУЗ-ийн хурал эсвэл хороодын хуралдааны ирцэд тулгуурлан хуралдаан бүрд \$1,000 урамшуулал олгогддог. ТУЗ-ийн дарга нь жилд 20,000 долларын үнэлгээ бүхий ИОХЭ (улиралд 5,000 долларын үнэлгээ бүхий ИОХЭ) болон жилд 20,000 долларын мөнгөн урамшуулал (улирал тутамд 5,000 долларын мөнгөн урамшуулал) авах эрхтэй бөгөөд ТУЗ эсвэл ТУЗ-ийн аль нэг хорооны хуралдаанаас 2,000 долларын урамшуулал авах эрхтэй. ТУЗ-ийн гишүүд нь мөнгөн урамшууллын нийт дүн эсвэл тодорхой хувийг ИОХЭ-ээр хүлээн авах эрхтэй. ТУЗ-ийн зөвшөөрөлтэйгөөр аливаа хороодын хуралд ажиглагчаар оролцсон ТУЗ-ийн гишүүд тухайн хуралд оролцсоны урамшуулал авах боломжтой. 2022 онд ТУЗ-ийн хурлын ирцэд тулгуурлан олгох төлбөрийн нийт дүн \$125,000 болсон. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хурлаас үүдсэн томилолтын зардал болон бусад өөрийн төлсөн зардлуудын нөхөн төлбөрийг хүлээн авдаг. ИОХЭ авахаар сонгосон ТУЗ-ийн гишүүд үнийн дүнгийн 20%-тай тэнцэх хэмжээний нэмэлт ИОХЭ-ийн хувьцаанд суурилсан урамшуулал авдаг.

ТУЗ-ийн Цалин урамшууллын хороо нь ижил төстэй зөвлөлүүдийн цалин урамшууллын харьцуулалт хийж ТУЗ-д санал дэвшүүлнэ. ТУЗ нь Цалин урамшууллын хорооны саналд үндэслэн удирдах албан тушаалтан бус удирдлагын бус ТУЗ-ийн гишүүд, тэдгээрт төлөх цалин урамшууллын хэмжээг тогтооно.

**Хувьцаанд суурилсан урамшуулал ба Опционд суурилсан урамшууллын үлдэгдэл**  
Дараах хүснэгтэд 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар нэр бүхий Удирдлагаас бусад ТУЗ-ийн гишүүдэд олгох опционд суурилсан болон хувьцаанд суурилсан урамшууллын бүх үлдэгдлийг үзүүлсэн.

Нэр	Опционд суурилсан урамшуулал <sup>(3)</sup>				Хувьцаанд суурилсан урамшуулал <sup>(3)</sup>		
	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны тоо (#)	Опцион хэрэгжүүлэх үнэ (\$)	Опцион дуусах хугацаа	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны тоо (\$) <sup>(1)</sup>	Опцион хэрэгжүүлэх үнэ (#)	Баталгаажгаагүй байгаа хувьцаанд суурилсан шагналын зах зээлийн ба төлбөрийн үнэлгээ (\$)	Хэрэгжүүлээгүй опционд суурилсан үнэт цаасны тоо (\$) <sup>(2)</sup>
Др. Анна Г.Биолик	125,000	0.31	2027.08.09	8,500	N/A	N/A	125,163
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	100,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				
Жон П.Бюрн	125,000	0.31	2027.08.09	15,000	N/A	N/A	187,998
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	100,000	0.22	2025.05.13				
	100,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				
Т.Лэйтон Крофт	125,000	0.31	2027.08.09	12,750	N/A	N/A	130,514
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	150,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				
Кэннет МакДоналд	125,000	0.31	2027.08.09	8,500	N/A	N/A	76,328
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	100,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				
Камерон МакРэй	125,000	0.31	2027.08.09	12,750	N/A	N/A	58,288
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	150,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				
	100,000	0.40	2023.03.13				
Дэвид В.Мошер	125,000	0.31	2027.08.09	15,000	N/A	N/A	136,433
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	100,000	0.22	2025.05.13				
	100,000	0.20	2024.06.20				
	100,000	0.40	2023.06.14				
Хэдли Виддап	125,000	0.31	2027.08.09	23,500	N/A	N/A	43,626
	100,000	0.37	2026.06.23				
	100,000	0.49	2025.08.27				
	200,000	0.22	2025.05.13				
	100,000	0.18	2024.11.29				

Тэмдэглэл:

- (1) Хэрэгжүүлээгүй, мөнгөн дүнгээр илэрхийлсэн опционы үнэ нь TSX биржийн Энгийн хувьцааны 2022 оны жилийн эцсийн хаалтын ханш \$0.285 болон опционыг зарах үнийн зөрүү юм.
- (2) Баталгаажсан ИОХЭ-ийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар үлдэгдэл ИОХЭ-ийн тоо ширхгийг TSX биржийн Энгийн хувьцааны 2022 оны жилийн эцсийн хаалтын үнэ ханш \$0.285-аар үржүүлж тооцно
- (3) Бүх опционууд болон ИОХЭ-үүд олгогдсон даруй баталгаажсан.
- (4) 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар Др.Биолик 439,168, н.Бюрн 659,641, н.Крофт 457,943, н.МакДоналд 267,819, н.МакРэй 204,518, н.Мошер 478,713, н.Виддап 153,075 ширхэг ИОХЭ-ийг тус тус эзэмшиж байна.



Урамшууллын төлөвлөгөөний шагнал – 2022 онд баталгаажсан, хэрэгжүүлсэн үнэ цэн

Name	Опционд суурилсан урамшуулал – баталгаажсан үнэ цэн 2022 онд (\$)	Хувьцаанд суурилсан урамшуулал – баталгаажсан үнэ цэн 2022 онд (\$)	Үнэт цаасны бус урамшууллын төлөвлөгөө урамшууллын үнэ цэн 2022 онд (\$)
Др.Анна Г.Биолик	Nil <sup>(1)</sup>	36,400 <sup>(2)</sup>	Nil
Жон П.Бюрн	Nil <sup>(1)</sup>	22,000 <sup>(2)</sup>	Nil
Т.Лэйтон Крофт	Nil <sup>(1)</sup>	21,000 <sup>(2)</sup>	Nil
Кэннет МакДоналд	Nil <sup>(1)</sup>	16,000 <sup>(2)</sup>	Nil
Камерон МакРэй	Nil <sup>(1)</sup>	10,000 <sup>(2)</sup>	Nil
Дэвид В.Мошер	Nil <sup>(1)</sup>	31,600 <sup>(2)</sup>	Nil
Хэдди Виддап	Nil <sup>(1)</sup>	10,000 <sup>(2)</sup>	Nil

Тэмдэглэл:

- (1) 2022 оны 8-р сарын 9-нд нийт 875,000 опционыг ТУЗ-ийн гишүүдэд олгосон ба хэрэгжүүлэх үнэ \$0.31 байна. 2022 оны 8-р сарын 9-нд өдрүүдийн энгийн хувьцааны 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ \$0.31 байсан.
- (2) Баталгаажсан үнэ цэнийг баталгаажсан өдрийн (олгосон өдөр) энгийн хувьцааны зах зээлийн ханшаар тогтоосон. 2022 онд 114,147 ИОХЭ-ийг Др.Биолик, 69,258 ширхэг ИОХЭ-ийг н.Бюрн, 62,964 ширхэг ИОХЭ-ийг н.Крофт, 50,370 ширхэг ИОХЭ-ийг н.МакДоналд, 31,481 ширхэг ИОХЭ-ийг н.МакРэй болон н.Виддап, 100,370 ширхэг ИОХЭ-ийг н.Мошер нарт тус тус олгож, баталгаажсан. Баталгаажсан өдрийн энгийн хувьцааны 5 өдрийн жигнэсэн дундаж ханш \$0.32 байсан.

ТУЗ-ийн гишүүд 2022 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон санхүүгийн жилийн эцэст 0 опцион хэрэгжүүлсэн байна.

ҮНЭТ ЦААСНЫ УРАМШУУЛЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨР БАТАЛСАН ҮНЭТ ЦААС

Үнэт цаасны урамшууллын төлөвлөгөө

Компани одоогоор опционы төлөвлөгөө болон ИОХЭ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг ба ХЭХ-аар хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг баталгаажуулахаар танилцуулж байна. Доорх хүснэгтэд Компанийн сүүлийн санхүүгийн жил буюу 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар Төлөвлөгөөний дагуу энгийн хувьцаанд хөрвөх боломжит опцион ба ИОХЭ-ийн мэдээллийг харуулав.

Үнэт цаасны урамшууллын төлөвлөгөөний мэдээлэл

Төлөвлөгөөний төрөл	Үлдэгдэл опцион, варрант, эсхүл ИОХЭ хэрэгжүүлэх боломжит үнэт цаасны тоо (a)	Үлдэгдэл опцион, баталгааг хэрэгжүүлэх жигнэсэн дундаж үнэ (b)	Үнэт цаасны урамшууллын төлөвлөгөөний дагуу ирээдүйд гаргах боломжтой үлдэгдэл үнэт цаасны тоо ((a)-д заасан үнэт цаасыг оруулахгүйгээр) (c)
Үнэт цаас эзэмшигчдээс баталсан үнэт цаасны урамшууллын төлөвлөгөө <sup>(5)</sup>	17,555,000 <sup>(1)</sup>	\$0.36	16,875,038 <sup>(3)</sup>
Үнэт цаас эзэмшигчдээс баталсан ИОХЭ-ийн төлөвлөгөө	7,287,272 <sup>(2)(4)</sup>	N/A	212,728 <sup>(6)</sup>
Нийт	24,842,272	N/A	17,087,766

Тэмдэглэл:

- (1) Энэ тоо нь 2022 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон хугацаанд Төлөвлөгөөнөөс үлдсэн опционыг тусгасан ба энэ нь нийтэд гаргасан ба арилжиж буй энгийн хувьцааны 5.1%-ийг төлөөлнө.
- (2) Энэ тоо нь 2022 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон хугацаанд ИОХЭ-ийн Төлөвлөгөөнөөс үлдсэн ИОХЭ-ийг тусгасан ба энэ нь нийтэд гаргасан ба арилжиж буй гаргасан энгийн хувьцааны 2.1%-ийг төлөөлнө.
- (3) Энэ тоо нь 2022 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон хугацаанд Компанийн нийтэд гаргасан ба арилжиж буй энгийн хувьцааны 10%-тай тэнцүү буюу 344,300,376 ширхэг, дээрх (a) баганад дурдсан энгийн хувьцааны тооноос бага буюу 2022 оны 12-р сарын 31-ний байдлаарх нийтэд гаргасан ба арилжиж буй энгийн хувьцааны 4.9%-ийг төлөөлнө.
- (4) ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу Компани нь 7,500,000 ширхэг энгийн хувьцаа гаргах эрхтэй бөгөөд энэ нь 2022 оны 12-р сарын 31-нд Компанийн нийтэд гаргасан ба арилжиж буй энгийн хувьцааны 2.2%-ийг төлөөлнө. “Өмчийн урамшууллын төлөвлөгөөгөөр баталсан үнэт цаас - Ирээдүйд олгогдох хувьцааны эрх”-ийг харна уу.

- (5) Төлөвлөгөөний дагуу гаргахаар нөөцөлсөн энгийн хувьцааны тоо нь ямар ч үед нийт үлдэгдэл энгийн хувьцааны 10%-тай тэнцэх эргэлтийн дээд хэмжээ байна.
- (6) ИОХЭ төлөвлөгөөний дагуу энэ тоо нь 7,500,000 буюу дээрх (а) баганад дурдсан үнэт цаасны тооноос бага буюу 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар нийтэд гаргасан ба арилжиж буй энгийн хувьцааны 0.1%-ийг төлөөлнө.

### **Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр**

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг баталж, Залгамж халааны төлөвлөгөөг орлуулахыг хувьцаа эзэмшигчдэд санал болгож байна. ХСУБХ нь Опцион, ХБХН, ГУХН болон ИОХЭ гэх хувьцаанд суурилсан урамшууллыг олгох уян хатан байдлыг олгоно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус хөтөлбөрийг баталбал хувьцаанд суурилсан урамшууллын ирээдүйд олгох бүх төрлийн урамшууллыг ХСУБХ дагуу, эсхүл зөвшөөрсний дагуу хэрэгжүүлэх бөгөөд цаашид Залгамж халааны төлөвлөгөөний дагуу урамшуулал олгохгүй. Залгамж халааны төлөвлөгөө нь зөвхөн тус төлөвлөгөөний дагуу олгосон хүчинтэй байгаа урамшууллын хувьд хүчин төгөлдөр байна. ХСУБХ-ийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр” гэх хэсгээс үзнэ үү.

## **Урамшууллын хувьцааны опционы төлөвлөгөө**

### **Танилцуулга**

2007 оны 5-р сарын 10-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит тусгай хурал дээр Хувьцаа эзэмшигчид 10%-ийн “эргэлтийн” хувьцааны опционы төлөвлөгөө (“**Опцион Төлөвлөгөө**”) баталсан. Уг төлөвлөгөөг хувьцааны опционы төлөвлөгөөний оронд 2003 оны 11-р сарын 18-ны өдөр Хувьцаа эзэмшигчид баталсан. Төлөвлөгөөг 2004 оны 6-р сарын 24, 2005 оны 6-р сарын 25-нд дахин баталгаажуулсан бөгөөд энэ нь Компанийн Энгийн хувьцаа тухайн үедээ бүртгэлтэй байсан бирж болох Торонтогийн (TSX Venture Exchange) хөрөнгийн биржийн журмын шаардлагын дагуу боловсруулагдсан. ТУЗ уг Төлөвлөгөөнд ажил олгогчийн суутган татвар болон хувьцааны опционы ашгийн шилжүүлгийн шаардлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд 2010 оны 12-р сарын 16-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Төлөвлөгөөг ТХБ-ийн аргачлалтай уялдуулан дотоод мэдээлэл эзэмшигчийн тодорхойлолтын талаар нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 5-р сарын 15-ны өдөр оруулсан. Энэхүү төлөвлөгөөтэй холбоотойгоор ТУЗ нь дээрх мэдээлэлтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийг Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авахгүйгээр оруулах боломжтой. Торонтогийн хөрөнгийн бирж (“TSX”)-ийн дүрмийн шаардлагын дагуу, Хуваарилагдаагүй опционуудыг нь өмнө нь 2010 оны 5-р сарын 20, 2013 оны 6-р сарын 27, 2016 оны 6-р сарын 14, 2019 оны 6 сарын 20-нд тус тус Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон тусгай хурлаар баталсан. Энэхүү Төлөвлөгөөний зорилго нь опционоор дамжуулан Компанийн ТУЗ-ийн гишүүд, албан тушаалтан, албан хаагчид, гэрээт үйлчилгээ үзүүлэгч нарыг тогтвортой ажиллуулах, Компанийн ашиг сонирхлын төлөө ажиллах хүсэл сонирхлыг идэвхжүүлэхэд оршино.

Дараах мэдээлэл нь Опцион Төлөвлөгөөний хураангуй хэлбэрээр ашиглагдах бөгөөд энэ нь бүхэлдээ Опцион Төлөвлөгөөг тайлбарлах буюу 2007 оны 4-р сарын 29-ний өдрийн Компанийн удирдлагын мэдээллийн танилцуулгад Хавсралт А хэлбэрээр багтсан бөгөөд ТУЗ-өөс дээр мэдээлсэн онуудад дээр дурдсанчлан нэмэлт өөрчлөлт оруулсан.

### **"Эргэлтийн" нөөцийн дээд хэмжээ**

Опцион Төлөвлөгөөнд хувьцааны опцион гаргах эргэлтийн нөөцийн дээд хэмжээ нь нийт гаргасан энгийн хувьцааны тоо хэмжээний 10%- аас ямар ч үед хэтрэхгүй байна гэж тусгасан.

### **Бусад нөхцөлүүд**

Опцион Төлөвлөгөөгөөр ТУЗ нь (эсвэл ТУЗ-ийн зөвшөөрлөөр ТУЗ-ийн Хороо) хувьцааны опционыг олгох "Эрх бүхий хүн/хүмүүс" хүмүүсийг батална. Эрх бүхий хүмүүст Компанийн ба түүний хамаарал бүхий компаниудын ТУЗ-ийн гишүүд, албан тушаалтнууд, ажилтнууд, зөвлөхүүд, толгой компанийн ажилтнууд болон бусад гэрээт үйлчилгээ үзүүлэгч нар хамаарна.

Опцион Төлөвлөгөөний дагуу нэг жилийн дотор Компанийн дотоод мэдээлэл эзэмшигчдэд олгосон Хувьцааны нийт тоо нь урамшууллын зохицуулалтад суурилсан бусад үнэт цаасны хамт нийт гаргасан Хувьцааны 10%-аас хэтрээгүй. Мөн түүнчлэн Опцион Төлөвлөгөөний дагуу, ямар ч үед Компанийн дотоод

мэдээлэл эзэмшигчдэд олговол зохих энгийн хувьцааны нийт тоо нь урамшууллын зохицуулалтад суурилсан бусад үнэт цаасны хамт нийт гаргасан энгийн хувьцааны 10%-аас хэтэрч болохгүй.

Энгийн хувьцааг олгосон огноо, тоо ширхэг, баталгаажих хугацаа болон Опцион Төлөвлөгөөний дагуу олгосон опционы бусад нөхцөлүүдийг Опцион Төлөвлөгөөнд тусгасан үндсэн заалтуудыг чиглэл болгон ТУЗ-өөс батална.

Опцион олгох үед ТУЗ-өөс өөрөөр заагаагүй бол Опцион Төлөвлөгөө ёсоор:

- (a) Опционыг худалдах үнийг TSX бирж дээр олгосон өдрөөс өмнөх 5 өдрийн арилжааны нийт хэмжээнд жигнэсэн дундаж үнээр тогтооно;
- (b) Опционы хугацаа нь олгосон өдрөөс хойш 10 жилийн хугацаатай (Опцион Төлөвлөгөөнд зааснаар байж болох хамгийн дээд хугацаа), гэхдээ дуусгавар болох хугацаа нь Компанийн бодлогын дагуу тодорхой хүмүүс, тухайлбал опцион эзэмшигч Компанийн үнэт цаасны арилжааг хийхийг түр зогсоосон (эсхүл арилжааг түр зогсоосон хугацаа дуусахаас 10 өдрийн дотор) цаг хугацаатай давхацвал, опционы дуусгавар болох хугацаа нь арилжааг түр зогсоосон цаг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрөөр автоматаар сунгагдана;
- (c) Опцион нь олгогдмогц нэн даруй баталгаажна; мөн
- (d) Опционы хугацаа дуусгавар болохоос өмнө опцион эзэмшигч нь Компанийн ажлаас шалтгаантайгаар халагдсанаас өөр бусад шалтгаанаар эрх бүхий хүнээс чөлөөлөгдвөл, опцион эзэмшигч эрх бүхий хүнээс хасагдсан өдрөөс хойш 90 өдрийн дотор опцион нь цуцлагдана; опцион эзэмшигч нас барсан тохиолдолд нас барсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд опционыг хэрэгжүүлэх эрх хэвээр хадгалагдана. Хэрэв опцион эзэмшигч нь Компанийн ажлаас шалтгаантайгаар халагдсанаас эрх бүхий хүнээс чөлөөлөгдвөл, опцион эзэмшигч эрх бүхий хүнээс хасагдсан өдрөөс шууд опцион нь хүчингүй болно.

Компанийн хувьцааг худалдан авах санал ирсэн бөгөөд энэхүү санал нь холбогдох үнэт цаасны хууль журмын дагуу Компанийн хяналтыг эзэмших үр дүнд хүрсэн тохиолдолд, опцион эзэмшигч нь үлдэгдэл опционоо хэрэгжүүлж тухайн худалдан авах саналын дагуу хувьцаагаа худалдах боломжийг олгоно; гэсэн хэдий ч хэрэв санал нь бүрэн хэрэгжээгүй, эсхүл санал тавигч нь хувьцааг хүлээж аваагүй эсхүл хувьцааны үнийг төлөөгүй бол опцион эзэмшигч нь тэдгээр Хувьцааг Компанид буцаах ёстой бөгөөд опционы нөхцөл өмнөх хэвээр хадгалагдана.

Опционыг бусад хариуцуулах ба шилжүүлэхгүй бөгөөд Опцион Төлөвлөгөөний заалтаар, Опцион Төлөвлөгөөний дагуу олгосон опционыг үнэт цаасны бонус болгон хувиргах боломжгүй.

ТУЗ нь зөвхөн холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрхийн хүрээнд Компанид эрх бүхий хүмүүс опционоо эдлэхэд нь туслах зорилгоор зээл өгөхийг зөвшөөрч болно. Зээлийн хугацаа ба нөхцөлийг ТУЗ-өөс тогтоох ба үүнд зах зээлийн ханшаар тогтоосон хүүтэй, хугацаа нь нэг жилээс хэтрэхгүй байх, Компанид зээлийн баталгаа болгож хүлээн авах хувьцааны тоо ширхэг нь зээлэх мөнгөн дүнг хувьцааны арилжааны тухайн өдрийн зах зээлийн ханшинд хуваасантай тэнцэх эсхүл үүнтэй дүйцэхүйц баталгаатай байх ба барьцаагүй олгож болно.

Опцион Төлөвлөгөө нь албан ёсны нэмэлт өөрчлөлтийн журамтай ба үүний дагуу нэмэлт өөрчлөлтийн жагсаалтыг гаргах бөгөөд TSX биржээс тусгайлан шаардаагүй бол ТУЗ нь Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл авах шаардлагагүйгээр гүйцэтгэж болно. Нэмэлт өөрчлөлтүүдийг дор дурдсан боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (a) Опционыг баталгаажуулах хугацаа ба нөхцөлийг өөрчлөх, сунгах, түргэвчлэх;
- (b) Опционыг цуцлах нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах;
- (c) Опционы дуусах хугацааг түргэвчлэх;

- (d) Компанийн засаглалын өөрчлөлттэй холбоотойгоор Опцион Төлөвлөгөөний заалтуудын дагуу тохируулга хийх шаардлагыг тодорхойлох;
- (e) Опцион Төлөвлөгөөнд тусгасан нэр томьёонд өөрчлөлт оруулах;
- (f) Опцион хэрэгжүүлэх механизмыг өөрчлөх, засах;
- (g) Опцион Төлөвлөгөөний дагуу Хувьцаа худалдан авахад Компанийн зүгээс санхүүгийн туслалцаа үзүүлэх тухай заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл хасах;
- (h) Опцион Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтуудад нэмэлт өөрчлөлт;
- (i) Опцион Төлөвлөгөөнд байгаа засах шаардлагатай хоёрдмол утгатай, алдаатай утга санаа, үг үсгийг засах “цэвэрлэх” нэмэлт өөрчлөлт оруулах;
- (j) Холбогдох хууль, дүрэм журмын заалтад нийцүүлэхийн тулд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах; мөн
- (k) Опцион Төлөвлөгөөг түр зогсоох эсхүл цуцлах.

Опцион Төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтүүдэд Хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авах шаардлагатай болохыг онцгойлон тогтоосон нөхцөлүүд:

- (a) Опцион Төлөвлөгөөний дагуу гаргах Энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх, үүнд “эргэлтийн” нөөцийн дээд хэмжээний үйл ажиллагаа хамаарахгүй;
- (b) Опцион Төлөвлөгөөний дагуу дотоод мэдээлэл эзэмшигчдэд нэг жилийн хугацаатай гаргасан эсхүл дотоод мэдээлэл эзэмшигчдэд хэзээ нэг цагт гаргах Хувьцааны нийт тоонд өөрчлөлт орж байгаа буюу цалин урамшууллын хэлбэрээр олгох бусад үнэт цаасны хамт, нийт гаргасан болон үлдэгдэл Хувьцааны 10%-аас хэтрэх өөрчлөлтийг нэмэлт өөрчлөлтөөр оруулах бол;
- (c) Опционыг хэрэгжүүлж болох үед хугацааг сунгах;
- (d) Опционы үнийг бууруулах;
- (e) Опцион Төлөвлөгөөнд оролцох боломжтой дотоод мэдээлэл эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх, өргөжүүлэх зорилгоор Эрх бүхий хүн/хүмүүсийн ангиллыг өөрчлөх;
- (f) Нэмэлт өөрчлөлт оруулах тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулах; мөн
- (g) Холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авах шаардлагатай аливаа нэмэлт өөрчлөлт.

Компанийн ИОХЭ төлөвлөгөө нь Компанийн Опцион Төлөвлөгөөний дагуу гаргах опционы тоо хэмжээнд нөлөөлөх боломжтой. Жишээлбэл, дотоод мэдээлэл эзэмшигчдэд гаргаж болох Хувьцааны дээд хэмжээ (энэ нэр томьёог TSX биржээс тодорхойлсон) нь ИОХЭ Төлөвлөгөөний дагуу байх ба Компаниас гаргах үнэт цаасанд тулгуурласан бусад урамшууллын хэлбэрээр гаргах аливаа Энгийн хувьцааны хамтаар аль ч үед нийт гаргасан ба үлдэгдэл Энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байна. *"Өмчийн урамшууллын төлөвлөгөөгөөр баталсан үнэт цаас- ИОХЭ төлөвлөгөө- ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан хувьцааны дээд хэмжээ ба үлдэгдэл"*- ийг харна уу.

### **Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөө**

2012 оны 10-р сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Хувьцаа эзэмшигчид Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөө (“ИОХЭ-ийн төлөвлөгөө”)–г баталж, 2015 оны 6-р сарын 4, 2019 оны

6 сарын 20, 2020 оны 6-р сарын 25-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. ТУЗ нь энэхүү төлөвлөгөөнд 2019 оны 6-р сарын 20-нд ахин нэмэлт өөрчлөлт оруулсан (Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталгаажуулах). 2020 оны 6 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан, төлөвлөгөөний хязгаарыг шинэчлэн, 5,000,000 ширхэг энгийн хувьцааг 7,500,000 ширхэг энгийн хувьцаа болгосон. 2019 оны 5 сарын 15-нд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авахгүйгээр ИОХЭ-ийн төлөвлөгөөнд тодорхой өөрчлөлтүүд оруулах эрхтэй бөгөөд 10%-ийн нэмэгдэл бүхий ИОХЭ-г авахаар сонгогдсон хүлээн авагчийн шаардлагуудыг хасах зэрэг нь багтсан. ИОХЭ-ийн төлөвлөгөөний зорилго нь Компани авьяаслаг, ур чадвартай ажилтнууд болон захирлуудаа хүсэл сонирхлыг нь татаж, авч үлдэх мөн Хувьцаа эзэмшигчид, захирлууд, болон ажилтнуудын эрх ашгийг нэгтгэх зорилготой. ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан ИОХЭ ("ИОХЭ") нь Компанийн бүх захирлууд болон ажилтнуудын цалин урамшууллын стратегийн нэг хэсгийг бүрдүүлдэг. ИОХЭ-ийн үнэ цэн Хувьцааны үнээс хамааран өсөх ба буурахад ИОХЭ-ээс захирлууд ба ажилтнуудын ашиг сонирхлыг Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнийн урамшууллаар холбож нэгтгэх философийг бий болгоно. Мөн түүнчлэн, Компани нь ИОХЭ-ийг бэлэн мөнгөн цалин урамшууллын зардлыг бууруулахаар ашиглах боломжтой.

### **Хураангуй**

Дараах мэдээлэл нь ИОХЭ-ийн төлөвлөгөөний хураангуй болох ба ИОХЭ-ийн төлөвлөгөөний бүрэн тайлбар мэдээллийг [www.sedar.com](http://www.sedar.com) сайтаас үзэх боломжтой.

### **Төлөвлөгөөний удирдлага**

ИОХЭ-ийн төлөвлөгөөгөөр ИОХЭ дэх жилд ногдох урамшууллыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн авах Компанийн захирлууд болон ажилтнуудыг сонгоно. ИОХЭ хүлээн авах тоо нь ИОХЭ -ийн дагуу авахаар тогтсон урамшууллын нийт дүнг TSX бирж дэх төлбөр хийх өдрөөс өмнөх арилжааны 5 өдрийн хувьцааны арилжааны тоо хэмжээнд жигнэсэн дундаж үнэнд хуваасантай тэнцүү байх ёстой ("Зах зээлийн ханш"). ИОХЭ -ийн төлөвлөгөөний дагуу жилийн урамшууллын оронд олгосон ИОХЭ нэн даруй баталгаажна.

Үүнээс гадна, Цалин урамшууллын хороо нь өөрийн эрхийн хүрээнд ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу захирлууд болон ажилтнуудад ИОХЭ-ийг урамшуулал болгон олгох эрхтэй бөгөөд энэхүү өөрийн эрхийн хүрээнд олгосон ИОХЭ-ийн урамшууллын баталгаажих хугацаа ба үе шатууд нь Цалин урамшууллын хорооны тодорхойлсноор хэрэгжинэ. Ерөнхийдөө, ИОХЭ баталгаажих хугацаа 3-аас дээш жилд тэнцүү хуваагддаг бөгөөд тухайлбал эхний 25% нь ИОХЭ олгосон өдрөөс баталгаажиж, үүнээс хойш нэг жилийн дараа удаах 25% баталгаажих гэх мэтчилэн бүрэн дуусах хүртэл үргэлжилнэ. Цалин урамшууллын хороо хяналт солигдох зэрэгт бүх болон хэсэг ИОХЭ -ийн баталгаажих хугацааг богиносгож болно.

Хэрэв ИОХЭ -ийн үлдэгдэлтэй байхад Энгийн хувьцаанд ногдол ашиг тараах тохиолдолд, ИОХЭ хүлээн авсан ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд тус бүрт хувьцааны тоонд ногдох нийт ногдол ашгийн дүнтэй тэнцэх нэмэлт ИОХЭ хуваарилах бөгөөд ийм тохиолдолд, ногдол ашиг төлөх өдрийн энгийн хувьцааны зах зээлийн үнэ ханшинд хуваасантай тэнцүү байна.

ИОХЭ тус бүр нь түүнийг хүлээн авах ТУЗ-ийн гишүүн болон ажилтны эзэмших эрхийг хадгалах бөгөөд түүнийг нас барсан, ажлаас өөрийн хүсэлтээр гарсан, тэтгэвэрт гарсан, эсхүл ажлаас халагдсаны дараа, Компанийн өөрийн сонголтоор (а) дээрхийн аль нэг тохиосон өдрийн Энгийн хувьцааны зах зээлийн ханшийг эзэмшиж байсан ИОХЭ-ийн тоогоор үржүүлсэнтэй тэнцэх бэлэн мөнгөний төлбөр, эсхүл (б) тухайн ТУЗ-ийн гишүүн ба ажилтны эзэмшиж байсан ИОХЭ-ийг төлөөлөх Энгийн хувьцааг олгох гэсэн хувилбарын аль нэгээр шийдвэрлэнэ. ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу, Компани нь татварын болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу олгогдох дүнгээс татварын суутгал хийх эрхтэй. Шаардлагатай гэж үзвэл ажлаас халагдсан өдрөөс ИОХЭ-ийн хэрэгжилтийг зогсооно.

ИОХЭ-ийн төлөвлөгөөнд оролцогч тус бүр ИОХЭ-ийн урамшуулал ба түүнийг хэрэгжүүлэх хуваарийг бүргэх данстай байна.

### **ИОХЭ-д зориулж гаргасан ба үлдэгдэл хувьцааны дээд хэмжээ**

ИОХЭ -ийн төлөвлөгөөний дагуу гаргавал зохих Хувьцааны дээд хэмжээ 7,500,000 ширхэг байна.

ИОХЭ-ийн төлөвлөгөө нь дотоод мэдээлэл эзэмшигчдэд (TSX биржээс тодорхойлсноор) олговол зохих нийт Хувьцааны дээд тоо хэмжээг, ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу Компаниас үнэт цаас хэлбэрээр бусад төрлийн урамшуулал болгон гаргах Энгийн хувьцааны хамтаар аль ч үед нийт гаргасан ба үлдэгдэл Энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байна гэж тогтоосон. Мөн түүнчлэн, дотоод мэдээлэл эзэмшигчдэд олгосон нийт Хувьцааны дээд тоо хэмжээ Компаниас үнэт цаас хэлбэрээр бусад төрлийн урамшуулал болгон гаргах Энгийн хувьцааны хамтаар нэг жилийн хугацаанд нийт гаргасан ба үлдэгдэл Энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байна.

### **Шилжүүлэх боломж**

ИОХЭ -ийг эсхүл ИОХЭ -ийн төлөвлөгөөнд хамрагдсан этгээдийн эрх ба ашиг сонирхлын аль алиныг хууль ёсны гэрээслэл буюу эзэмшигч нас барснаар өв залгамжлагчид шилжүүлэх, эсхүл хуулийн шаардлагын дагуу хөрөнгийг шилжүүлэх шаардлагатай болохоос бусад тохиолдолд бусдад шилжүүлэх боломжгүй.

### **ИОХЭ -ийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах**

ИОХЭ-ийн төлөвлөгөөнд зааснаар ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авах шаардлагагүйгээр ИОХЭ-ийн төлөвлөгөөний заалтуудад, нэмэлт өөрчлөлт оруулах үеийн хууль тогтоомжийн болон TSX биржийн дүрэм журмыг мөрдлөг болгон дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулж болох ба, үүгээр хязгаарлагдахгүй:

- (a) ИОХЭ-ийн төлөвлөгөөний заалтуудад жижиг хэмжээний “тодруулга” засвар, болон үг үсгийн буюу техникийн засвар хийх зорилгоор;
- (b) ИОХЭ-ийн төлөвлөгөөний заалтууд дахь хоёрдмол утга санаа, алдаа зэргийг засах;
- (c) ИОХЭ-ийг цуцлахтай холбоотой заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах;
- (d) Үнэт цаасны хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбоотой аливаа өөрчлөлт хийхийг зөвлөсөн эсхүл шаардлагатай болсон бол;
- (e) ИОХЭ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа нэмэлт өөрчлөлт оруулах бол; мөн
- (f) Бусад хууль тогтоомж болон TSX биржийн дүрэм журмаар Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл авахыг шаардаагүй аливаа суурь болон үндсэн нэмэлт өөрчлөлтүүд;

Гэвч:

- (g) ИОХЭ-ийн төлөвлөгөөнд оролцогчийн эрх ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй өөрчлөлтийг оролцогч бүрийн зөвшөөрлийг авахгүйгээр ИОХЭ-ийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж болохгүй;
- (h) ИОХЭ-ийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт нь Канадын Орлогын албан татварын хууль ба журмын 6801(d) хэсэг ба түүнтэй холбоотой гарч болзошгүй шаардлагыг үргэлжлүүлэн хангаж чадахгүй бол тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулж болохгүй;
- (i) TSX-ийн шаардлагын дагуу дараах нэмэлт өөрчлөлт оруулах бол Хувьцаа эзэмшигчээс заавал зөвшөөрөл авна. Үүнд:
  - a. ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргаж болох ИОХЭ -ийн дээд хэмжээг нэмэгдүүлэх бол; эсхүл
  - b. ИОХЭ-ийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай заалтад нэмэлт өөрчлөлт оруулах бол.

ИОХЭ-ийн төлөвлөгөөг түр зогсоосон бол ИОХЭ-ийн урамшууллыг нэмэлтээр болон зээлээр олгож болохгүй. Оролцогчийн данс дахь ИОХЭ-ийн үлдэгдэл нь ИОХЭ-ийн төлөвлөгөөнд заасан хугацаагаар хүчинтэй хэвээр



байна. ИОХЭ-ийн төлөвлөгөө нь уг төлөвлөгөөний дагуу олговол зохих бүх төлбөрийг барагдуулж, оролцогчийн дансан дахь бүх ИОХЭ-ийг хүчингүй болгосноор бүрэн цуцлагдсанд тооцогдоно.

### Жилийн алдагдлын түвшин

Дараах хүснэгтэд сүүлийн 3 санхүүгийн жилийн хугацаанд Опцион Төлөвлөгөөний дагуу олгосон опционууд болон ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу олгосон ИОХЭ-ийн жилийн алдагдлын түвшинг харуулсан. Жилийн алдагдлын түвшин нь тухайн санхүүгийн жилд холбогдох төлөвлөгөөний дагуу олгогдсон үнэт цаасны тоог тухайн санхүүгийн жилийн үлдэгдэл үнэт цаасны жигнэсэн дундаж тоонд хуваасан хэмжээ.

Төлөвлөгөө	Алдагдлын түвшин		
	2020	2021	2022
Төлөвлөгөө	1.8%	1.4%	1.4%
ИОХЭ төлөвлөгөө	0.5%	0.4%	0.4%

## ТУЗ-ИЙН ГИШҮҮД БА АЛБАН ТУШААЛТНУУДЫН ӨР ТӨЛБӨР

Компанийн одоогийн болон хуучин ТУЗ-ийн гишүүд, удирдах албан тушаалтнууд, ажилтнууд, эсхүл ТУЗ-д нэр дэвшигчид, холбоотон ба хамаарал бүхий компаниудын ТУЗ-ийн гишүүд ба удирдах албан тушаалтнууд эсхүл ТУЗ-д нэр дэвшигчдийн аль нь ч Компанийн хамгийн сүүлийн санхүүгийн жил эхэлснээс хойш аль ч үед Компани болон түүний охин компаниудад үнэт цаасны хууль тогтоомжид тодорхойлсон “ердийн өр төлбөр”-өөс бусад аливаа өр төлбөргүй болно.

## МАТЕРИАЛЛАГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВСАН ХҮНИЙ СОНИРХОЛ

Компанийн одоогийн болон хуучин ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх албан тушаалтнууд, ажилтнууд, эсхүл тэдгээрийн холбоотон болон хамаарал бүхий этгээдүүдийн алинд нь ч нийт үнэт цаасны 10%-иас илүү санал өгөх эрхтэй үнэт цаасыг эзэмшдэггүй, шуу болон шууд бус байдлаар хянадаггүй. 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойш хийсэн аливаа гүйлгээнд, эсхүл хийх гэж байсан гүйлгээнд, дээрх хоёр тохиолдлын алинд нь ч, Компанид болон түүний охин компаниудад шууд болон шууд бусаар материаллаг нөлөө үзүүлсэн эсхүл материаллаг нөлөө үзүүлж болзошгүй байсан аливаа материаллаг сонирхол байгаагүй.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компани нь Канадын засаглалын үйл ажиллагааны ил тод байдлын стандарт NI 58-101 ("Баримт бичиг")-ийн дагуу энэхүү Танилцуулгад компанийн засаглалын үйл ажиллагааг ил тод мэдээлэх шаардлагатай. Энэхүү Баримт бичгийг Канад Улс даяар үнэт цаасны хороо буюу түүнтэй ижил төстэй эрх бүхий байгууллагууд ("Канадын үнэт цаасны захиргааны байгууллагууд") үйл ажиллагаандаа дагаж мөрддөг.

ТУЗ нь Канадын үнэт цаасны удирдлагын компанийн сайн засаглалыг үргэлжлүүлэн хөгжүүлж байгаа зүтгэлийг дэмжиж ажилладаг. ТУЗ нь үйл ажиллагаандаа бүх талаараа хамгийн өндөр стандартыг дагаж мөрдөхийг хичээдэг.

Компани хөгжихийн хэрээр дор дурдсан засаглалын үйл ажиллагаа даган өөрчлөгдөж болно. ТУЗ нь компанийн засаглалын асуудалд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж, цаашид хяналтын механизм ба бүтцийг бий болгох шаардлагатай арга хэмжээнүүдийг авах бөгөөд илүү нэмэлт зардал гаргахгүйгээр, Хувьцаа эзэмшигчдийн өөрийн хөрөнгийн өгөөжийг бууруулахгүйгээр өөрийн үүрэг хариуцлагаа үр дүнтэйгээр үргэлжлүүлэн биелүүлэхийг эрмэлзэнэ.

## Төлөөлөн Удирдах Зөвлөл

ТУЗ нь одоогоор 8 гишүүнээс бүрдэх ба цаашид 8 гишүүнтэйгээр ажиллах саналтай байгаа бөгөөд холбогдох үнэт цаасны тухай хууль тогтоомжид зааснаар олонх нь "хараат бус" гишүүн байна. Хараат бус гишүүний

тухай тодорхойлолтоор, тус гишүүн нь Компанитай шууд ба шууд бус хамааралгүй байх ёстой бөгөөд ТУЗийн хүлээлтээр бол гишүүний хараат бус шүүмж, санал бодлоо илэрхийлэн оролцох чадвартай байх ёстой.

Тус хурлаар дахин сонгогдохоор нэр дэвшсэн хараат бус ТУЗ-ийн гишүүд нь Жон П.Бюрн, Доктор Анна Г.Биолик, Т.Лэйтон Крофт, Кеннет В.МакДоналд, Камерон МакРэй, Дэвид В.Мошер, Хедли Виддап нар юм. Петер С.Акерли нь компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал тул хараат бус гэж тооцогддоггүй.

Компани нь ТУЗ-ийг бие даасан байдлаар ажиллахыг зөвшөөрөх хангалттай бүтэц, үйл ажиллагааг бий болгохын тулд тодорхой арга хэмжээ авсан. ТУЗ-ийн дарга Лэйтон Крофт нь хараат бус гишүүн юм. ТУЗийн даргын голлох чиг үүрэг нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй байлгахад чиглэл өгч, удирдахад оршино. ТУЗ нь Компанийн удирдлагыг удирдах, хянах үүрэгтэй. Энэхүү зорилгыг биелүүлэхэд ТУЗ, удирдлага, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын үр дүнтэй харилцааг дэмжих нь чухал юм. ТУЗ-ийн дарга нь холбогдох талуудын харилцааг дэмжих, Компанийн эрх ашгийг эрхэмлэн ажиллаж буйд хяналт тавин, чиглэл өгөх үүрэгтэй.

ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараа хуанлийн улирал бүр нэгээс доошгүй удаа хуралддаг. Төлөвлөсөн уулзалтуудын хооронд шаардлагатай үед бас хуралдана. Уулзалтын давтамж, уулзалтын хэлэлцэх асуудлын мөн чанар нь Компанид байнга тулгардаг бизнесийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай байдаг. Хараат бус гишүүдэд ТУЗ-ийн хурал бүрийн төгсгөлд тусдаа уулзах боломжийг олгодог боловч хараат бус гишүүд болон хараат гишүүдийн оролцоогүй тогтмол хуваарьт уулзалтууд зохион байгуулдаггүй. ТУЗ-ийн одоогийн гишүүдийн тоонд хараат бус гишүүд олонх нь байдаг, мөн хараат бус гишүүдийн өөр бусад этгээдүүдэд тайлагнадгийг нь харгалзан үзээд, ТУЗ нь хараат бус гишүүдийг манлайлах боломжоор хангахын тулд хараат бус гишүүдэд зориулсан тусдаа хурлыг зохион байгуулж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Удирдлага нь гишүүдтэй албан бусаар мөн тогтмол харилцдаг бөгөөд тэдний мэдлэг, ур чадвар, туршлагад хамаарах асуудлаар гишүүд, зөвлөхүүдээс зөвлөгөө авдаг. Үүнээс гадна, Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын хороо, Ил тод байдлын бодлогын хороо тус бүр нь зөвхөн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

Компанийн доор дурдсан нэр бүхий ТУЗ-ийн гишүүд өөр бусад хуулийн этгээдүүдэд тайлагнадаг:

ТУЗ-ийн гишүүн	Бусад тайлагнадаг этгээд
Жон Бюрн	Morien Resources Corp. (TSX-V)
Лэйтон Крофт	Carolina Rush Corp. (TSX-V) Voltage Metals Corp. (CSE)
Камерон МакРэй	Kincora Copper Limited (TSX-V)
Дэвид Мошер	Carolina Rush Corp. (TSX-V) Pelangio Exploration Inc. (TSX-V)

2022 онд албан ёсны 6 удаагийн ТУЗ-ийн хурал хуралдсан. ТУЗ-ийн гишүүдийн тус бүрийн хурлын ирцийн бүртгэлийг дор харуулав:

ТУЗ-ийн гишүүд	Оролцсон хурлын тоо/ Гишүүн байхдаа тухайн жилд оролцсон ТУЗ-ийн хурлын тоо
Петер Акерли	6/6
Др. Анна Биолик	6/6
Жон Бюрн	4/6
Лэйтон Крофт	6/6
Кеннет МакДоналд	6/6
Камерон Макрей	6/6
Дэвид Мошер	6/6
Хедли Виддап	5/6

Үүнээс гадна, 2022 оны 1-р сарын 1-ээс хойш ТУЗ-ийн зарим шийдвэрүүдийг ТУЗ-ийн гишүүд болон удирдлагуудын дунд албан бус хэлэлцүүлгийн дараа бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр баталсан.

### ТУЗ-ийн эрх, үүрэг

ТУЗ нь Компанийн ажил хэргийг хянах, удирдах замаар дамжуулан Компанийн өмнө үүрэг хариуцлага хүлээнэ. Энэхүү үүрэгт ажлыг 5 Хороодоор дамжуулан шууд хэрэгжүүлнэ:

- (a) Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо;
- (b) Цалин урамшууллын хороо;
- (c) Дотоод хяналтын хороо; мөн
- (d) Байгууллагын засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо;
- (e) Техникийн хороо.

ТУЗ нь Компанийн урт хугацааны оршин тогтнох чадвар, ашиг орлоготой байдал, түүнчлэн ажилчдынхаа болон үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдийн эрх ашгийг хангахын төлөө эрмэлзэж ажиллана. ТУЗ-д жил бүр албан ёсоор ирүүлэх удирдлагын боловсруулсан стратеги төлөвлөлт, бизнесийн зорилтыг, мөн тогтмол хугацааны завсрын тайлангуудыг ТУЗ хянана. ТУЗ нь үндсэн эрсдэлийг тодорхойлох, ахлах менежерийг сонгох, үнэлэх, үйл ажиллагааны болон санхүүгийн чухал асуудлуудыг хянахын тулд удирдлагын багтай хамтран ажилладаг. ТУЗ нь жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, жилийн эцсийн тайлан, жилийн төсөв, түүнд оруулсан өөрчлөлт, удирдлагын итгэмжлэлийн мэдээллийн танилцуулга, материаллаг чанарын хэвлэлийн мэдээ, ээлжит удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, төсөвт тусгагдаагүй материаллаг худалдан авалт, хувьцааны опцион олгохтой холбоотой асуудлуудыг тус тус хянаж баталдаг. ТУЗ-д бичгээр үйлдсэн эрх үүргийн хуваарь буюу мандат байхгүй.

### Албан тушаалын тодорхойлолтууд

ТУЗ нь дээр дурдсан таван Хороотой. ТУЗ-ийн Хороодын дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг Хорооны дүрэмд тусгасан болно. Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын хороо, Байгууллагын засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо, Техникийн хороо тус бүрийн дарга нар Хорооны дүрэмд заасны дагуу тогтмол хуралдаж, дүрэмд заасан ажил үүргээ биелүүлж байхад анхаарах бөгөөд хорооны үйл ажиллагааны талаар ТУЗ-д тайлагнах үүрэгтэй. Дотоод хяналтын хороо шаардлагатай үед хуралдана.

Компанийн цар хүрээ харьцангуй бага учраас ТУЗ нь одоогоор ТУЗ-ийн даргын албан тушаалын тодорхойлолтыг албан ёсны болгох шаардлагагүй гэж үзэж. Компанийн цар хүрээ харьцангуй жижиг тул өнөөг хүртэл ТУЗ-ийн гишүүд ба ТУЗ-ийн дарга Лэйтон Крофт үүрэг, хариуцлагыг хоорондоо ТУЗ-ийн хуралдаанаар дамжуулан зохин ёсоор харилцаж байна үзэж байна.

ТУЗ нь Гүйцэтгэх захирлын албан тушаалын тодорхойлолтыг бичгээр боловсруулаагүй. Гэсэн хэдий ч, Гүйцэтгэх захирлын үндсэн үүрэг хариуцлага бол Компанийн үйл хэрэг, бизнесийн менежментийг бүхэлд нь хариуцахад чиглэгдэнэ. Гүйцэтгэх захирал нь Компанийн стратегийн болон үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг Зөвлөлд санал болгож, удирдлагын багийг манлайлна. Гүйцэтгэх захирал нь Компанийн бүх үйл ажиллагаанд ТУЗ-ийн өмнө шууд хариуцлага хүлээнэ.

### Чиг баримжаа олгох ба зогсолтгүй боловсрол

ТУЗ-ийн хэмжээ, мөн үйл ажиллагаа нь тогтвортой байдалтай холбоотойгоор шинээр ТУЗ-д томилогдсон гишүүнд чиг баримжаа олгох ба боловсролын талаар албан ёсны хөтөлбөр одоохондоо байхгүй. Гэхдээ Компани нь ТУЗ-ийн гишүүдэд Компанийн бизнесийн талаар, үнэт цаасны хууль, түүний мөрдлөг ба хязгаарлалтын тухай иж бүрэн мэдээллийг Компанийн бүх бодлого журмын хуулбарын хамт өгч танилцуулдаг.

Өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх нь ТУЗ-ийн гишүүд хариуцаж байгаа салбар дахь засаглалтай холбоотой аливаа өөрчлөлт шинэчлэлт, хууль ёсны шаардлага, хууль тогтоомж зэргийн талаар хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг олж авахад тусалдаг. ТУЗ нь гишүүд байнгын мэдлэг боловсролоо дээшлүүлэхийн ач

холбогдлыг үнэлдэг бөгөөд гишүүд энэ тал дээр хувийн хариуцлага хүлээх хэрэгтэйг ойлгодог. Тасралтгүй боловсролыг дэмжих үүднээс ТУЗ дараах зүйлсийг хийж болно:

- ТУЗ-ийн гишүүд өөрсдийн сургалт, боловсролын хэрэгцээг тодорхойлохыг хүсэх;
- Компанийн төсөл, үйл ажиллагаатай биечлэн танилцах;
- ТУЗ-ийн гишүүдийн албан тушаалд хамаарах сонирхож буй семинар, бага хурлуудад оролцоход нь санхүүжилтийг хариуцах;
- Чухал ач холбогдол бүхий эсхүл сүүлийн үеийн онцгой асуудлаар удирдлагын гишүүд эсхүл гадны мэргэжилтнүүдийн илтгэлд оролцох, илтгэл тавиулахыг хөхиүлэн дэмжих.

### Бизнесийн ёс зүй

2007 оны 3-р сард ТУЗ нь албан ёсны Бизнесийн ёс зүйн дүрэм ("Дүрэм")-ийг баталсан бөгөөд үүгээр, ТУЗийн гишүүд, албан тушаалтнууд, ажилтнууд тус бүр нь Дүрэмд тусгасан хэм хэмжээг мөрдөж аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнчлэн (i) ажил хэргийг шударга, ёс зүйтэй явуулах, (ii) компанийн мэдээллийн нууцлал хадгалах, (iii) сонирхлын зөрчлөөс зайлсхийх, (iv) компанийн өмч хөрөнгийг хамгаалах, зохистой ашиглах, (v) засгийн газрын холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөх, (vi) Дүрмийн зөрчлийн талаар зохих этгээдэд нь дотооддоо шуурхай мэдэгдэх, (vii) Дүрмийн дагуу хүлээх хариуцлага, (viii) Компанийн шударга үнэнч, хариуцлагатай байдлын соёл зэргийг идэвхжүүлсэн.

ТУЗ нь Дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянахгүй; гэсэн хэдий ч ТУЗ-ийн гишүүд, албан тушаалтнууд, ажилтнууд тус бүрт энэхүү Дүрмийн хуулбарыг өгсөн бөгөөд уг этгээд нь Дүрэмд заасан стандартуудыг дагаж мөрдөхийн тулд хүлээн зөвшөөрөх маягтанд гарын үсэг зурах шаардлагатай. Дүрмийн хуулбарыг SEDAR [www.sedar.com](http://www.sedar.com) дээрээс авах боломжтой. Дүрэм нь бусад зүйлийн дотроос ялангуяа, сонирхлын зөрчил, нууцлал, хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ёс зүйгүй үйлдлийн талаар мэдээлэх, нягтлан бодох бүртгэлийн зөрчлийг тайлагнах талаар тусгайлан зааж өгдөг. Аудит ба эрсдлийн удирдлагын хороонд Дүрмийн заалттай холбоотой ирүүлсэн аливаа мэдээллийг Аудит ба эрсдлийн удирдлагын хороо хянах ёстой. Үүний дараа Аудит ба эрсдлийн удирдлагын хороо мөрдөн шалгалт хийх шаардлагатай эсэхийг тодорхойлно. Хороо болон/эсвэл удирдлага нь уг мэдээллийг даруй шалгаж, үр дүнг бичгээр гаргана. Бүх мэдээлэлд аль болох бүх хүрээнд нууцлалтай хандах ёстой бөгөөд Аудит ба эрсдлийн удирдлагын хороо болон гадны зөвлөх нь мэдээлэл ирүүлсэн хүн хэн болохыг ил болгохыг хориглох ба түүний хувийн нууцыг чандлан хадгалахыг шаарддаг. Дүрэмд зааснаар аливаа мэдээлэл өгөхдөө ажлаас халагдах, сахилгын арга хэмжээ авагдах, аливаа төрлийн хариу үйлдэл ирэхээс айхгүйгээр гаргах боломжтойг тусгайлан заадаг.

ТУЗ-өөс компанийн одоогийн бүтцийн хэмжээ нь бизнесийн ёс зүйг сурталчлах, Дүрмийн биелэлтэд хяналт тавих зорилгоор албан тушаалтнууд ба ажилтнуудтай албан бус яриа хэлэлцүүлгийг зохион байгуулах нь үр дүнтэй гэж үздэг.

Үүнээс гадна, Дотоод хяналтын хороо нь компанийн ТУЗ-ийн гишүүд ба ажилтнууд, мөн тэдний гэр бүлийн гишүүдийн Компанийн үнэт цаасны арилжаанд оролцох асуудлыг Компанийн дотоод хяналтын бодлогын дагуу шалгах ажлыг хариуцдаг.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн зарим нь өөр бусад компаниудад захирал, албан тушаалтнаар давхар ажилладаг эсвэл бусад компаниудад томоохон хувьцаа эзэмшдэг. Компанийн оролцож болох төсөл эсхүл бизнест тухайн бусад компаниуд мөн адил оролцохоор болсон тохиолдолд, тухайн ТУЗ-ийн гишүүд тус үйл ажиллагаанд гэрээ хэлцэл хийх ба түүний нөхцөлийг тохиролцоход ашиг сонирхол зөрчилдөж болзошгүй. ТУЗ-ийн хуралдаан дээр ийм сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд уг зөрчилтэй гишүүн нь тухайн оролцооноос эсвэл санал хураалтад оролцохоосоо татгалзах эсхүл тухайн бизнест хэлцэл хийх, нөхцөлийг тохиролцох үйл ажиллагаанд оролцуулахаар олгосон зөвшөөрлөөс татгалзах шаардлагатай. Үүнээс гадна, гишүүн ба албан тушаалтан нь Компанитай хийсэн гэрээ хэлцэл, шилжүүлэгт хувийн ашиг сонирхол байвал энэ талаар мэдэгдэж ил болгох нь зүйтэй бөгөөд үнэт цаасны хуулиар шаардлагатай гэж үзвэл тухайн материаллаг ашиг сонирхол бүхий хэлэлцүүлэгт санал өгөхөөс татгалзах ёстой.

**ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх**

ТУЗ нь нэр дэвшүүлэх тусдаа хороогүй. ТУЗ-д нэр дэвшигчдийг тодорхойлохоор шаардлагатай үед ТУЗ нь хуралдаж, тодорхойлогдог. Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд ТУЗ-д нэр дэвшигчдийн ур чадварыг хянах, ТУЗ-д Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгохоор нэр дэвшигдэх гишүүдийн талаар өөрийн саналыг гаргах үүргийг хүлээсэн. Дээр дурдсанчлан, Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь хараат бус гурван гишүүнээс бүрддэг. Үүнд: Др. Анна Биолик, Жон П.Бюрн болон Т. Лэйтон Крофт нар багтана.

**ТУЗ болон удирдах албан тушаалтнуудын олон талт байдал**

ТУЗ нь 2015 онд олон талт байдлын бодлогыг ("Олон талт байдлын бодлого") баталсан бөгөөд ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын албан тушаалд олон талт байдлыг бий болгох ба хадгалах Компанийн арга барилыг тодорхойлсон. ТУЗ-д нэр дэвшүүлэх, удирдах албан тушаалтан томилоход тодорхой шалгууртай байх ёстой гэж Компани үздэг боловч Олон талт байдлын бодлогын зорилго нь хэлэлцүүлгийн тэнцвэртэй байдлыг дэмжих, шийдвэр гаргалтыг сайжруулахад хувь нэмэр оруулах юм. Компани нь "олон талт байдал" гэдгийг хүйс, үндэс угсаа, бие эрхтний тахир дутуу байдал, газар зүйн байршил зэрэг янз бүрийн бүлэг, хүмүүсийг ялгахад хэрэглэдэг хэмжээс хэмээн ойлгодог.

Олон талт байдлын бодлогын хүрээнд, Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь ТУЗ болон удирдлагын албан тушаалд янз бүрийн бүлгүүд, мэдлэг, үзэл бодол бүхий иргэдийг, үүнд уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсвэл үндэсний цөөнх буюу "Нэрлэсэн бүлэг"-ийг багтаан оруулахыг эрмэлзэнэ. Боломжит ТУЗ-ийн гишүүн, удирдлагын албан тушаалтнуудын мэргэшил, туршлагыг харгалзан үзэхийн хамт Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь ТУЗ-д сонгогдох, дахин сонгогдох нэр дэвшигчдийн, мөн түүнчлэн ТУЗ нь удирдах албан тушаалтнуудыг томилох шийдвэр гаргахдаа олон талт байдлын түвшинг харгалзаж үзэх болно. Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хамаарах шалгуурыг боловсруулж, мөрдөх бөгөөд Олон талт байдлын бодлогын зорилгод хүрэхийн тулд ТУЗ-ийн гишүүдийг ажилд авах протоколыг боловсруулах үүрэгтэй.

2015 оноос эхлэн Компани нь үйл ажиллагаанд хяналт тавих, ТУЗ-ийн залгамж чанарыг сайжруулахад чиглэн, туршлага, мэдлэг чадвар, олон талт байдлыг төлөөлөх зэрэгт онцгой анхаарч ажиллаж байна. ТУЗ-ийн хувьд Компанийн үйл ажиллагааны тэргүүн зорилго нь стратеги болон эрсдийн хяналтын чиглэлээр хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг үр дүнтэйгээр хангах, хэтийн төлөв болон байгууллагын тасралтгүй байдлыг тэнцвэртэй ханган ажиллахад оршино. ТУЗ-ийн гишүүд тэтгэвэрт гарах төлөвлөгөөнөөс үүдэн 2015 оноос Компани нь зургаан шинэ гишүүнийг нэмж ажиллуулж байна. Зургаан гишүүний нэг нь нэрлэсэн бүлгийн гишүүн бөгөөд бүх гишүүд нь уул уурхайн болон санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай, өндөр түвшний мэдлэгтэй. Түүнээс гадна, 2020 оны 12-р сард ТУЗ нь Монгол Улсын уул уурхайн салбарт тэргүүлэгч болох зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зөвлөх хороог байгуулсан. Зөвлөх хорооны анхны гишүүнээр Монгол Улсын иргэн, уул уурхайн салбарт арвин туршлагатай, дэлхийн хэмжээний эрдэмтэн Др.А.Ундрааг томилсон. Түүний үүрэг хариуцлагын нэг нь тус хороонд хамтарч ажиллах чадварлаг боловсон хүчнийг тодорхойлж, гишүүнээр томилоход дэмжлэг үзүүлэх юм.

Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь нэр дэвшүүлэх, томилох үйл явцын үр дүнд тогтмол үнэлгээ хийх, түүнчлэн Олон талт байдлын бодлогын үр дүнтэй байдлыг үнэлж, Олон талт байдлын бодлогын хэрэгжилтийг хянах болно. Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь шаардлагатай тохиолдолд дээрх асуудлуудын талаар ТУЗ-д танилцуулга хийх, тайлан хүргүүлдэг.

ТУЗ нь одоогоор ТУЗ дахь эсвэл удирдах албан тушаал дахь нэрлэсэн бүлэгтэй холбоотой зорилтуудыг дэвшүүлээгүй байна. ТУЗ болон удирдлага бүтцийн хувьд жижиг, үйл ажиллагааны эхэн үе шатанд явж байгаа тул санал болгож буй шинэ ТУЗ-ийн гишүүд эсвэл удирдах албан тушаалтнуудын мэргэшил, туршлагаас сонгон шалгаруулах үйл явцад гол анхаарлаа хандуулах шаардлагатай гэж ТУЗ үзэж байна.

Энэхүү танилцуулга гарсан өдрийн байдлаар ТУЗ-д дахин нэр дэвшиж байгаа найм (8), гүйцэтгэх удирдлагын таван (5) гишүүн байна. ТУЗ-д нэр дэвшиж буй найман гишүүнээс нэг нь (12%), гүйцэтгэх удирдлагын гишүүдийн нэг (20%) эмэгтэй хүн байна. Компанийн ТУЗ-ийн гишүүдээс нэг нь ч (0%) нэрлэсэн бүлгийн гишүүн биш бөгөөд гүйцэтгэх удирдлагын нэг гишүүн (20%) нэрлэсэн бүлгийн гишүүн болно.

**ТУЗ-ийн гишүүдийн албан тушаалын хугацааны хязгаар**

ТУЗ нь гишүүдэд хугацааны хязгаар тогтоодоггүй бөгөөд ТУЗ-ийн шинэчлэлтэй холбоотой аливаа бусад механизмыг батлаагүй байна. ТУЗ-ийн цар хүрээ бага, Компанийн үйл ажиллагааны үе шатаас шалтгаалан, Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хорооноос жил бүр хийдэг үнэлгээ нь ТУЗ-ийн бүтэц нь зохистой байгааг дүгнэх үр дүнтэй тогтолцоо гэж үздэг. ТУЗ нь 5 жил тутамд багадаа нэг удаа, ТУЗ-ийн бүрэлдэхүүн ур чадвар, нас, хүйс, бусад ялгаатай байдал нь зорилго зорилтын хэрэгцээг хангаж байгаад итгэлтэй байхын тулд хэрэв шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт хийх шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

**Цалин урамшууллын хороо**

Цалин урамшууллын хорооны эрх үүрэг нь Компанийн удирдах албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэл, цалин урамшуулал, залгамж халааны төлөвлөлтийг хянан үзэж, Төлөвлөгөөний бүрэн хэрэгжилтийг хангахад оршино. Цалин урамшууллын хороо нь Гүйцэтгэх захиралтай хамтран ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын түвшинг бусад олон нийтэд хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг компаниудын бизнесийн харьцуулалтад үндэслэн ТУЗ-д санал оруулна. Энэ хороо нь удирдах албан тушаалтнуудын тэтгэмжийн төлөвлөгөө болон шаардлагыг хянаж ТУЗ-өөр батлуулахаар саналаа ирүүлэх үүрэгтэй. Цалин урамшууллын хороо нь жилд дунджаар хоёр удаа хуралддаг.

Цалин урамшууллын хороо нь одоогоор гурван гишүүдээс бүрддэг, үүнд н.МакДоналд, н.Мошер, н.Виддап багтдаг бөгөөд бусад хүмүүс нь NI-52-110-д заасны дагуу хараат бус гишүүд юм.

**Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо**

Компанийн Аудит ба эрсдэлийн удирдлагын хороотой холбоотой мэдээллийг 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхтгэл ("AIF") хэсэгт дэлгэрэнгүй багтаасан. Эмхтгэлийн хуулбарыг SEDAR [www.sedar.com](http://www.sedar.com) вэбсайт дахь Компанийн олон нийтэд мэдээлэх баримт бичгээс авч болно.

Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо нь жилд 4 удаа хуралддаг. Аудит ба эрсдэлийн удирдлагын хороо одоогийн байдлаар NI 52-110-г тодорхойлсноор хараат бус дөрвөн гишүүн буюу н.Бюрн, н.Крофт, н.МакДоналд ба Др. Биолик нарын бүрэлдэхүүнтэй байна.

**Дотоод хяналтын хороо**

Дотоод хяналтын хороо нь компанийн ТУЗ-ийн гишүүд ба ажилтнууд, мөн тэдний гэр бүлийн гишүүдийн Компанийн үнэт цаасны арилжаанд оролцох асуудлыг Компанийн дотоод хяналтын бодлогын дагуу урьдчилан шалгах ажлыг хариуцдаг.

Дотоод хяналтын хороо нь үнэт цаасны арилжаанд орох хүсэлтийг баталдаг. Дотоод хяналтын хороо нь одоогоор хоёр захирал н.Акерли, н.Женкинс нараас бүрдэж байна.

**Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо**

Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь мэдээлэл түгээх, ил тод байдлын хуулийн шаардлагууд болон Компанийн ил тод байдлын бодлого журам, Дотоод мэдээлэл эзэмшигчдийн арилжаанд оролцох бодлогын биелэлтийг хянах үүрэгтэй. Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь мэдээлэл түгээх, ил тод байдлын талаарх зохих тогтолцоо, үйл явц, хяналт шалгалтыг хангах үүрэгтэй бөгөөд бүх хэвлэлийн мэдээлэл болон олон нийтэд ил байлгах үндсэн бичиг баримтуудыг нийтэд дэлгэх, болон тайлагнахын өмнө нягтлан хянах үүрэгтэй.

Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь жилд дунджаар нэг удаа хуралддаг. Тус Хороо нь одоогоор н.Бюрн, н.Крофт, Др.Биолик нараас бүрддэг ба NI 52-110-д тодорхойлсноор хараат бус гишүүд юм.

**Техникийн хороо**

Техникийн хороо нь хайгуул, хөгжүүлэлт, тусгай зөвшөөрөл, эрдсийн талбайн нөөц болон уурхайн техник, үйл ажиллагаатай холбоотой асуудлуудад ТУЗ-д танилцуулахаас өмнө техникийн хяналт тавьж, удирдлагад дэмжлэг үзүүлдэг. Техникийн хороо нь одоогоор гурван гишүүнээс бүрдэнэ. Үүнд н.Акерли, н.МакРэй, н.Хэдли (Хорооны дарга) нарын бүрэлдэхүүнтэй бөгөөд бүгд уул уурхай, хайгуулын салбарт олон жил



ажилласан туршлагатай удирдах албан тушаалтнууд юм. Техникийн хороо нь шаардлагатай үед хуралдаан зохион байгуулдаг.

### Бусад хороо

ТУЗ аль ч цаг үед шинээр Хороо үүсгэн байгуулах эсхүл бизнесийн тусгай асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор онц яаралтай түр хороо байгуулж болно.

### Үнэлгээ

Компанийн Засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, хороодын үр ашигтай байдлын үнэлгээ хийх үйл явцыг хөгжүүлэх, мөн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах үүрэгтэй. Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо нь жил бүр Үнэлгээний үйл явцыг зохион байгуулж, ТУЗ-д гарсан үр дүнг тайлагнадаг бөгөөд үүгээр гарсан аливаа асуудлыг шийдвэрлэдэг. Энэ зорилгоор тусгай хурал зарлан хуралдуулахгүйгээр, ТУЗ ба түүний Хорооны гишүүд тус бүр ТУЗ-ийн үр ашигтай байдлын үнэлгээг тогтсон хугацаанд Удирдлагын санаа бодлыг оруулан хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн ТУЗ-ийн гишүүн бүр аливаа гарсан асуудлыг Компанийн засаглал, мэдээлэл түгээх бодлогын хороо эсхүл ТУЗ-д дэвшүүлэх эрхтэй.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ

Канадын Бизнесийн Байгууллагуудын журамд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ирэх жилийн ээлжит хурал дээр шийдүүлэхээр өргөн барих шийдвэр тогтоолын төслүүд нь Канадын Бизнесийн Байгууллагуудын журмын заалтуудад нийцсэн байх ёстой бөгөөд ирэх жилийн ээлжит хурлын удирдлагын мэдээллийн танилцуулгад оруулахын тулд 2024 оны 2-р сарын 20-ны Мягмар гарагаас хэтрэлгүй Компанийн төв оффист хүргүүлсэн байх шаардлагатай.

### НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Компанитай холбоотой аливаа нэмэлт мэдээлэл нь SEDAR, [www.sedar.com](http://www.sedar.com) дахь Компанийн хуудсанд тавигдсан. Хамгийн сүүлийн жилийн санхүүгийн тайлан болон удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээнд компанийн санхүүгийн мэдээллүүд багтсан. Дээрх мэдээллийг Компанийн Suite 1480, 99 Wyse Road, Dartmouth, Nova Scotia, B3A 4S5 хаяг болон утас (902) 423-6419, email: [info@erdene.com](mailto:info@erdene.com)-оор Даррин Бродерик-тэй холбогдон авна уу. Мөн санхүүгийн тайлан болон удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ нь SEDAR, [www.sedar.com](http://www.sedar.com)-д тавигдсан болно.

### ТАНИЛЦУУЛГЫГ ЗӨВШӨӨРСӨН

Энэхүү мэдээллүүд нь Компанийн ТУЗ-өөр хүлээн зөвшөөрөгдсөн.

Нова Скошиа муж, Халифакс хот, 2023 оны 5-р сарын 19.

*(гарын үсэг зурав) Петер К.Акерли*

Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал

Энэхүү материал нь англи хэл дээр бэлтгэгдсэн материалын орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

Хавсралт “А”

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр

**ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ**  
**ХУВЬЦААНД СУУРИЛСАН УРАМШУУЛЛЫН БАГЦ ХӨТӨЛБӨР**

**2023 оны 5 сарын 17**

## ГАРЧИГ

### Хуудас

1	НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ЗОРИЛГО.....	1
1.1	Зорилго .....	1
2	ХОЁРДУГААР ЗҮЙЛ ТАЙЛБАР .....	1
2.1	Тодорхойлолт .....	1
2.2	Тайлбар .....	10
3	ГУРАВДУГААР ЗҮЙЛ УДИРДЛАГА .....	11
3.1	Удирдлага .....	11
3.2	Хороогоор төлөөлүүлэх .....	12
3.3	Шийдвэр хүчин төгөлдөр байх.....	12
3.4	Оролцох эрх.....	12
3.5	Хөтөлбөрийн зохицуулагчийн шаардлага.....	12
3.6	Урамшууллаар олгох нийт хувьцаа .....	13
3.7	Урамшуулал олгоход тавих хязгаарлалт .....	13
3.8	Урамшууллын гэрээ.....	14
3.9	Урамшууллыг шилжүүлэхгүй байх .....	14
4	ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ОПЦИОН.....	15
4.1	Опцион олгох .....	15
4.2	Хэрэгжүүлэх үнэ .....	15
4.3	Опционы хугацаа .....	15
4.4	Эзэмшүүлэх ба хэрэгжүүлэх.....	15
4.5	Хэрэгжүүлэх үнийн төлбөр.....	16
5	ТАВДУГААР ЗҮЙЛ ХЯЗГААРЛАЛТ БҮХИЙ ХУВЬЦААНЫ НЭГЖ.....	16
5.1	ХБХН-ийг олгох .....	16
5.2	ХБХН-ийн данс.....	17
5.3	ХБХН-ийг эзэмшүүлэх.....	17
5.4	ХБХН-ийн тооцоо хийх .....	17
6	ЗУРГААДУГААР ЗҮЙЛ ГҮЙЦЭТГЭЛД УЯЛДСАН ХУВЬЦААНЫ НЭГЖ .....	18
6.1	ГУХН олгох.....	18
6.2	ГУХН-ийн нөхцөл болзол.....	18
6.3	Гүйцэтгэлийн зорилт .....	18
6.4	ГУХН-ийн данс.....	18
6.5	ГУХН-ийг эзэмшүүлэх.....	19
6.6	ГУНХ-ийн тооцоо хийх.....	19
7	ДОЛООДУГААР ЗҮЙЛ ИРЭЭДҮЙД ОЛГОГДОХ ХУВЬЦААНЫ ЭРХ .....	19
7.1	ИОХЭ-ийг олгох .....	19
7.2	ИОХЭ -ийн данс ба Урамшууллын гэрээ .....	21
7.3	ИОХЭ-ийг эзэмшүүлэх .....	21
7.4	ИОХЭ-ийн тооцоо хийх .....	21
7.5	Нэмэлт төлбөр, олговор байхгүй тухай .....	22

8	НАЙМДУГААР ЗҮЙЛ УРАМШУУЛЛЫН НЭМЭЛТ НӨХЦӨЛ .....	22
8.1	Ногдол ашигтай дүйцүүлэх.....	22
8.2	Арилжааг түр зогсоох үе.....	22
8.3	Татвар суутган авах .....	22
8.4	Нөхөн төлүүлэх.....	23
9	ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА ЭСВЭЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦУЦЛАХ	23
9.1	Ажилтан, Зөвлөх, ТУЗ-ийн гишүүний хөдөлмөрийн харилцааг цуцлах.....	23
9.2	Түргэвчлүүлэх зөвшөөрөл олгох эрх хэмжээ.....	26
10	АРАВДУГААР ЗҮЙЛ КОРПОРАЦИД НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ ЯВДАЛ .....	26
10.1	Ерөнхий зүйл.....	26
10.2	Хяналт өөрчлөгдөх .....	26
10.3	Корпорацийн хөрөнгийг өөрчлөн зохион байгуулах .....	27
10.4	Корпорацид нөлөөлөх бусад үйл явдал .....	28
10.5	Урамшууллыг нэн даруй эзэмшүүлэх.....	28
10.6	Корпораци нэмэлт хувьцаа гаргах .....	28
10.7	Бутархай хувьцаа .....	28
11	АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ АНУ-ЫН ТАТВАР ТӨЛӨГЧ.....	28
11.1	АНУ-ын татвар төлөгчдөд хамааралтай заалт .....	28
11.2	УХО.....	29
11.3	10% хувьцаа эзэмшигчдэд олгох УХО .....	29
11.4	УХО-ын жилийн \$100,000 хязгаарлалт .....	29
11.5	Шаардлага хангахгүй захиран зарцуулалт .....	29
11.6	Хуулийн 409А хэсэг .....	30
11.7	АНУ-ын Татвар төлөгчдөд 11-р зүйл үйлчлэх талаар.....	31
12	АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ.....	31
12.1	Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, цуцлах .....	31
12.2	Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл.....	31
12.3	Зөвшөөрөгдсөн нэмэлт өөрчлөлт .....	32
13	АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ БУСАД ЗҮЙЛ.....	32
13.1	Хуулийн шаардлага .....	32
13.2	Бусад олговор байхгүй талаар .....	32
13.3	Оролцогчийн эрх.....	33
13.4	Байгууллагаас авах арга хэмжээ.....	33
13.5	Зөрчилдөөн.....	33
13.6	Хэджингийн эсрэг бодлого .....	33
13.7	Оролцогчийн мэдээлэл.....	33
13.8	Хөтөлбөрт оролцох.....	33
13.9	Олон улсын Оролцогчид.....	34
13.10	Эрх залгамжлал.....	34
13.11	Шилжүүлэгт тавих ерөнхий хориг.....	34
13.12	Тус тусдаа үйлчлэл.....	34
13.13	Мэдэгдэл.....	34
13.14	Хүчин төгөлдөр болох өдөр.....	34
13.15	Үйлчлэх хууль.....	35
13.16	Харьяалал .....	35

## Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци

### Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр

#### 1 НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ЗОРИЛГО

##### 1.1 Зорилго

Корпораци (“Эрдэнэ Ресурс”, “компани”) болон түүний охин компаниудад буй чадварлаг ТУЗ-ийн гишүүд, Ажилтнууд ба Зөвлөхүүдийг татах, тэдгээрийг идэвхжүүлэх, урт хугацаанд хамтран ажиллах, Корпорацийн урт хугацааны зорилго болон амжилтад оруулсан хувь нэмрийг нь ТУЗ-өөс тухай бүр үнэлж уг Хөтөлбөрийн дагуу урамшуулах, мөн тэдгээр ТУЗ-ийн гишүүд, Ажилтнууд ба Зөвлөхүүд нь хувьцаа эзэмших замаар урт хугацааны хөрөнгө оруулалт хийж, өмчийн эзэн болох боломжийг бүрдүүлэх нь энэхүү Хөтөлбөрийн зорилго юм. Уг Хөтөлбөр нь Залгамж халааны төлөвлөгөө (дор тодорхойлсон)-ний дагуу олгосон хувьцаанд суурилсан урамшуулалд хамаарахгүй. Залгамж халааны төлөвлөгөө нь цаашид зөвхөн тухайн хөтөлбөрийн дагуу өмнө олгосон урамшууллын эрхийг эзэмшүүлэх, хэрэгжүүлэх асуудлыг зохицуулах чиг үүрэгтэй байна. Залгамж халааны төлөвлөгөөний дагуу дахин хувьцаанд суурилсан урамшуулал олгохгүй бөгөөд өмнө уг хөтөлбөрийн дагуу олгосон урамшууллыг бүхэлд нь хэрэгжүүлсэн эсхүл цуцалсан даруй тус Залгамж халааны төлөвлөгөөний үйлчлэл дуусгавар болж, хүчингүй болно.

#### 2 ХОЁРДУГААР ЗҮЙЛ ТАЙЛБАР

##### 2.1 Тодорхойлолт

Агуулгад өөрөөр бичигдсэнээс бусдаар энэхүү Хөтөлбөрт ашигласан доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно:

**“Харилцан хамааралтай этгээд буюу Affiliate”** гэж Канадын Үнэт Цаасны Захиргааны байгууллагын тухай бүр өөрчлөлт оруулсан Үндэсний Баримт Бичиг 45-106 - *“Үнэт Цаасны Танилцуулгын чөлөөлөх нөхцөлүүд”*-д тодорхойлсон “харилцан хамааралтай этгээд”-ийг хэлнэ.

**“Урамшуулал буюу Award”** гэж энэхүү Хөтөлбөрийн дагуу олгох Опцион, Хязгаарлалт бүхий хувьцааны нэгж, Гүйцэтгэлтэй уялдсан хувьцааны нэгж, Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг хэлэх ба эдгээрийг Хувьцаа, бэлэн мөнгөөр, эдгээрийн холимог байдлаар, эсхүл Хөтөлбөрийн Зохицуулагчийн үзэмжээр тогтоосон бусад хэлбэрээр илэрхийлж, хэрэгжүүлж болно.

**“Урамшууллын гэрээ буюу Award Agreement”** гэж Хөтөлбөрийн Зохицуулагчийн баталсан загвараар Оролцогч болон Корпорацийн хооронд бичгээр байгуулж гарын үсэг зурсан гэрээг хэлэх ба түүнд Урамшууллыг олгосон болзол нөхцөлийг тодорхойлсон байна. Энэхүү гэрээ нь бусад ижил төрлийн гэрээтэй адил байх албагүй.



**“Арилжааг царцаах үе буюу Blackout Period”** гэж (i) тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа Корпорацийн бичгээр гаргасан бодлого, эсхүл (ii) Корпорацийн ахлах ажилтан, захирлаас Оролцогчид бичгээр хүргүүлсэн мэдэгдэлд заасны дагуу Корпорацийн үнэт цаасны арилжааг царцаасан үеийг хэлнэ.

**“ТУЗ буюу Board”** гэж тухай бүр томилогдох Корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлийг хэлнэ.

**“Ажлын өдөр буюу Business Day”** гэж Бямба, Ням болон Халифакс, Нова Скошиагийн хуулиар тогтоосон баярын өдрөөс бусад өдрийг хэлнэ.

**“Бэлэн төлбөр буюу Cash Fees”** гэж 7.1(a) хэсэгт заасныг хэлнэ.

**“Бэлэн бусаар хэрэгжүүлэх буюу Cashless Exercise”** гэж 4.5(b) хэсэгт заасныг хэлнэ.

**“Шалтгаан буюу Cause”** гэж тодорхой Оролцогчийн хувьд дараах зүйлсийг хэлнэ:

- (a) “шалтгаан” (бусад төсөөтэй нэр томъёо)-ыг Корпораци, түүний охин компани болон Ажилтан хооронд байгуулсан хөдөлмөрийн ба бусад бичгээр байгуулсан гэрээнд тодорхойлсноор ойлгоно,
- (b) хэрвээ Корпораци, түүний Охин компанитай хөдөлмөрийн болон бусад гэрээ бичгээр байгуулаагүй, эсхүл “шалтгаан” (бусад төсөөтэй нэр томъёо)-ыг тэдгээр гэрээнд тодорхойлоогүй бол Урамшууллын гэрээнд тодорхойлсноор ойлгоно,
- (c) хэрвээ дээрх (a) эсхүл (b)-д заасны дагуу тодорхойлох боломжгүй бол хуульд зааснаар тодорхойлох ба хэрвээ ийнхүү тодорхойлоогүй бол (i) ажил олгогчийн зүгээс хөдөлмөрийн гэрээг аливаа мэдэгдэл, төлбөр, хохирол олгохгүйгээр цуцлах, эсхүл (ii) Корпораци, охин компани нь Оролцогчийн гэрээг аливаа мэдэгдэл, цуцалсны төлбөр, хохирлыг олгохгүйгээр цуцлах шалтгаан нөхцөл байдлыг хамааруулан ойлгоно.

**“Хяналт өөрчлөгдөх буюу Change in Control”** гэж дараах тохиолдлууд дангаараа эсхүл хамтдаа бий болохыг хэлнэ:

- (a) Худалдан авах, үнэт цаас хөрвүүлэх, Корпорацийг аливаа бусад этгээдтэй нэгтгэх, хөрөнгийг дахин хуваарилах эсхүл аливаа бусад бизнесийн нэгдэл, өөрчлөх зохион байгуулах зэрэг үйл ажиллагааны дүнд аливаа Этгээд эсхүл хоёр ба түүнээс дээш тооны этгээдүүдэд хамтран Корпорациас гаргаж, эзэмшүүлэх саналын эрхтэй үнэт цаасны 50-аас дээш хувийн “эцсийн өмчлөл” (Нова Скошиа) (Үнэт цаасны хуульд тодорхойлсон)-ийг шууд болон шууд бусаар, эсвэл Хяналт хэрэгжүүлэх буюу удирдлагын эрхийг олж авах аливаа хэлцлийг,
- (b) Корпорацийн охин компаниас бусад этгээдэд Корпорацийн нэгтгэсэн хөрөнгийг бүхлээр нь эсхүл хөрөнгийн дийлэнхийг худалдсан, эрхийг шилжүүлсэн болон бусад байдлаар шилжүүлснийг,

- (c) Корпорацийг татан буулгах. Үүнд: тухайн үйл явдлаас өмнө Корпорацийн хөрөнгийг Корпорацийн аливаа харилцан хамааралтай этгээд болох нэг (1) эсхүл түүнээс дээш этгээдэд хуваарилах орохгүй,
- (d) Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр батлах шаардлагатай Корпорацийг нэгтгэх, нийлүүлэх, хувьцаа солилцох, хөрөнгийг худалдах, хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулах болон бусад байдлаар аливаа бусад этгээд худалдан авах хэлцэл хийхийг (богино хэлбэрийн нэгдэл болон Корпорацийн охин компанитай хувьцаагаа солилцох хамаарахгүй),
- (e) Аливаа шалтгаанаар одоогийн ТУЗ-ийн гишүүдийг бүрдүүлж буй хувь хүмүүс (“**Эрх бүхий ТУЗ**” гэх) ТУЗ-ийн олонхыг бүрдүүлэхээ больсон. Хэрвээ шинэ гишүүнийг томилох, эсхүл томилохоор Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн гишүүнийг Эрх бүхий ТУЗ-ийн дийлэнхийн саналаар баталсан бол шинэ гишүүнийг Эрх бүхий ТУЗ-ийн гишүүн гэж үзнэ.
- (f) ТУЗ-өөс Корпорацийн хяналтын өөрчлөлт гэж тодорхойлон үзсэн аливаа бусад үйл явдлыг хэлнэ.

Дээрх (a), (b), (c) ба (d) хэсэгт зааснаас үл хамааран, хэрвээ (a), (b), (c) ба (d) хэсэгт заасан хэлцлүүдийн дараа доорх нөхцөл байдал бий болсон бол Хяналт өөрчлөгдөх үйл явдал болсон гэж үзэхгүй. Үүнд: (A) хэлцэл хийхийн өмнө тухайн үеийн гаргасан хувьцааны 50%-аас дээш саналын эрхийг эзэмшдэг бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг томилох эрхтэй Корпорацийн үнэт цаас эзэмшигчид (х) тухайн хэлцлийн дараах этгээд (“**Залгамжлан авсан этгээд**”)-ийн үнэт цаасыг эзэмшдэг (дээрх (b)-д заасан Корпорацийн хөрөнгийг шилжүүлэн авсан этгээдийг үүнд оруулан тооцно) ба тухайн үнэт цаас нь Залгамжлан авсан этгээдийн тухайн үед гаргасан хувьцааны 50%-аас дээш саналын эрхийг илэрхийлж, ТУЗ-ийн гишүүд, хөрөнгө итгэмжлэгчийг томилох эрхтэй (**санал өгөх эрх хэмжээ**) байгаа бол, эсхүл (y) Залгамжлан авсан этгээдийн ТУЗ-ийн гишүүд, хөрөнгө итгэмжлэгчийг томилох саналын эрхтэй үнэт цаасны эцсийн өмчлөлийг 100% шууд болон шууд бусаар эзэмшдэг (**Толгой компани**) бөгөөд Толгой компанийн ТУЗ-ийн гишүүд ба хөрөнгө итгэмжлэгчийг томилох саналын эрх буюу тухайн үед гаргасан үнэт цаасны санал өгөх эрхийн 50-аас дээш хувийг илэрхийлэх үнэт цаасыг эзэмшиж байвал (B) аливаа Этгээд, эсхүл хоёр (2) ба түүнээс дээш Этгээд хамтаараа Толгой компани (хэрвээ Толгой компани байхгүй бол Залгамжлан авсан этгээдийн)-ийн саналын эрхийн 50%-аас дээш эрхийг шууд болон шууд бусаар эзэмшдэг эцсийн өмчлөгч биш бол (дээрх (A) ба (B) хэсэгт заасан аливаа хэлцлийг “**Шаардлага хангаагүй хэлцэл**” гэх ба Шаардлага хангаагүй хэлцлийн дараа “Корпораци”-ийн Хяналт өөрчлөгдөх гэх тодорхойлолтыг “Толгой Компани”-ийн (хэрвээ Толгой компани байхгүй бол Залгамжлан авсан этгээдийн) гэж ойлгох ба хэрвээ тухайн этгээд нь компани буюу хөрөнгө итгэмжлэгч бол “ТУЗ” гэдгээр тухайн этгээдийн ТУЗ-ийн гишүүд, хөрөнгө итгэмжлэгчийг төлөөлүүлэн ойлгоно).

Дээр дурдсаныг үл харгалзан, (Хуулийн 409А зүйлд дурдсан утгаар) “ирээдүйд олгогдох урамшуулал” нөхцөлтэй бөгөөд Хяналт өөрчлөгдөхөд хүчин төгөлдөр болох, эсхүл урагшлуулах нөхцөлтэй Урамшууллын хувьд АНУ-ын Татвар төлөгч

аливаа Оролцогчид олгосон Урамшууллын хувьд уг хэлцлийг Хяналт өөрчилсөн гэж тооцохгүй. Гэхдээ Хуулийн 409А зүйлд дурдсан утгаар “хяналт өөрчлөгдөх үйл явдал” бий болсон гэж үзвэл дээр дурдсаныг тооцно.

“**Хууль буюу Code**” гэж тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлтийг багтаагаад 1986 оны Америкийн Нэгдсэн Улсын Дотоод Орлогын тухай Хуулийг хэлнэ. Хуулийн аливаа зүйл заалтыг эшилсэн нь тухайн хуультай холбоотой бусад зохицуулалтыг эшилсэнд мөн адил тооцогдоно.

“**Хороо буюу Committee**” гэж 3.2 дахь хэсэгт заасан утгатай;

“**Зөвлөх буюу Consultant**” гэж Ажилтан, ТУЗ-ийн гишүүдээс бусад Корпораци ба Корпорацийн аливаа Охин компани бизнесийн болон зөвлөх үйлчилгээ авахаар цалинтай эсэхээс үл хамааран ажиллуулж буй хувь хүн, хуулийн этгээд (Корпорацийн Охин компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтныг оруулаад)-ийг хэлнэ. Америкийн Нэгдсэн улсад байгаа эсхүл Урамшуулал авах, Урамшууллын гэрээ байгуулах үед АНУ-ийн Этгээд гэж тооцогдох Зөвлөх нь Хөтөлбөрийн зохицуулагчаас өөрөөр тогтоосноос бусад тохиолдолд хувь хүн байх ёстой бөгөөд Корпораци, охин компанид бодитоор үйлчилгээ үзүүлэх ёстой ба тухайн үйлчилгээ нь хөрөнгө нэмэгдүүлэх хэлцлийн дагуу үнэт цаас санал болгох, худалдахтай болон Корпорацийн үнэт цаасыг шууд болон шууд бусаар сурталчлах, зах зээлийг барихтай холбоогүй байна.

“**Тасралтгүй ажилласан байдал буюу Continuous Service**” гэж Оролцогч нь Корпораци эсхүл түүний аль нэг охин компанид ТУЗ-ийн гишүүн, Ажилтан эсхүл Зөвлөхийн хувиар ямар нэг тасалдалгүй, зогсолтгүй ажилласан байдлыг ойлгох бөгөөд тодруулбал Оролцогч нь Корпораци эсхүл түүний аль нэг охин компанид ТУЗ-ийн гишүүн, Ажилтан эсхүл Зөвлөхөөр ажилласан ажил, албан тушаалд өөрчлөлт орсон, эсхүл тухайн хуулийн этгээдийн бүтцэд өөрчлөлт орсныг Оролцогчийн тасралтгүй ажилласан байдал тасалдсан гэж үзэхгүй буюу энэ тохиолдолд ажилласан байдалд тасалдаагүй, зогсоогүй гэж үзнэ;

“**Хяналт буюу Control**” гэж аливаа Этгээд нөгөө Этгээдийг “хяналтдаа байлгах” дараах харилцааг хэлнэ. Үүнд:

- (a) аливаа Этгээд болон Корпорацийн харилцаанд хэрэглэгдэж байгаа бол тухайн Корпорацийн саналын эрх бүхий үнэт цаас болон бусад ашиг сонирхлын эцсийн өмчлөлийг шууд болон шууд бусаар эзэмшихийг хэлэх бөгөөд тухайн Корпорацийн үйл ажиллагааг хянах, удирдан чиглүүлэх эрх хэмжээтэй байна.
- (b) аливаа Этгээд болон нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, хөрөнгө итгэмжлэл, хамтарсан компанийн харилцаанд хэрэглэгдэж байгаа бол тухайн нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, хөрөнгө итгэмжлэл, хамтарсан компанийн үйл ажиллагааг гэрээний дагуу удирдах эрхийг хэлнэ.
- (c) Хөрөнгө итгэмжлэлийн харилцаанд хэрэглэгдэж байгаа бол тухайн хөрөнгө итгэмжлэлийн дагуу тухайн үед зохицуулах хөрөнгийн 50-аас дээш хувийн эцсийн өмчлөлийг хэлнэ.

“Хяналтад байгаа”, “хяналтыг хэрэгжүүлж байгаа” зэрэг ойлголт нь төсөөтэй хэрэглэгдэх ба корпораци, нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, хамтарсан компанийн хяналтыг хэрэгжүүлэх Этгээд нь тухайн этгээдийн хяналтдаа байлгаж буй корпораци, нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, хамтарсан компанийг удирдаж байгаа гэж ойлгоно.

“Корпораци буюу Corporation” гэж Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци буюу түүний залгамжлагч этгээдийг хэлнэ.

“Олгох өдөр буюу Date of Grant” гэж аливаа Урамшууллын хувьд тухайн Урамшууллыг олгохоор Хөтөлбөрийн зохицуулагчаас тодорхойлсон өдрийг хэлэх ба хэрвээ тодорхойлоогүй бол тухайн Урамшууллыг олгосон өдрийг хэлнэ.

“Ирээдүйд олгогдох хувьцааны эрх буюу Deferred Share Unit” “ИОХЭ” гэж 7-р зүйлийн дагуу Корпорацийн данс тооцоонд бүртгэгдсэн хувьцааны үнэлгээ бүхий нэгжийг хэлнэ.

“ТУЗ-ийн гишүүн буюу Director” гэж Корпорацийн ТУЗ-ийн гишүүнийг ойлгох буюу тухайн ТУЗ-ийн гишүүн нь Ажилтан биш байна;

“ТУЗ-ийн гишүүний төлбөр буюу Director Fees” ТУЗ болон ТУЗ-ийн аливаа хороонд ажилласны төлөө санхүүгийн жилд ТУЗ-ийн гишүүнд Корпорациас төлөх (хэрвээ байгаа бол жилийн цалин болон уулзалтын төлбөрийг оруулаад) нийт төлбөрийг хэлнэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй буюу Disabled” эсхүл “Хөгжлийн бэрхшээл буюу Disability” гэж тодорхой Оролцогчийн хувьд дараахыг хэлнэ:

- (a) “Хөгжлийн бэрхшээлтэй” эсхүл “Хөгжлийн бэрхшээл” (бусад төсөөтэй нэр томъёо)-ыг Корпораци, түүний охин компани болон Оролцогч хооронд байгуулсан хөдөлмөрийн ба бусад бичгээр байгуулсан гэрээнд тодорхойлсноор ойлгоно.
- (b) хэрвээ Корпораци, түүний охин компанитай байгуулсан хөдөлмөрийн болон бусад бичгээр байгуулаагүй, эсхүл “Хөгжлийн бэрхшээлтэй”, “Хөгжлийн бэрхшээл” (бусад төсөөтэй нэр томъёо)-ыг тэдгээр гэрээнд тодорхойлоогүй бол Урамшууллын гэрээнд тодорхойлсноор ойлгоно.
- (c) хэрвээ дээрх (a) эсхүл (b)-д заасны дагуу тодорхойлох боломжгүй бол бие махбод, оюун санааны чадамж, хөгжлийн бэрхшээл, өвчнөөс шалтгаалан (хуулийн дагуу эрх бүхий эмнэлгийн байгууллага, шүүхээс тодорхойлсны дагуу) үргэлжилсэн 6 сар буюу 12 сарын хугацаанд нийт 180 хоног Ажилтан, ТУЗ-ийн гишүүн, Зөвлөхөөр хэвийн ажиллаж, чиг үүргээ хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болж Оролцогчийн чадвар, чадамж хязгаарлагдсан байхыг хэлнэ. Дээрх хугацааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хөтөлбөрийн Зохицуулагчийн гаргасан журмын дагуу тодорхойлон тогтооно.

“Хүчин төгөлдөр болох өдөр буюу Effective Date” гэж энэхүү Хөтөлбөр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх 2023 оны 5 сарын 17-ыг хэлнэ.

“**Сонгосон дүн буюу Elected Amount**” гэж 7.1(a) хэсэгт заасныг хэлнэ.

“**Сонгох этгээд буюу Electing Person**” гэж Сонгуулийн өдрөөр ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж буй Оролцогчийг хэлнэ.

“**Сонгох өдөр буюу Election Date**” гэж 7.1(b) хэсэгт заасны дагуу Сонгуулийн мэдэгдлийг Сонгох этгээд бүртгүүлэх өдрийг хэлнэ.

“**Сонгох мэдэгдэл буюу Election Notice**” гэж 7.1(b)-д заасныг хэлнэ.

“**Ажилтан буюу Employee**” гэж дараах хувь хүнийг хэлнэ. Үүнд:

- (a) Холбогдох татвар болон нийгмийн даатгалын хуулийн дагуу суутгал хийгддэг, Корпораци ба түүний охин компанийн ажилтныг хэлнэ.
- (b) Корпораци ба түүний охин компанид долоо хоногийн горимоор бүтэн, эсхүл хагас цагаар ажиллаж, ажилтны үзүүлдэг энгийн ажил үйлчилгээг үзүүлдэг бөгөөд Корпораци ба түүний охин компанийн удирдлага, өгсөн чиглэл, арга барилын дагуу ажил гүйцэтгэдэг.

“**Бирж буюу Exchange**” гэж (a) Торонтогийн хөрөнгийн бирж эсхүл (b) Хувьцаа гаргасан анхдагч биржийг хэлнэ. Хэрвээ (i) Торонтогийн хөрөнгийн бирж Корпорацийн анхдагч бирж биш болсон бол эсхүл (ii) Хувьцаа Торонтогийн хөрөнгийн биржид арилжаалагдахаа больсон бол Хөтөлбөрийн зохицуулагчийн тодорхойлсон биржийг хэлнэ.

“**Хэрэгжүүлэх мэдэгдэл буюу Exercise Notice**” гэж тодорхой Опционыг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаагаа дурдсан Оролцогчийн бичгээр үйлдэж, гарын үсэг зурсан мэдэгдлийг хэлнэ.

“**Хэрэгжүүлэх үнэ буюу Exercise Price**” гэж Опционыг хэрэгжүүлэх хүрээнд Опционы хувьцааг худалдан авах үнийг хэлнэ.

“**Дуусгавар болох өдөр буюу Expiry Date**” гэж Урамшууллын гэрээнд заасан дуусгавар болох өдрийг хэлэх (Олгосон өдрөөс хойш 5 жилээс илүүгүй байх) ба хэрвээ ийнхүү заагаагүй бол Олгосон өдрөөс хойш 5 жилийн дараах өдөр байна.

“**Ашигтай дүн буюу In-the-Money Amount**” гэж 4.5(b) дэх хэсэгт заасан утгатай.

“**Дотоод мэдээлэл эзэмшигч буюу Insider**” гэж Хөрөнгийн биржийн дүрмийн дагуу тухай бүр тодорхойлсон этгээдийг хэлэх ба Торонтогийн хөрөнгийн биржийн хувьд “TSX Компанийн гарын авлага”-ын 613 дахь хэсэг болон холбогдох заалтуудын дагуу тодорхойлогдоно.

“**Залгамж халааны төлөвлөгөө буюу Legacy Plans**” гэж (a) Корпорацийн хувьцаа эзэмшигчдээс 2007 оны 5-р сарын 10-ны өдөр баталж, нэмэлт өөрчлөлт оруулсан Корпорацийн урамшууллын хувьцааны опционы төлөвлөгөө ба (b) Корпорацийн хувьцаа эзэмшигчдээс 2012 оны 10-р сарын 26-ны өдөр баталж, нэмэлт өөрчлөлт оруулсан Корпорацийн Ирээдүйд олгогдох хувьцааны төлөвлөгөөг хэлнэ. Эдгээр хөтөлбөрүүд зөвхөн

Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон байгаа урамшууллыг хэрэгжүүлэх зорилгоор хүчин төгөлдөр хэвээр үйлчлэх бөгөөд олгогдсон байгаа урамшууллауд хэрэгжих эсхүл цуцлагдсанаар дуусгавар болж, хүчин төгөлдөр байхаа болино.

**“Зах зээлийн үнэ буюу Market Price”** гэж Хөрөнгийн бирж дээрх Хувьцааны тухайн өдрийн өмнөх 5 арилжааны өдрийн жигнэсэн дундаж арилжааны ханшийг хэлэх ба Хувьцааг арилжаалж байх ямар ч үед Зах зээлийн үнэ нь Хөрөнгийн биржийн бодлогуудын дагуу тооцоолсон зах зээлийн үнээс доогуур бус байх бөгөөд АНУ-ын Татвар төлөгчид олгосон Урамшууллын хувьд тухайн тухайн Оролцогч, Урамшуулалд хамаарах Хувьцааны ангилал, Хувьцааны тоог тухайн 5 арилжааны өдөр эхлэхээс өмнө ТУЗ эсхүл Хороо тогтооно. Хэрвээ тухайн Хувьцааг аливаа Хөрөнгийн биржид байршуулж арилжаалаагүй бол Хувьцааны Зах зээлийн үнэ нь ТУЗ-өөс тогтоосон зах зээлийн бодит үнэлгээ байх ба АНУ-ын Татвар төлөгчид олгосон Урамшууллын хувьд Хуулийн 409А-д заасны дагуу тогтооно.

**“Орон тооны бус ТУЗ-ийн гишүүн буюу Non-Executive Director”** гэж 3.7 хэсэгт заасныг хэлнэ.

**“Опцион буюу Option”** гэж энэхүү Хөтөлбөрийн 4-р зүйлд заасан Хувьцааг худалдан авах эрхийг хэлэх ба Хөтөлбөрийн зохицуулагч баталснаас бусад тохиолдолд шилжүүлэх нөхцөлгүй байна.

**“Опционы хувьцаа буюу Option Shares”** гэж олгосон Опционыг хэрэгжүүлэхэд Корпорациас гаргасан Хувьцааг хэлнэ.

**“Оролцогч буюу Participant”** гэж энэхүү Хөтөлбөрийн дагуу Урамшуулал олгосон ТУЗ-ийн гишүүн, Ажилтан ба Зөвлөхийг хэлнэ.

**“Гүйцэтгэлийн зорилт буюу Performance Goals”** гэж Корпораци, охин компани, Корпорацийн болон охин компанийн хэлтэс, эсхүл хувь хүнд хамааруулан тодорхой шаардлагын тогтоосон түвшнийг хангах, эсхүл тодорхой хувийг өсгөх, багасгах зэрэг нөхцөлөөр илэрхийлэгдсэн гүйцэтгэлийн зорилтыг хэлэх ба Корпораци, охин компани болон бусад компанийн нэгдэл зэргийн зах зээлийг индекстэй холбоотой гүйцэтгэлд хамааруулж болно. Үүнийг Хөтөлбөрийн зохицуулагч өөрийн үзэмжээр тодорхойлно.

**“Гүйцэтгэлд уялдсан хувьцааны нэгж буюу Performance Share Unit”, “ГУХН”** гэж 6-р зүйлийн дагуу Корпорацийн данс тооцоонд бүртгэгдсэн Хувьцааны үнэлгээ бүхий нэгжийг хэлнэ.

**“Этгээд буюу Person”** гэж хувь хүн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, бүртгүүлээгүй холбоо, нэгдэл, бүртгүүлээгүй байгууллага, хөрөнгө итгэмжлэгч зэргийг хэлэх ба хөрөнгө итгэмжлэл, захиргаа удирдлага болон бусад хуулийн дагуух төлөөллийг хэрэгжүүлж буй хувь хүнийг ойлгоно.

**“Хөтөлбөр буюу Person”** гэж тухай бүр өөрчлөлт оруулсан энэхүү Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийг хэлнэ.

**“Хөтөлбөрийн зохицуулагч буюу Plan Administrator”** гэж ТУЗ-ийг хэлэх ба хэрвээ 3.2 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ эрх хэмжээгээ Хороонд шилжүүлсэн бол Хороог хэлнэ.

**“ГУХН-ийн Үйлчилгээ үзүүлсэн жил буюу PSU Service Year”** гэж 6.1 дэх хэсэгт заасан утгатай.

**“Хязгаарлалт бүхий хувьцааны нэгж буюу Restricted Share Unit”, “ХБХН”** гэж 5-р зүйлийн дагуу Корпорацийн данс тооцоонд бүртгэгдсэн Хувьцааны үнэлгээ бүхий нэгжийг хэлнэ.

**“Тэтгэвэрт гарах буюу Retirement”** гэж Хөтөлбөрийн зохицуулагч баталсны дагуу Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд 67 нас хүрсний дараа эсхүл Хөтөлбөрийн зохицуулагчаас зөвшөөрсөн насанд хүрсний дараа Үргэлжлүүлэн үзүүлсэн үйлчилгээнээс хойш багадаа таван (5) жил өнгөрсний дараа Оролцогчийн ажиллах карьер дуусгавар болохыг хэлнэ. Үүнд: Шалтгаан тохиолдсоны улмаас Корпораци, охин компани Оролцогчийн үйлчилгээг дуусгавар болгосон хамаарахгүй.

**“ХБХН-ийн Үйлчилгээ үзүүлсэн жил буюу RSU Service Year”** гэж 5.1 дэх хэсэгт заасны ойлгоно.

**“Хуулийн 409А хэсэг буюу Section 409A of the Code”** эсвэл **“409А хэсэг буюу Section 409А”** гэж Хуулийн 409А хэсгийг хэлэх ба түүнтэй холбоотойгоор гаргасан бүхий л тогтоомж, журам, гарын авлага, хөтөлбөр, тайлбар хамаарна.

**“Үнэт цаасны тухай хуулиуд буюу Securities Laws”** гэж тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлтийг багтаагаад үнэт цаасны тухай хууль тогтоомж, зохицуулалт, дүрэм, бодлого, мэдэгдэл, баримт бичиг, тушаал зэрэг Корпорацид хамааралтай, түүний дагаж мөрдөх хууль тогтоомжийг хэлнэ.

**“Үнэт цаасанд суурилсан урамшууллын зохицуулалт буюу Security Based Compensation Arrangement”** гэж хувьцааны опцион, опционы хөтөлбөр, ажилтнууд хувьцаа худалдан авах хөтөлбөр болон бусад төлбөрийн ба урамшууллын механизмыг хэлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүд, Ажилтнууд, Корпораци, охин компанид үйлчилгээ үзүүлдэг бусад этгээдэд хувьцаа олгох, олгохоор амлах зэргийг багтаах. Үүнд: зээл, баталгаа болон бусад хэлбэрээр Корпорациас санхүүгийн дэмжлэг үзүүлэх байдлаар халаасны хувьцаа худалдан авах орно.

**“Хувьцаа буюу Share”** гэж Хүчин төгөлдөр болох өдрөөр тогтоосон Корпорацийн хувь нийлүүлсэн хөрөнгө дэх нэг (1) энгийн хувьцааг, эсхүл Канадын болон бусад холбогдох хуулийн дагуу тухайн энгийн хувьцааг солихоор гаргасан аливаа хувьцаа буюу хувьцаануудыг, түүнчлэн тухай бүр Корпорацийн хувь нийлүүлсэн хөрөнгөөс гаргасан энгийн хувьцааны аливаа нэмэлт ангиллын нэг хувьцааг, эсхүл 10-р зүйлд заасны дагуу тохируулга хийсний дараа Урамшуулал эзэмшигч тухайн тохируулгын дагуу эзэмших эрхтэй болсон бусад хувьцаа, үнэт цаасыг хэлнэ.

**“Охин компани буюу subsidiary”** гэж нэг хувьцаа гаргагч шууд болон шууд бусаар Хяналыг хэрэгжүүлдэг нөгөө хувьцаа гаргагчийг хэлэх ба тухайн охин компанийн охин компани болон энэхүү Хөтөлбөрийн зорилгоор Хөтөлбөрийн зохицуулагчаас тухай бүр



охин компани гэж тогтоосон Корпорацийн хувьцааг нь эзэмшдэг бусад аливаа хуулийн этгээдийг багтаана.

“Татварын хууль буюу Tax Act” гэж Орлогын албан татварын тухай хууль (Канад)-ийг хэлнэ.

“Цуцлах өдөр буюу Termination Date” гэж холбогдох хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд дараахыг хэлнэ. Үүнд:

- (a) Ажилтны хувьд түүний Корпораци, охин компанитай хийсэн хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон бол (i) Корпораци, охин компанитай бичгээр байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээнд “Цуцлах өдөр” (болон бусад төсөөтэй нэр томъёо) гэж тогтоож өгсөн өдрийг, эсхүл (ii) хэрвээ бичгээр байгуулсан хөдөлмөрийн гэрээ, бусад гэрээ байхгүй бол тухайн Ажилтан Корпорацийн ажилтан байхаа больсон гэж Корпораци, охин компаниас тогтоосон өдрийг хэлэх ба хэрвээ Оролцогч өөрийн санаачилгаар хөдөлмөрийн харилцааг цуцалсан бол тухайн Корпорацийн тогтоосон өдөр нь цуцлах мэдэгдэл өгсөн өдрөөс өмнө байж болохгүй. Ямар ч тохиолдолд “Цуцлах өдөр”-ийг Корпораци, охин компаниас хуулийн дагуу Оролцогчид мэдэгдэл өгөх боломжит хоног, цуцлах мэдэгдлийн оронд төлөх аливаа төлбөр, олговор болон Оролцогчид төлсөн буюу төлөх ёстой хохирлыг оруулахгүйгээр тогтооно.
- (b) Зөвлөхийн хувьд түүний Корпораци, охин компанитай хийсэн гэрээ, хэлцэл дуусгавар болсон бол (i) Корпораци, охин компанитай бичгээр байгуулсан гэрээнд “цуцлах өдөр” (болон бусад төсөөтэй нэр томъёо), дуусгавар болох өдөр гэж тогтоож өгсөн өдрийг, эсхүл (ii) хэрвээ бичгээр байгуулсан гэрээ байхгүй бол тухайн Зөвлөх Корпорацийн зөвлөх байхаа больж, үйлчилгээ үзүүлэхээ больсон гэж Корпораци, охин компаниас тогтоосон өдрийг хэлэх ба хэрвээ Оролцогч өөрийн санаачилгаар зөвлөх үйлчилгээний болон бусад бичгээр байгуулсан гэрээг цуцалсан бол тухайн Корпорацийн тогтоосон өдөр нь цуцлах мэдэгдэл өгсөн өдрөөс өмнө байж болохгүй. Ямар ч тохиолдолд “Цуцлах өдөр”-ийг Корпораци, охин компаниас хуулийн дагуу Оролцогчид мэдэгдэл өгөх боломжит хоног, цуцлах мэдэгдлийн оронд төлөх аливаа төлбөр, хураамж болон Оролцогчид төлсөн буюу төлөх ёстой хохирлыг оруулахгүйгээр тогтооно.
- (c) ТУЗ-ийн гишүүний хувьд тухайн хувь хүн ТУЗ-ийн гишүүн байхаа больсон өдрийг хэлнэ.

Дээрх тохиолдол бүрд тухайн хувь хүн өөр ажил, албан тушаалын хувиар Оролцогч байхаа болиогүй байх шаардлагатай.

Дээр заасныг үл харгалзан АНУ-ын Татвар төлөгчийн хувьд тухайн Оролцогчийн “дуусгавар болох өдөр” гэдэг нь Хуулийн 409А хэсэгт заасан утгаар Оролцогч Корпораци, охин компаниас “үйлчилгээг салгасан” өдөр гэж үзэх өдрийг хэлнэ.

“АНУ буюу U.S” эсвэл “Нэгдсэн Улс буюу United States” гэж Америкийн Нэгдсэн Улс, түүний газар нутаг, эзэмшил, аливаа муж улсад болон Колумбын дүүргийг хэлнэ.

“АНУ-ын этгээд буюу U.S. Person” гэж АНУ-ын Үнэт цаасны тухай хуулийн S журмын 902(k) дүрэмд тодорхойлсон “АНУ-ын этгээд”-ийг ойлгоно (уг тодорхойлолтод дараах орох ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: (i) АНУ-д оршин суугч хувь хүн, (ii) АНУ-ын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан аливаа нөхөрлөл, корпораци, (iii) хувь хүн, хөрөнгө, болон хөрөнгө итгэмжлэгч биш хөрөнгө оруулагч нар байгуулан өмчилдөхөөс бусад тохиолдолд АНУ-ын Үнэт Цаасны тухай хуулийн дагуу бүртгэгдээгүй үнэт цаасанд хөрөнгө оруулах үндсэн зорилготойгоор АНУ-ын этгээдийн АНУ-аас гадна байгуулсан аливаа нөхөрлөл, корпораци, болон (iv) гүйцэтгэгч, удирдах этгээд болон хөрөнгө итгэмжлэгч нь АНУ-ын этгээд болох аливаа хөрөнгө итгэмжлэн удирдах байгууллагыг хэлнэ.

“АНУ-ын Үнэт цаасны тухай хууль буюу U.S. Securities Act” гэж нэмэлт өөрчлөлтийг багтаагаад 1933 оны АНУ-ын Үнэт цаасны тухай хуулийг хэлнэ.

“АНУ-ын Татвар төлөгч буюу U.S. Taxpayer” Урамшуулалтай холбоотойгоор АНУ-ын татварын хуулийн дагуу татвар төлөх ёстой Оролцогчийг хэлнэ.

## 2.2 Тайлбар

- (a) Энэхүү Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Хөтөлбөрийн зохицуулагч “сонголтоор” шийдвэрлэх гэдэг нь тухайн Хөтөлбөрийн зохицуулагчийн сонголтыг хэлнэ.
- (b) Энд дурдсан “Бүлэг”, “Зүйл”, “Заалт”, “Хэсэг”, “Дэд хэсэг” гэдэг нэр томъёо нь энэхүү Хөтөлбөрийн тодорхой Бүлэг, Зүйл, Заалт, Хэсэг, Дэд хэсгийг тус тус хэлсэн болно.
- (c) Нэг тоон дээр илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоо нь нэг тоог мөн адил багтаах бөгөөд аливаа нэг хүйсийн үг хэрэглэснийг бусад хүйсийг багтаасан гэж ойлгоно.
- (d) Өөрөөр заагаагүй бол аливаа төлбөр төлөх, эсхүл үйлдэл хийх хугацааг тоолохдоо тухайн хугацааны эхний өдрийг оруулахгүй бөгөөд тухайн хугацаа дуусах өдрийн оруулан тоолно. Хэрвээ Ажлын өдөр биш өдөр аливаа үйлдэл хийх, эсхүл төлбөр төлөхийг шаардсан бол тухайн үйлдлийг, эсхүл төлбөрийг дараагийн Ажлын өдөрт хийнэ.
- (e) Өөрөөр заагаагүй бол мөнгөн дүн илэрхийлснийг Канадын мөнгөн тэмдэгт гэж ойлгоно.
- (f) Гарчгийг зөвхөн ойлгомжтой байлгах үүднээс оруулсан ба энэхүү Хөтөлбөрийг тайлбарлахад нөлөөлөхгүй.

### 3 ГУРАВДУГААР ЗҮЙЛ УДИРДЛАГА

#### 3.1 Удирдлага

Энэхүү Хөтөлбөрийг Хөтөлбөрийн зохицуулагч удирдан зохицуулах бөгөөд Хөтөлбөрийн зохицуулагч нь дараах асуудлыг зөвхөн өөрийн сонголтоор шийдвэрлэх бүрэн эрх хэмжээтэй байна. Үүнд:

- (a) Хөтөлбөрийн дагуу урамшуулал олгох хувь хүнийг тодорхойлох,
- (b) Хөтөлбөрийн дагуу Хувьцаа гаргахтай холбоотой Урамшууллыг өөрийн тодорхойлсон Этгээдэд зохих хэмжээгээр, Хөтөлбөрт заасан нөхцөл болзлыг харгалзан олгох (Опцион, Хязгаарлагдмал Хувьцааны нэгж, Гүйцэтгэлд уялдсан хувьцааны нэгж болон Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн нэгж зэргийг багтаагаад) ба тэдгээр нөхцөл болзолд дараах орно (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй):
  - (i) Урамшуулал олгох тохиолдол,
  - (ii) Дараах нөхцөл:
    - (A) Оролцогчид урамшууллыг олгож болох нөхцөл болзол; or
    - (B) Корпораци Урамшууллыг хурааж авч болох нөхцөл болзол,  
Түүнчлэн Гүйцэтгэлийн тодорхой зорилтыг хангахтай холбоотой аливаа нөхцөл болзлыг оруулна.
  - (iii) Урамшуулалд хамаарах Хувьцааны тоо,
  - (iv) Урамшуулалд хамаарах Хувьцааг худалдан авахтай холбоотойгоор Оролцогчоос төлөх (хэрвээ бий бол) үнэ,
  - (v) олгосон Урамшууллын дагуу гаргах Хувьцаанд аливаа хориг, хязгаарлалтууд тавигдах эсэх болон хэрвээ тавигдах бол тухайн хориг, хязгаарлалтын шинж чанар,
  - (vi) Хөтөлбөрийн зохицуулагчийн тодорхойлсон хүчин зүйлд үндэслэн Урамшууллыг эзэмших, хэрэгжүүлэх хугацааг урагшлуулах, эсхүл эрхээсээ татгалзах болон цуцлах нөхцөл.
- (c) Урамшууллын гэрээний загварыг батлах,
- (d) энэхүү Хөтөлбөрийн заалтуудын дагуу Хөтөлбөр хэрэгжүүлэгч зүйтэй гэж үзсэн тохиолдлуудад Урамшууллыг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах болон бусад байдлаар өөрчлөх,
- (e) энэхүү Хөтөлбөр болон Урамшууллын гэрээг тайлбарлах,

- (f) энэхүү Хөтөлбөртэй холбоотой удирдамж, бусад дүрэм, журмыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох. Эдгээр дүрэм журамд гадаад улсын хууль тогтоомжийн шаардлагыг хангах, эсхүл гадаад улсын хууль тогтоомжийн дагуу татварын таатай нөхцөлийг эдлэх зорилгоор гаргасан дэд хөтөлбөрүүд орно.
- (g) энэхүү Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулахад шаардлагатай бөгөөд зохистой гэж үзсэн бусад бүх үйл ажиллагаа.

### **3.2 Хороогоор төлөөлүүлэх**

- (a) Эхний Хөтөлбөрийн Зохицуулагч нь ТУЗ байна.
- (b) Холбогдох хуульд зөвшөөрсөн бол энэхүү Хөтөлбөрийн дагуу Хөтөлбөрийн Зохицуулагчид олгосон бүхий л эрх хэмжээг ТУЗ нь ТУЗ-ийн Хороо (“**Хороо**” гэх)-нд тухай бүр шилжүүлж болно. Шилжүүлэх эрх хэмжээнд ТУЗ-өөс шилжүүлсэн эрх хэмжээг заримыг болон бүхлээр нь Хорооны гишүүн (гишүүд), эсхүл Корпораци, охин компанийн аль нэг тодорхой ажилтанд шилжүүлэн төлөөлүүлж болно. Энэ тохиолдолд төлөөлүүлж байгаа этгээдээс олгосон нөхцөлийн дагуу тухайн Хороо, дэд төлөөлөгч нь эрх хэмжээгээ хэрэгжүүлнэ. Энэхүү Хөтөлбөрийг зохион байгуулж, тайлбарлахтай холбоотой тухайн Хороо болон дэд төлөөлөгчийн ийнхүү гаргасан шийдвэр, аливаа үйл ажиллагаа нь эцсийнх байх бөгөөд Корпораци, охин компани болон бүх Оролцогч, бусад Этгээдэд заавал биелүүлэх хүчин төгөлдөр үйлчилнэ.

### **3.3 Шийдвэр хүчин төгөлдөр байх**

Энэхүү Хөтөлбөрийг зохион байгуулж, тайлбарлахтай холбоотой ТУЗ болон дээрх 3.2-т заасны дагуу төлөөлүүлсэн Хороо болон дэд төлөөлөгчийн гаргасан шийдвэр, аливаа үйл ажиллагаа нь эцсийнх байх бөгөөд Корпораци, тухайн Оролцогч, тэдгээрийн хуулийн ба хувийн төлөөлөгчид болон бусад бүх Этгээдэд заавал биелүүлэх хүчин төгөлдөр үйлчилнэ.

### **3.4 Оролцох эрх**

9.1(f) хэсэгт заасныг харгалзан, бүх ТУЗ-ийн гишүүд, Ажилтнууд болон Зөвлөхүүд энэхүү Хөтөлбөрт оролцох эрхтэй байна. Хөтөлбөрт оролцох нь сайн дурын шийдвэр байх бөгөөд оролцох эрхтэй гэдэг нь энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг хүлээн авах эрхийг ТУЗ-ийн гишүүн, Ажилтан, Зөвлөхөд олгосон гэсэн үг биш юм. Энэхүү Хөтөлбөрийн дагуу Урамшуулал хүлээн авах эрхтэй аливаа ТУЗ-ийн гишүүн, Ажилтан, Зөвлөхийг зөвхөн Хөтөлбөрийн зохицуулагчийн шийдвэр, үзэмжид үндэслэн тодорхойлно.

### **3.5 Хөтөлбөрийн зохицуулагчийн шаардлага**

Аливаа хөрөнгийн бирж, эсхүл харьяаллын улсын Үнэт Цаасны тухай хууль тогтоомжийн дагуу Хөтөлбөрийн дагуу олгосон аливаа Урамшууллаар олгох Хувьцааг арилжаанд гаргах, бүртгэх, хүчин төгөлдөр болгох аливаа шаардлага тавигдана гэж Хөтөлбөрийн зохицуулагч тодорхойлсон тохиолдолд, эсхүл Урамшууллыг олгох, хэрэгжүүлэх болон түүний дагуу олгох Хувьцааг гаргах, худалдахтай холбоотой шаардлага эсхүл тэдгээрийг хийхэд

тавигдах урьдчилсан нөхцөл бий болохыг Корпорацийг харьяалах үнэт цаасны хууль тогтоомж, зохицуулах байгууллага, хөрөнгийн бирж шаардлагатай гэж үзэж тэдгээрийн зөвшөөрөл баталгааг авах шаардлагатай гэж Хөтөлбөрийн зохицуулагч тухай бүр тодорхойлсон тохиолдолд тухайн хувьцааг арилжаанд гаргах, бүртгэх, хүчин төгөлдөр болгох зөвшөөрөл, баталгааг авч, урьдчилсан нөхцөлийг Хөтөлбөрийн Зохицуулагчийн шаардлагад нийцсэн байдлаар биелүүлтэл Урамшууллыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээн авч, хэрэгжүүлэхгүй.

Дээр дурдсанаас гадна бүх Урамшууллыг АНУ-ын Үнэт Цаасны тухай хуулийг бүртгэлийн шаардлага, эсхүл тухайн шаардлагаас чөлөөлсөн бол уг чөлөөлөлтийн дагуу гаргана. Хувьцааг арилжаанд гаргах, бүртгэх, хүчин төгөлдөр болгох зөвшөөрөл баталгааг авахыг Корпорациас шаардахгүй бөгөөд Оролцогчид өөрийн боломжит хэмжээнд Корпорацитай хамтран ажиллаж тухайн хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагыг биелүүлэн ажиллана.

### **3.6 Урамшууллаар олгох нийт хувьцаа**

- (a) 10 дугаар зүйлд заасан тохируулгын заалт болон энэхүү Хөтөлбөрт оруулах аливаа нэмэлт өөрчлөлтийг харгалзан, энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллын дагуу гаргахаар хадгалсан Хувьцааны нийт тоо нь Корпорацийн нийт гаргасан ба эргэлтэд буй хувьцааны 10%-иас хэтрэхгүй бөгөөд энэ дүнд Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон байгаа урамшууллыг хэрэгжүүлэхэд гаргах аливаа хувьцаа орно.
- (b) Энэхүү Хөтөлбөрийн дагуу олгох болон Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон Урамшууллыг аливаа шалтгаанаар бүхэлд нь буюу хэсэгчлэн цуцалсан, хураан авсан болон Оролцогч буцаасан, эсхүл мөнгөн төлбөрөөр тохиролцсон бол тухайн Урамшуулал болон Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон урамшууллаар гаргах Хувьцааг энэхүү Хөтөлбөрийн дагуу гаргахаар хадгалж буй Хувьцааны тоонд нэмж тооцох ба энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг хэрэгжүүлэхэд дахин гаргахаар бэлэн байлгана.
- (c) Худалдан авсан компаниас хэрэгжүүлэх аливаа хувьцааны опцион болон бусад үнэт цаасанд суурилсан урамшууллын дагуу Корпораци аливаа Хувьцаа гаргасан нь энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг хэрэгжүүлэхэд гаргах Хувьцааны тоог багасгахгүй.

### **3.7 Урамшуулал олгоход тавих хязгаарлалт**

Энэхүү Хөтөлбөрт заасныг үл харгалзан:

- (a) Дараах тохиолдолд гаргах Хувьцааны нийт тоо дор дурдсанаас хэтрэхгүй байна:
  - (i) Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон урамшууллыг оруулаад Корпорацийн үнэт цаасанд суурилсан төлбөрийн зохицуулалтын дагуу Дотоод мэдээлэл эзэмшигчид гаргах хувьцаа Корпорацийн гаргасан Хувьцааны арван хувь (10%)-аас,

- (ii) Залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон урамшууллыг оруулаад Корпорацийн үнэт цаасанд суурилсан төлбөрийн зохицуулалтын дагуу Дотоод мэдээлэл эзэмшигчид аливаа нэг (1) жилийн хугацаанд гаргах хувьцаа Корпорацийн гаргасан Хувьцааны арван хувь (10%)-аас,

Гэхдээ хүчингүй болгохоор Корпорациас буцаан авсан Хувьцааг тухайн хувьцааг худалдан авч хүчингүй болгохоос өмнө олгосон байсан аливаа Урамшууллын хувьд энэхүү 3.7 дахь хэсэгт нийцээгүй гэж тодорхойлоход харгалзаж үзэхгүй.

- (b) Корпорацийн аливаа нэг санхүүгийн жилийн дотор (i) Ажилтан, Зөвлөх биш аливаа ТУЗ-ийн гишүүн (“**Орон тооны бус ТУЗ-ийн гишүүн**”) -д олгох бүх Опционы Олголтын өдрөөрх нийт бодит үнэлгээ \$100,000 хэтрэхгүй, (ii) Корпорацийн үнэт цаасанд суурилсан төлбөрийн зохицуулалтын дагуу Орон тооны бус ТУЗ-ийн гишүүнд олгосон бүх Урамшууллын олголтын өдрөөрх нийт бодит үнэлгээ (тодорхой байх үүднээс Опционы бодит үнэлгээг оруулаад) \$150,000 хэтрэхгүй байх ба эдгээр хязгаарлалт нь (А) Бэлэн төлбөрийн оронд авсан Урамшуулал ба (В) Гүйцэтгэх удирдлагын багт хамаарахгүй захиралд ТУЗ-д нэгдсэнээр олгосон нэг удаагийн анхны олголтод хамаарахгүй.

### **3.8 Урамшууллын гэрээ**

Энэхүү Хөтөлбөрийн дагуу бүх Урамшууллыг Урамшууллын гэрээгээр баталгаажуулна. Урамшууллын гэрээ нь энэхүү Хөтөлбөрийн заалтуудад үндэслэх бөгөөд Хөтөлбөрийн дагуу шаардсан нөхцөлүүд болон Хөтөлбөрийн зохицуулагчаас удирдлага болгосон бусад заалтуудыг тусгана. Корпорацийн аливаа ажилтан энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг баталгаажуулсан Урамшууллын гэрээг Корпорацийг төлөөлөн Оролцогчтой байгуулах, түүнд хүргүүлэх эрх хэмжээтэй байна.

### **3.9 Урамшууллыг шилжүүлэхгүй байх**

Хөтөлбөрийн зохицуулагч зөвшөөрсөн, эсхүл Оролцогч нас барснаар гэрээслэлээр болон хуулиар өв залгамжлагчид зарим эрх тодорхой хэмжээгээр шилжиж болохоос бусад тохиолдолд сайн дураараа болон хуулиар шаардсан эсэхээс үл хамааран Урамшууллыг аливаа байдлаар шилжүүлэхгүй ба шилжүүлэн авагч ямар нэг байдлаар тухайн Урамшууллын аливаа эрхийг хэрэгжүүлэхээр оролдвол тухайн шилжүүлэг хийгдмэгц, эсхүл оролдмогц Урамшуулал цуцлагдаж, хүчин төгөлдөр биш болно. Оролцогч нас барснаар өв залгамжлагчид зарим эрх тодорхой хэмжээгээр шилжсэн бол тухайн өв залгамжлагч Урамшууллыг хэрэгжүүлэх хугацаа Оролцогчийн нас барснаас хойш нэг жилээс хэтрэхгүй.



## 4 ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ОПЦИОН

### 4.1 Опцион олгох

Хөтөлбөрийн зохицуулагч энэхүү Хөтөлбөрийн заалт болон өөрийн шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл болзлын дагуу аливаа Оролцогчид Опцион тухай бүр олгож болно. Опционы нөхцөл болзлыг Урамшууллын гэрээнд тусгаж баталгаажуулна.

### 4.2 Хэрэгжүүлэх үнэ

Хөтөлбөрийн зохицуулагч Опцион олгох үед Хэрэгжүүлэх үнийг тогтоох ба Хэрэгжүүлэх үнэ ямар ч тохиолдолд Олгох өдрийн Зах зээлийн үнээс доош байж болохгүй.

### 4.3 Опционы хугацаа

Энэхүү Хөтөлбөрт заасан түргэвчлэн цуцлах нөхцөлийг харгалзан Опцион бүр Дуусгавар болох өдөр дуусгавар болно.

### 4.4 Эзэмшүүлэх ба хэрэгжүүлэх

- (a) Хөтөлбөрийн зохицуулагч нь олгосон Опционыг эзэмших нөхцөлийг тодорхойлох эрх хэмжээтэй байна.
- (b) Опционыг олгосноор Хөтөлбөрийн Зохицуулагч өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд Опционыг дуусгавар болгох, цуцлах хүртэл Опционыг эзэмшиж, хэрэгжүүлж болохоор байна. Эзэмшүүлсэн Опцион бүрийг тухай бүр хэдийд ч Опционы хувьцааны нийт тоонд хүртэл бүхлээр нь эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлж болно. Хөтөлбөрийн зохицуулагч аливаа Опционыг хэрэгжүүлэх өдрийг түргэвчлүүлэх эрхтэй.
- (c) Энэхүү Хөтөлбөр болон Урамшууллын гэрээнд заасны дагуу Опционыг бүрэн бөглөсөн Хэрэгжүүлэх мэдэгдлийг Корпорацид хүргүүлэх байдлаар хэрэгжүүлнэ.
- (d) Хөтөлбөрийн зохицуулагч Опционыг олгохдоо Опционыг хэрэгжүүлэх энэхүү 4.4-т зааснаас гадна нэмэлт хоригийг тогтоож болох ба тухайлбал тодорхой Гүйцэтгэлийн Зорилтыг хангахтай холбоотой нөхцөл зааж болно.
- (e) Хөтөлбөрийн зохицуулагчийн сонголтоор Опционы хувьцааг дараах байдлаар тогтоож болно:
  - (i). Оролцогчид, эсхүл түүний зааварчилснаар бүрэн төлөгдсөн, үнэлэх боломжгүй нэг Хувьцааг халааснаас гаргаж өгөх,
  - (ii). Ашигтай дүнтэй (In-the-Money Amount) тэнцүү дүнгээр бэлнээр төлбөр хийх, эсхүл
  - (iii). Дээрх (i) ба (ii)-т заасан Хувьцаа, бэлэн төлбөрийг хослуулах.

#### 4.5 Хэрэгжүүлэх үнийн төлбөр

- (a) Опционыг олгох үед Хөтөлбөрийн зохицуулагчаас өөрөөр тогтоосон, эсхүл Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Хэрэгжүүлэх мэдэгдэлд Хэрэгжүүлэх үнийг төлөн хавсаргана. Хэрэгжүүлэх үнийг Хөтөлбөрийн зохицуулагчийн тухай бүр тогтоосноор баталгаат чек, мөнгөн гуйвуулга, банкны драфт болон бусад аргаар бүрэн төлөх ба үүнд дараах багтаж болно: (i) Опционыг хэрэгжүүлэхэд хүргүүлэх Хувьцааг худалдсан орлогоор Хэрэгжүүлэх Үнийг төлсөн болохыг Корпорациас зөвшөөрсөн брокероор дамжуулан (эсхүл Корпорацитай шууд) зохицуулсан, (ii) доорх 4.5(b) дахь хэсэгт заасан бэлэн бусаар хэрэгжүүлэх байдлаар зохицуулсан, эсхүл (iii) гаргасан Хувьцааны төлбөрийг Үнэт цаасны тухай хуулиар зөвшөөрсөн бусад төлбөрийн аргаар эсхүл дээрх аргуудыг хослуулан зохицуулсан.
- (b) Хөтөлбөрийн зохицуулагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрвээ Хөтөлбөрийн зохицуулагч зөвшөөрвөл Оролцогч нь Хэрэгжүүлэх мэдэгдлийг өгч Опционыг хэрэгжүүлэхийн оронд Корпорацид тухайн Опционыг буцаан шилжүүлэн өгөхөөр (“**Бэлэн бусаар хэрэгжүүлэх**”) сонгож болох ба (i) Опционыг (эсвэл түүний зарим хэсгийг) хэрэгжүүлэх өдрөөр тухайн Опцион (эсвэл түүний зарим хэсэг)-ыг хэрэгжүүлэхэд гаргах Хувьцааны зах зээлийн үнээс (ii) тухайн Хувьцаанд хамаарах буцаан шилжүүлэх өгөх Опционы (эсвэл түүний зарим хэсгийн) нийт Хэрэгжүүлэх үнийг хассан дүнтэй Ашигтай дүнг (In-the-Money Amount) тэнцүү төлбөрийг Корпорациас авч болно. Оролцогч нь ийнхүү Бэлэн бусаар хэрэгжүүлэх талаарх мэдэгдлийг хэрэгжүүлэх Опционы тоо болон Корпорациас шаардсан бусад мэдээллийг оруулан Корпорацид бичгээр гаргаж өгнө. 8.3 дахь хэсэгт заасныг харгалзан Корпораци нь Ашигтай дүнг хэрэгжүүлэх өдрийн байдлаарх Хувьцааны үнээр хувааж тодорхойлсон тоо хэмжээ бүхий Хувьцааг (хамгийн ойрын бүхэл тоогоор илэрхийлсэн) Оролцогчид хүргүүлэн Ашигтай дүнг төлбөрийг төлнө.
- (c) Корпорацид төлбөр бүрэн төлөгдтөл, эсхүл Хөтөлбөрийн зохицуулагчийн шаардлагад нийцсэн байдлаар төлбөрийн зохицуулалт хийтэл Хувьцааг гаргахгүй.
- (d) Хэрвээ Оролцогч 4.5(b) хэсэгт заасны дагуу Бэлэн бусаар хэрэгжүүлэх байдлаар Опционыг буцаан шилжүүлэн өгсөн бөгөөд Оролцогч нь Татварын тухай хуулийн 110 (1.1)-д заасны дагуу сонголт хийж бичиг баримтаа цаг хугацаанд нь өгвөл Татварын тухай хуулийн 110 (1.1)-д заасан хасалтад хамрагдах эрхтэй болох ба Корпораци нь Оролцогчийн хамрагдаж болох боломжит хэмжээгээр сонголтыг хийлгэнэ (бусад шаардлагатай арга хэмжээг авна).

### 5 ТАВДУГААР ЗҮЙЛ ХЯЗГААРЛАЛТ БҮХИЙ ХУВЬЦААНЫ НЭГЖ

#### 5.1 ХБХН-ийг олгох

- (a) Хөтөлбөрийн зохицуулагч энэхүү Хөтөлбөрийн заалт болон өөрийн шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл болзлын дагуу аливаа Оролцогчид татварын жилд тухайн

Оролцогчийн үзүүлсэн үйлчилгээ (“ХБХН-ийн Үйлчилгээний Жил”)-тэй холбоотой бонус болон түүнтэй ижил төстэй төлбөртэй холбогдуулан ХБХН-ийг тухай бүр олгож болно. ХБХН-ын нөхцөл болзлыг Урамшууллын гэрээнд тусгаж баталгаажуулна. ХБХН бүр нь тухайн ХБХН-ийн тооцоо хийх үед Хувьцаа хүлээн авах, бэлэн төлбөр авах эсхүл тэдгээрийн хослуулан авах эрхээс бүрдэнэ.

- (b) Энэхүү 5-р зүйлийн дагуу олгосон ХБХН-ийн тоо ширхэг (бутархай ХБХН-ыг оруулаад)-ийг (i) Хөтөлбөрийн зохицуулагчийн тодорхойлсон ХБХН-ээр төлөх урамшуулал, ижил төстэй төлбөрийн хэмжээг (ii) (A) Олгосон өдрөөр энгийн хувьцааны Зах зээлийн үнэ болон (B) Хөтөлбөрийн Зохицуулагч өөрийн үзэмжээр тодорхойлсон дүнгийн аль ихэд хувааж (бутархайг хоёр аравтын бутархайд шилжүүлэн) тооцно.

## **5.2 ХБХН-ийн данс**

Оролцогчийн хүлээн авсан бүх ХБХН-ийг Олгох өдрөөр Корпораци нь өөрийн тооцоо бүртгэл дэх Оролцогчийн дансанд оруулан хөтөлнө.

## **5.3 ХБХН-ийг эзэмшүүлэх**

Хөтөлбөрийн зохицуулагч ХБХН-ыг олгон эзэмшүүлэх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд тухайн нөхцөл болзол нь АНУ-ын Татвар төлөгчийн талаарх 409А хэсэгт холбогдох байдлаар нийцсэн байна.

## **5.4 ХБХН-ийн тооцоо хийх**

- (a) Хөтөлбөрийн зохицуулагч ХБХН-ын тооцоо хийх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд тухайн нөхцөл болзол нь АНУ-ын Татвар төлөгчийн талаарх 409А хэсэгт холбогдох байдлаар нийцсэн байна. Доор 11.6(d)-д заасныг харгалзан Хөтөлбөрийн зохицуулагч өөрөөр тодорхойлсон, эсхүл Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ХБХН-ийн тооцоо хийх өдрөөс хойш 30 хоногийн дотор Оролцогч нь эзэмшүүлсэн ХБХН тус бүрийг Хөтөлбөрийн зохицуулагчийн сонгосноор дараахын аль нэг байдлаар авна. Үүнд:
- (i) Оролцогчид, эсхүл түүний зааварчилснаар бүрэн төлөгдсөн, дахин үнэлэгдэхгүй нэг Хувьцааг халааснаас гаргаж өгөх,
  - (ii) Бэлнээр төлбөр хийх, эсхүл
  - (iii) Дээрх (i) ба (ii)-т заасан Хувьцаа, бэлэн төлбөрийг хослуулах.
- (b) Бэлнээр төлбөр тооцоог авах ХБХН-ийн хувьд бэлнээр авах ХБХН-ийн тоог тооцоо хийх өдрийн Хувьцааны Зах зээлийн үнээр үржүүлж Корпорациас Оролцогчид энэхүү 5.4 дэх хэсэгт заасны дагуу төлөх аливаа бэлэн төлбөрийг тооцно.
- (c) Оролцогчид эзэмшүүлсэн ХБХН-ийн бэлэн төлбөрийг Корпорацийн цалин буух аливаа нэг өдөр төлж болох ба тухайн хугацаа нь тооцоо хийх өдрөөс хойш 30 хоногт багтана.

(d) Энэхүү Хөтөлбөрийн 11.6(d) дэх хэсэгт зааснаас бусад заалтыг үл харгалзан, Хөтөлбөрийн зохицуулагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ХБХН-ийн үйлчилгээний жилээс хойш гурав дахь хуанлийн жилийн сүүлийн Ажлын өдрөөс хойш энэхүү 5.4 дэх заалтыг дагуу ХБХН-тэй холбоотойгоор аливаа тооцоо хийх өдөр тохиохгүй, Хувьцаа гаргахгүй бөгөөд бэлэн төлбөр төлөхгүй.

## **6 ЗУРГААДУГААР ЗҮЙЛ ГҮЙЦЭТГЭЛД УЯЛДСАН ХУВЬЦААНЫ НЭГЖ**

### **6.1 ГУХН олгох**

Хөтөлбөрийн зохицуулагч энэхүү Хөтөлбөрийн заалт болон өөрийн шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл болзлын дагуу аливаа Оролцогчид татварын жилд тухайн Оролцогчийн үзүүлсэн үйлчилгээ (“**ГУХН-ийн Үйлчилгээний Жил**”)–тэй холбоотой бонус болон түүнтэй ижил төстэй төлбөртэй холбогдуулан ГУХН-ийг тухай бүр олгож болно. ГУХН-ийн нөхцөл болзлыг Урамшууллын гэрээнд тусгаж баталгаажуулна. ГУХН бүр нь Хувьцаа хүлээн авах, бэлэн төлбөр авах эсхүл тэдгээрийн хослуулан авах эрхээс бүрдэх (6.6(a) дэх хэсэгт заасны дагуу) ба Хөтөлбөрийн зохицуулагчийн тодорхойлох гүйцэтгэлийн үе шатанд тодорхой Гүйцэтгэлийн зорилтыг хангасан тохиолдолд үйлчилнэ.

### **6.2 ГУХН-ийн нөхцөл болзол**

Гүйцэтгэлийн үе шатанд хангах Гүйцэтгэлийн зорилт, гүйцэтгэлийн мөчлөгийн хугацаа, ГУХН олгох хэмжээ, Оролцогчийн үйлчилгээг цуцалсны нөлөө болон ГУХН-ийн дагуу хийх төлбөр, шилжүүлгийн хэмжээг Хөтөлбөрийн зохицуулагч тодорхойлох бөгөөд эдгээрийн Урамшууллын Гэрээнд тусгана.

### **6.3 Гүйцэтгэлийн зорилт**

Хөтөлбөрийн зохицуулагч Олгох өдрөөс өмнө Гүйцэтгэлийн зорилтыг тодорхойлон гаргана. Гүйцэтгэлийн зорилт нь байгууллагын, хэлтсийн эсхүл хувь хүний гүйцэтгэлийн амжилтад үндэслэж болох ба үзүүлэлт эсхүл харьцуулах бүлэг болон Хөтөлбөрийн зохицуулагчийн тодорхойлсон аливаа бусад суурь үзүүлэлтэд хамааран хэрэглэгдэж болно. Олгох өдрийн дараа Хөтөлбөрийн зохицуулагч нь Урамшууллын гэрээнд заасан хязгаарлалтууд болон Оролцогчтой байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээнд заасныг харгалзан Корпорацийн байгууллагын зорилтуудад нийцүүлэн шаардлагатай өөрчлөлтийг Гүйцэтгэлийн зорилтод оруулж болно. Гүйцэтгэлийн зорилтод төлбөр хийгдэхгүй (эзэмшүүлэлт хийгдэхгүй) гүйцэтгэлийн түвшин, тодорхой төлбөр төлөх гүйцэтгэлийн түвшин (тодорхой эзэмшүүлэлт хийгдэх), нэмэлт төлбөр төлөх дээд гүйцэтгэлийн түвшин (бүрэн эзэмшүүлэлт хийгдэх) зэрэг босгыг тогтоож болох ба эдгээрийг Урамшууллын гэрээнд тусгана.

### **6.4 ГУХН-ийн данс**

Оролцогчийн хүлээн авсан бүх ГУХН-ийг Олгох өдрөөр Корпораци нь өөрийн тооцоо бүртгэл дэх Оролцогчийн дансанд оруулан хөтөлнө.

## **6.5 ГУХН-ийг эзэмшүүлэх**

Хөтөлбөрийн зохицуулагч ГУХН-ийг олгон эзэмшүүлэх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд тухайн нөхцөл болзол нь АНУ-ын Татвар төлөгчийн талаарх 409А хэсэгт холбогдох байдлаар нийцсэн байна.

## **6.6 ГУНХ-ийн тооцоо хийх**

- (a) Хөтөлбөрийн зохицуулагч ГУХН-ийн тооцоо хийх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд тухайн нөхцөл болзол нь АНУ-ын Татвар төлөгчийн талаарх 409А хэсэгт холбогдох байдлаар нийцсэн байна. Доор 11.6(d)-д заасныг харгалзан Хөтөлбөрийн зохицуулагч өөрөөр тодорхойлсон, эсхүл Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ГУХН-ийн тооцоо хийх өдрөөс хойш 30 хоногийн дотор Оролцогч нь эзэмшүүлсэн ГУХН тус бүрийг Хөтөлбөрийн зохицуулагчийн сонгосноор дараахын аль нэг байдлаар авна. Үүнд:
- (iv) Оролцогчид, эсхүл түүний зааварчилснаар бүрэн төлөгдсөн, дахин үнэлэгдэхгүй нэг Хувьцааг халааснаас гаргаж өгөх,
  - (v) Бэлнээр төлбөр хийх, эсхүл
  - (vi) Дээрх (i) ба (ii)-г заасан Хувьцаа, бэлэн төлбөрийг хослуулах.
- (b) Бэлнээр төлбөр тооцоог авах ГУХН-ийн хувьд бэлнээр авах ГУХН-ийн тоог тооцоо хийх өдрийн Хувьцааны Зах зээлийн үнээр үржүүлж Корпорациас Оролцогчид энэхүү 6.6 дахь хэсэгт заасны дагуу төлөх аливаа бэлэн төлбөрийг тооцно.
- (c) Оролцогчид эзэмшүүлсэн ГУХН-ийн бэлэн төлбөрийг Корпорацийн цалин буух аливаа нэг өдөр төлж болох ба тухайн хугацаа нь тооцоо хийх өдрөөс хойш 30 хоногт багтана.
- (d) Энэхүү Хөтөлбөрийн 11.6(d) дэх хэсэгт зааснаас бусад заалтыг үл харгалзан, Хөтөлбөрийн зохицуулагчаас өөрөөр тогтоосон, эсхүл тухайн Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ГУХН-ийн үйлчилгээний жилээс хойш гурав дахь хуанлийн жилийн сүүлийн Ажлын өдрөөс хойш энэхүү 6.6 дахь заалтыг дагуу ГУХН-тэй холбоотойгоор аливаа тооцоо хийх өдөр тохиохгүй, Хувьцаа гаргахгүй бөгөөд бэлэн төлбөр төлөхгүй.

## **7 ДОЛООДУГААР ЗҮЙЛ ИРЭЭДҮЙД ОЛГОГДОХ ХУВЬЦААНЫ ЭРХ**

### **7.1 ИОХЭ-ийг олгох**

- (a) ТУЗ-аас ТУЗ-ийн гишүүдийн төлбөрийн тодорхой хэсгийг ИОХЭ хэлбэрээр төлөхөөр тухай бүр зохицуулалт хийж болно. Түүнчлэн Сонгох Этгээдэд энд заасан нөхцөл болзлыг харгалзан энэхүү 7-р зүйлд заасны дагуу нэмэлт ИОХЭ -ийг олгоход оролцохоор сонгох эрхийг 7.1(b)-д заасны дагуу олгоно. 7-р зүйлд заасны дагуу Нэмэлт ИОХЭ-ийг олгоход оролцохоор сонгосон Этгээд Сонгосон дүн (дор

тодорхойлсон)-г ИОХЭ хэлбэрээр хүлээн авна. “Сонгосон дүн” гэж холбогдох татварын хуулийн дагуу бэлнээр төлөгдөх байсан (“Бэлэн төлбөр”) ТУЗ-ийн гишүүний төлбөрийн 0%-аас 100% дотор ТУЗ-ийн гишүүний сонгосон дүнг хэлнэ.

- (b) Сонгосон Дүнг ИОХЭ хэлбэрээр хүлээн авахаар сонгосон Этгээд Корпорацийн Санхүү хариуцсан захиралд Хавсралт А-д заасан маягтаар сонгох мэдэгдэл (“Сонгох мэдэгдэл”)-ийг дараах байдлаар хүргүүлэх үүрэгтэй. (i) Одоо байгаа Сонгох этгээдийн хувьд тухайн сонголт хамаарах санхүүгийн жилийн өмнөх Корпорацийн санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс өмнө (2023 оны санхүүгийн жилд төлөх ТУЗ-ийн гишүүний төлбөр хамаарахгүй ба энэхүү Хөтөлбөрийн хүчин төгөлдөр болох өдрөөр АНУ-ын Татвар төлөгч биш Сонгох Этгээд Хүчин Төгөлдөр болох өдрөөс хойш үзүүлэх үйлчилгээний төлбөр төлөхтэй холбоотойгоор тухайн өдрөөс хойш 30 өдрийн дотор Сонгох Мэдэгдлийг өгнө), эсхүл Хөтөлбөрийн зохицуулагчаас тодорхойлсон хойших өдөр, (ii) АНУ-ын Татвар төлөгч биш шинээр томилогдсон Сонгох Этгээдийн хувьд томилогдсон өдрөөс хойш үзүүлэх үйлчилгээний төлбөр төлөхтэй холбоотойгоор тухайн өдрөөс хойш 30 хоногийн дотор. АНУ-ын Татвар төлөгч Сонгох Этгээд энэхүү Хөтөлбөрийн дагуу (эсхүл 409А хэсгийн дагуу Хөтөлбөртэй нэгтгэх шаардлагатай аливаа бусад хөтөлбөрийн дагуу) анх Сонгох Этгээд болсон бол эхний жилийн хувьд анхны Сонгох Мэдэгдлийг зөвхөн 30 хоногийн сонгох хугацааны дараа үзүүлэх үйлчилгээний төлбөртэй холбоотойгоор томилогдсоноос хойш 30 хоногийн дотор гаргана. Хэрвээ уг хугацаанд сонголт хийгдээгүй бол Сонгох этгээдийн Бэлэн Төлбөрөөр авах бүх дүнг бэлнээр авахаар сонгосон гэж үзнэ. Энэхүү 7.1(b) хэсэгт заасныг үл харгалзан Үнэт цаасны хууль тогтоомж, Хөрөнгийн биржийн дүрэмд зааснаар нийтэд задруулаагүй Корпорацийтай холбоотой ноцтой үйл баримт эсхүл томоохон өөрчлөлтийг мэдэж байх үедээ Сонгох Этгээд нь Сонгох Мэдэгдлийг гаргахгүй байж болно.
- (c) 7.1(d) дэх хэсгийг харгалзан Сонгох Мэдэгдэл өгсний дараа төлөгдөх бүх Бэлэн төлбөрт 7.1(b)-д заасны дагуу Сонгох Этгээдийн хийсэн сонголт хамаарна гэж үзнэ. Сонгох Этгээд нь АНУ-ын Татвар төлөгч байх тохиолдолд Сонгох Өдрийн дараа олсон бүх Бэлэн төлбөрт 7.1(b)-д заасны дагуу Сонгох Этгээдийн хийсэн сонголт хамаарна гэж үзнэ. Дараагийн санхүүгийн жилүүдэд Сонгох Этгээд дахин Сонгох Мэдэгдэл өгөхийг шаардахгүй.
- (d) АНУ-ын Татвар төлөгч биш Сонгох Этгээд бүр санхүүгийн жилд нэг удаа Санхүү хариуцсан захиралд Хавсралт В-д заасан маягтаар цуцлах мэдэгдэл өгч ИОХЭ-ийг хүлээн авах өөрийн сонголтыг цуцлах эрхтэй. Арилжааг царцаасан үе хүчинтэй байгаагаас бусад үед тухайн цуцлах мэдэгдлийг хүлээн авмагц хүчин төгөлдөр болно. Үүнээс хойш тухайн санхүүгийн жилд тэрхүү Сонгох Этгээдэд төлөх буюу төлсөн аливаа Бэлэн төлбөр болон дараагийн санхүүгийн жилүүдийн төлбөрүүдийг 7.1(b) хэсэгт заасанд нийцүүлэн бэлнээр төлнө. Тодорхой болгох үүднээс, Сонгох Этгээд энэхүү 7-р зүйлд заасны дагуу ИОХЭ олгоход оролцох сонголтоо цуцалсан бол цуцлах мэдэгдэл хүргүүлсэн жилийн дараагийн санхүүгийн жил хүртэл тэрээр Сонгосон Дүн ба бусад өөрийн Бэлэн төлбөрийг дахин ИОХЭ -ээр авахаар сонголт хийх эрхгүй. АНУ-ын Татвар төлөгчийн аливаа санхүүгийн жилд Сонгосон Дүнг ИОХЭ -ээр авах сонголт нь тухайн жилийн сонгох хугацаа өнгөрсний дараагийн жилд буцалтгүй нөхцөлтэй байх ба сонголтоо цуцалсан нь Хавсралт С-д заасан



маягтаар хүргүүлсэн цуцлах мэдэгдэл өгсөн жилийн дараах санхүүгийн жилийн эхний өдөр хүртэл хүчин төгөлдөр болохгүй.

- (e) 7.1(d)-д заасны дагуу цуцлах мэдэгдэл өгөхөөс өмнө 7-р зүйлд зааснаар олгосон аливаа ИОХЭ нь цуцалсны дараа ч Хөтөлбөрт хамрагдсаар байх бөгөөд зөвхөн Хөтөлбөрийн нөхцөлийг дагуу түүнийг хэрэгжүүлж болно.
- (f) Энэхүү 7-р зүйлийн дагуу олгосон ИОХЭ -ийн тоо ширхэг (бутархай ИОХЭ-ийг оруулаад)-ийг (i) ИОХЭ-ээр төлөгдөх ТУЗ-ийн гишүүний төлбөрийн дүн (аливаа Сонгосон дүнг оруулаад)-ийг (ii) (А) Олгосон өдрөөрх Хувьцааны Зах зээлийн үнэд хувааж (бутархайг хоёр аравтын бутархайд шилжүүлэн) тооцно.
- (g) Дээрхээс гадна Хөтөлбөрийн зохицуулагч энэхүү Хөтөлбөрийн заалтуудын дагуу, өөрийн шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл болзлоор аливаа Оролцогчид ИОХЭ тухай бүр олгож болно.

## **7.2 ИОХЭ -ийн данс ба Урамшууллын гэрээ**

Оролцогчийн (тодруулбал Сонгох Этгээдүүдийн) хүлээн авсан бүх ИОХЭ -ийг Олгох өдрөөр Корпораци нь өөрийн тооцоо бүртгэл дэх Оролцогчийн дансанд оруулан хөтөлнө. ИОХЭ-ийн нөхцөл болзлыг Урамшууллын гэрээнд тусгаж баталгаажуулна.

## **7.3 ИОХЭ-ийг эзэмшүүлэх**

Хөтөлбөрийн зохицуулагч ИОХЭ-ийг олгон эзэмшүүлэх нөхцөл болзлыг тодорхойлох эрх хэмжээтэй байх бөгөөд 7.1(g)-д заасны дагуу олгосон ИОХЭ ба бусад бүх ИОХЭ-ийг олгомогц хүчин төгөлдөр болно.

## **7.4 ИОХЭ-ийн тооцоо хийх**

- (a) 9.1 дэх хэсэгт заасныг харгалзан ИОХЭ-ийн тооцоо нь Цуцлах өдрөөр, эсхүл Хөтөлбөрийн зохицуулагчийн зөвшөөрлөөр Оролцогчийн сонгосон хойших өдрөөр (Цуцлах өдөр болсон жилийн дараах эхний хуанлийн жилийн сүүлийн Ажлын өдрөөс хойшлолгүйгээр) хүчин төгөлдөр болно. Гэхдээ АНУ-ын Татвар төлөгч Оролцогчийн хувьд тооцоо хийх өдөр нь Сонгох мэдэгдэлд заасны дагуу Оролцогчийн тодорхойлсон өдөр байна (тухайн өдөр нь Цуцлах өдөр болон үйлчилгээг салгасан гэж (409А хэсэгт заасан утгаар) тооцогдох өдрийн аль сүүлийнхээс өмнө байж болохгүй). ИОХЭ-ийн тооцоо хийх өдөр Оролцогч нь Хөтөлбөрийн зохицуулагчийн сонгосноор ИОХЭ-ийг дараахын аль нэг байдлаар төлүүлж авна. Үүнд:
  - (i). Оролцогчид, эсхүл түүний зааварчилснаар бүрэн төлөгдсөн, дахин үнэлэгдэхгүй нэг Хувьцааг халааснаас гаргаж өгөх,
  - (ii). Бэлнээр төлбөр хийх, эсхүл
  - (iii). Дээрх (i) ба (ii)-г заасан Хувьцаа, бэлэн төлбөрийг хослуулах.

- (b) Бэлнээр төлбөр тооцоог авах ИОХЭ-ийг хувьд бэлнээр авах ИОХЭ-ийн тоог тооцоо хийх өдрийн Хувьцааны Зах зээлийн үнээр үржүүлж Корпорациас Оролцогчид энэхүү 7.4 дэх хэсэгт заасны дагуу төлөх аливаа бэлэн төлбөрийг тооцно.
- (c) Оролцогчид эзэмшүүлсэн ИОХЭ-ийн бэлэн төлбөрийг Корпорацийн цалин буух аливаа нэг өдөр төлж болох ба тухайн хугацаа нь тооцоо хийх өдрөөс хойш 30 хоногт багтана.

## **7.5 Нэмэлт төлбөр, олговор байхгүй тухай**

Тодорхой байлгах үүднээс, ИОХЭ олгосон Оролцогч, эсхүл тухайн Оролцогчийн сунгасан гарын зарчмаар ажилладаггүй аливаа этгээд (татварын зорилгоор) одоо болон ирээдүйд тухайн ИОХЭ-ийн холбогдох Хувьцааны Зах Зээлийн үнийг бууруулах, бууруулах нөлөөллийг бүхэлд буюу хэсэгчлэн багасгах зорилгоор аливаа дүн болон олговрыг авах эрхгүй болно.

## **8 НАЙМДУГААР ЗҮЙЛ УРАМШУУЛЛЫН НЭМЭЛТ НӨХЦӨЛ**

### **8.1 Ногдол ашигтай дүйцүүлэх**

- (a) Хөтөлбөрийн зохицуулагч өөрөөр тодорхойлсноос бусад тохиолдолд ХБХН, ГУХН ба ИОХЭ-ийн Урамшуулал нь нэмэлт ХБХН, ГУХН ба ИОХЭ хэлбэрээр тухайн ХБХН, ГУХН ба ИОХЭ-д тооцогдох ногдол ашигтай дүйцүүлэх төлбөрийг Хувьцаанд төлөх энгийн бэлэн ногдол ашгийн төлбөрийн өдрөөр тооцон авах эрхийг багтаана. Тухайн ногдол ашигтай дүйцүүлэх төлбөрийг (a) Хувьцаа бүрд хуваарилан төлөх ногдол ашгийн дүнг ногдол ашиг төлөх бүртгэлийн өдрөөр Оролцогчийн эзэмшиж байгаа ХБХН, ГУХН ба ИОХЭ-ийн тоогоор үржүүлэх дүнг (b) ногдол ашиг төлөх өдрөөрх Зах зээлийн үнэд хувааж тооцох ба бутархайг хоёр оронгоор тасална. Оролцогчийн дансанд тооцогдсон ногдол ашигтай дүйцүүлэх төлбөрийг тухайн төлбөр хамаарах ХБХН, ГУХН ба ИОХЭ-д хувь тэнцүүлэн эзэмшүүлж 5.4, 6.6 болон 7.4 хэсэгт тус тус заасны дагуу тооцоо хийнэ.
- (b) Дээрх заалт нь Хувьцаанд ногдол ашиг хуваарилах болох төлөх үүргийг Корпорацид хүлээлгэхгүй бөгөөд энэхүү Хөтөлбөрийн ямар ч заалтыг ийм үүрэг үүсгэсэн гэж тайлбарлахгүй.

### **8.2 Арилжааг түр зогсоох үе**

Хэрвээ арилжааг түр зогсоох үе үйлчилж байхад Урамшуулал дуусгавар болсон бол Урамшуулал дуусгавар болох хугацааг арилжааг түр зогсоох үе цуцлагдсан өдрийн дараах 10 Ажлын өдрөөр сунгана.

### **8.3 Татвар суутган авах**

Энэхүү Хөтөлбөрийн бусад заалтыг үл харгалзан хэрвээ энэхүү Хөтөлбөрийн дагуу Урамшуулал олгох, эзэмшүүлэх болон тооцоо хийхэд суутган татвар болон бусад суутгах үүргийг биелүүлэх шаардлагатай гэж Хөтөлбөрийн зохицуулагч өөрийн үзэмжээр шийдэж

тодорхойлсон бол тухайн суутгах үүргийг Хөтөлбөрийн зохицуулагчийн шаардлагад нийцүүлэн хангатаг Урамшуулал олгох, эзэмшүүлэх, тооцоо хийх ажиллагаа нь хүчин төгөлдөр болохгүй. Энэ тохиолдолд Хөтөлбөрийн зохицуулагч Корпораци, охин компаниас Урамшууллыг олгох, эзэмшүүлэх болон тооцоо хийхэд татвар суутган татварын албанд шилжүүлэх хамгийн бага дүнг Оролцогчоос Корпорацид төлөхийг шаардаж болно. Үүнтэй адил Урамшуулалтай холбоотой аливаа нэмэлт төлбөрийг Корпораци, охин компаниас холбогдох татварын албанд суутган төлөх шаардлагатай болсон өдрөөс хоцроолгүй төлнө. Үүнээс гадна, холбогдох хуульд заасан шаардлага, хязгаарлалтыг харгалзан Корпораци болон аливаа Харилцан хамааралтай этгээд (а) Оролцогчид Корпораци, Харилцан хамааралтай этгээдээс төлөх цалин, бусад төлбөрөөс тухайн дүнг суутгаж, (b) Урамшууллыг хэрэгжүүлэх, эзэмших, тооцоо хийх үед тухайн суутгах төлбөртэй адил дүнгээр Хувьцааг худалдан, олсон цэвэр орлогоос Корпорацид шилжүүлэхийг шаардаж, эсхүл (c) тухайн суутгах дүнг хүлээн авах бусад тохиромжтой зохицуулалтыг хийж болно.

#### **8.4 Нөхөн төлүүлэх**

Энэхүү Хөтөлбөрийн бусад нөхцөлийг үл харгалзан, Корпораци, түүний охин компаниас баталсан нөхөн төлүүлэх болон бусад төсөөтэй бодлого болон Оролцогчийн хөдөлмөрийн гэрээ, Урамшууллын гэрээ болон бусад бичгээр байгуулсан гэрээ, эсхүл хууль болон Хөрөнгийн биржийн дүрмийн дагуу Урамшуулалд хүчингүй болгох, хасалт хийх, цуцлах, буцаан төлөх болон нөхөн шаардах нөхцөл тавигдаж болно. Хөтөлбөрийн зохицуулагч аливаа Оролцогч болон Оролцогчдын бүлгийг энэхүү 8.4-р зүйлийн шаардлагаас хэдий ч чөлөөлж болно.

### **9 ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА ЭСВЭЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦУЦЛАХ**

#### **9.1 Ажилтан, Зөвлөх, ТУЗ-ийн гишүүний хөдөлмөрийн харилцааг цуцлах**

Доорх 9.2 дахь хэсгийг харгалзан Хөтөлбөрийн зохицуулагч өөрөөр тодорхойлсноос бусад тохиолдолд:

- (a) Хэрвээ Оролцогч хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг сайн дураараа цуцалсан, эсхүл Корпораци, түүний охин компани Шалтгааны улмаас цуцалсан бол Оролцогчийн Цуцлах өдрөөр хэрэгжүүлээгүй, буцаан шилжүүлэн өгөөгүй, тооцоо хийгээгүй Опцион ба бусад Урамшуулал нь, эзэмшүүлсэн эсэхээс үл хамааран, Цуцлах өдрөөр даруй хураагдаж, хүчингүй болно.
- (b) Хэрвээ Оролцогчийн хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон гэрээг Корпораци, түүний охин компани Шалтгаангүйгээр цуцалсан бол (цуцлахдаа хангалттай үндэслэл бүхий мэдэгдэл өгсөн эсэхээс, мөн үндэслэл бүхий мэдэгдлийн оронд нөхөн төлбөр өгсөн эсэхээс үл хамааран) эзэмшүүлээгүй байгаа бүх Опцион ба бусад Урамшуулал нь Цуцлах өдрөөр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (А) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (В) Цуцлах өдрөөс хойш 90 хоногийн дараах өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Хэрвээ дээрх өгүүлбэрийн (А) ба (В)-д заасны аль өмнө тохиосон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ

байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд Цуцлах өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд 7.4(b)-д заасан тооцоо хийх аль сүүлийн өдрийг баримтална.

- (c) Оролцогч Хөгжлийн бэрхшээлтэй болсны улмаас Оролцогчийн хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээ цуцлагдсан эсхүл ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж буй Оролцогч албан тушаал хашихаа больсон бол Цуцлах өдрөөр Оролцогчид эзэмшүүлээгүй байгаа Оролцогчийн аливаа Урамшууллыг тухайн өдөр эзэмшүүлнэ. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (А) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (В) Цуцлах өдрөөс хойш эхний жил тохиох өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд Цуцлах өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд 7.4(b)-д заасан тооцоо хийх аль сүүлийн өдрийг баримтална.
- (d) Оролцогч нас барсны улмаас Оролцогчийн хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээ цуцлагдсан эсхүл ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж буй Оролцогч албан тушаал хашихаа больсон бол нас барсан өдрөөр Оролцогчид эзэмшүүлээгүй байгаа Оролцогчийн аливаа Урамшууллыг тухайн өдөр эзэмшүүлнэ. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогчийн өв залгамжлагч буюу хуулийн дагуух төлөөлөгч нь (А) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (В) нас барсан өдрөөс хойш эхний жил тохиох өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Хэрвээ дээрх өгүүлбэрийн (А) ба (В)-д заасны аль өмнө тохисон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд нас барсан өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн Урамшууллын тооцоог Оролцогчийн өв залгамжлагч буюу хуулийн дагуух төлөөлөгчтэй хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд 7.4(b)-д заасан тооцоо хийх аль сүүлийн өдрийг баримтална.
- (e) Оролцогч тэтгэвэрт гарсны улмаас Оролцогчийн хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээ цуцлагдсан эсхүл ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж буй Оролцогч албан тушаал хашихаа больсон бол (i) Оролцогчийн Корпораци, охин компанид үргэлжлүүлэн үзүүлэх үйлчилгээнд үндэслэн эзэмшүүлэх, эсхүл хэрэгжүүлж болохуйц болох аливаа Урамшууллыг Оролцогчийн Цуцлах өдрөөр эзэмшүүлэх ба (ii) өмнө нь эзэмшүүлээгүй байгаа бөгөөд Гүйцэтгэлийн зорилтыг хангаснаар эзэмшүүлэх аливаа Урамшууллыг тухайн Гүйцэтгэлийн зорилтыг бодитоор хангаснаар эзэмших эрх нь үргэлжилнэ. Эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (А) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (В) Цуцлах өдрөөс хойш 90 хоногийн дараах өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болно. Хэрвээ дээрх өгүүлбэрийн (А) ба (В)-д заасны аль өмнө тохисон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болно. Дээрх (i)-д заасны дагуу эзэмшүүлсэн Урамшууллын хувьд (Опционоос бусад) Оролцогч тэтгэвэрт гарсан өдрийн дараа 90 хоногийн дотор тухайн

Урамшууллын тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд 7.4(b)-д заасан тооцоо хийх аль сүүлийн өдрийг баримтална. Дээрх (ii)-д заасны дагуу эзэмшүүлсэн Урамшууллын хувьд (Опционоос бусад) Оролцогч Корпораци болон охин компанид үйлчилгээ үзүүлсэн хэвээр байсан бол тооцоо хийх байсантай адил хугацаанд тухайн Урамшууллын тооцоог хийнэ.

- (f) Нас барсан, Хөгжлийн бэрхшээлтэй болсон, эсхүл Тэтгэвэрт гарснаас бусад шалтгаанаар ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг Оролцогч албан тушаал хашихаа больсон бол (i) бүх эзэмшүүлээгүй Урамшуулал Цуцлах өдрөөр нэн даруй хураагдаж, хүчингүй болно, (ii) эзэмшүүлсэн Опционыг Оролцогч нь (А) тухайн Опционы Дуусгавар болох өдөр (В) Цуцлах өдрөөс хойш 90 хоногийн дараах өдрийн аль өмнө тохисон өдөр дуусгавар болох хугацааны дотор хэдийд ч хэрэгжүүлж болох ба эсхүл дээрх өгүүлбэрийн (А) ба (В)-д заасны аль өмнө тохиосон өдрөөр Опционыг хэрэгжүүлээгүй хэвээрээ байвал тухайн хугацаа дуусгавар болсноор Опцион нь аливаа нөхөн төлбөргүйгээр нэн даруй хураагдаж, хүчингүй болох ба (iii) Опционоос бусад эзэмшүүлсэн Урамшууллын хувьд Цуцлах өдрийн дараа 90 хоногийн дотор тооцоог хийх бөгөөд ИОХЭ-ийн хувьд 7.4(b)-д заасан тооцоо хийх аль сүүлийн өдрийг баримтална.
- (g) Оролцогч энэхүү Хөтөлбөрийн дагуу (мөн 8.1 дэх хэсэгт заасны дагуу) дахин Опцион ба бусад Урамшуулал авах эрх дараах өдрөөр дуусгавар болно. Үүнд:
- (i). Цуцлах өдрөөс өмнө байхаас үл хамааран Оролцогчийн хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг цуцалсан талаар Корпораци, охин компаниас бичгээр мэдэгдэл өгсөн өдөр,
  - (ii). Оролцогч нас барсан, Хөгжлийн бэрхшээлтэй болсон, эсхүл тэтгэвэрт гарсан өдөр,
  - (iii). ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг Оролцогчийн хувьд аливаа бусад шалтгаанаар тухайн Оролцогч албан тушаал хашихаа больсон өдөр.
- (h) Дээр заасныг үл харгалзан Хөтөлбөрийн зохицуулагчаас 409А-д нийцүүлэн өөрийн үзэмжээр тухай бүр өөрөөр тодорхойлноос бусад тохиолдолд Оролцогч ТУЗ-ийн гишүүн, Ажилтан, Зөвлөхийн аль нэг байдлаар Корпораци, охин компаниуд дотроо, тэдгээрийн дунд хөдөлмөрийн, зөвлөх үйлчилгээний болон бусад гэрээгээр ажиллах болсон өөрчлөлт нь Опцион болон бусад Урамшуулалд нөлөөлөхгүй.
- (i) Энэхүү 9.1 дэх хэсэгт заасныг үл харгалзан, АНУ-ын Татвар төлөгчид эзэмшүүлсэн, эсхүл Оролцогч үйлчилгээг цуцалмагц (бүхлээр нь эсхүл хэсэгчлэн) эзэмшүүлэхээр олгосон Урамшуулал (Опционоос бусад)-ын хувьд 11.6(d) дэх хэсгийг харгалзан тухайн Оролцогч үйлчилгээг цуцалсны дараа аль болох боломжит хугацаанд тооцоог хийх бөгөөд энэхүү хугацаа нь ямар ч тохиолдолд Оролцогч үйлчилгээг цуцалснаас хойш 90 хоногоос хэтрэхгүй. Гүйцэтгэлийн нэг болон хэд хэдэн зорилтыг хангаснаар эзэмшүүлэхээр АНУ-ын Татвар төлөгчид олгосон Урамшуулал (Опционоос бусад) хэрвээ Оролцогч үйлчилгээг дуусгавар болгосон ч (бүхлээрээ болон хэсэгчлэн)

хүчинтэй хэвээр байх нөхцөлтэй бол тухайн Урамшууллын тооцоог хийхээр анх товлосон өдрөөр тооцоо хийнэ.

## **9.2 Түргэвчлүүлэх зөвшөөрөл олгох эрх хэмжээ**

9.1 дэх хэсэгт заасныг үл харгалзан Хөтөлбөрийн зохицуулагч өөрийн үзэмжээр дээрх хэсэг, хөдөлмөрийн гэрээ, Урамшууллын гэрээ болон Корпораци, охин компани Оролцогчтой бичгээр байгуулсан аливаа бусад гэрээнд заасан үйл явдал болохоос өмнө болон дараа хэдийд ч аливаа Урамшуулал эзэмшүүлэх хугацааг түргэвчлүүлэх, эсхүл аливаа Урамшууллыг цуцлахаас татгалзах зөвшөөрлийг өөрийн тогтоосон нөхцөл болзол, хэлбэрээр өгч болно.

# **10 АРАВДУГААР ЗҮЙЛ КОРПОРАЦИД НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ ЯВДАЛ**

## **10.1 Ерөнхий зүйл**

Урамшуулал бий болгосон нь Корпораци, түүний хувьцаа эзэмшигчид хэдийд ч Корпорацийн хөрөнгийн бүтэц, бизнесийг өөрчлөх, тохируулах, дахин хөрөнгө оруулах, өөрчлөн зохион байгуулах, нэгдэх, нийлэх зэрэг зохицуулалт хийх болон бонд, өрийн бичиг, хувьцаа болон бусад үнэт цаас гаргах, тэдгээрийн нөхцөл болзлыг тодорхойлох, Корпорацийг татан буулгах, хөрөнгө, бизнесийн худалдах, шилжүүлэх, эсхүл корпорацийн тусын тулд бусад арга хэмжээ авах эрх, эрх хэмжээнд ямар нэг байдлаар нөлөөлөхгүй ба нь энэхүү 10-р зүйлд заасан эрх хэмжээ нь энэхүү Хөтөлбөр, эсхүл түүний дагуу олгосон аливаа Урамшуулалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эсэхээс үл хамааран үйлчилнэ.

## **10.2 Хяналт өөрчлөгдөх**

Хөтөлбөрийн зохицуулагчийн зөвшөөрлөөр Урамшууллын гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд:

- (а) энэхүү 10.2 дахь хэсгийг харгалзан, гэхдээ энэхүү Хөтөлбөр болон Урамшууллын гэрээнд өөрөөр заасныг үл харгалзан Хөтөлбөрийн зохицуулагч нь Оролцогчийн зөвшөөрөлгүйгээр шаардлагатай гэж үзсэн аливаа арга хэмжээг авч болох ба үүнд дараах орно: (i) аливаа олгосон Урамшууллыг Хяналт өөрчлөгдөхөд оролцсон, эсхүл үүнээс үүдэн бий болсон этгээдийн адил үнэлгээ бүхий бусад үнэт цаас, эрхэнд Хөтөлбөрийн зохицуулагч үзэмжээрээ тодорхойлсноор шилжүүлэх, солих, (ii) Хяналт өөрчлөгдөх үйл явдал болмогц, эсхүл болохоос өмнө олгосон Урамшууллыг бүхэлд нь болон хэсэгчлэн эзэмшүүлэх, хэрэгжүүлэх, төлөх, түүнтэй холбоотой хязгаарлалтыг хүчингүй болгох болон Хөтөлбөрийг зохицуулагчийн тодорхойлсноор тухайн Хяналт өөрчлөгдөх үйл явдал болмогц, эсхүл болохоос өмнө Урамшууллыг цуцлах, (iii) хэлцэл хийх өдрийн байдлаарх Урамшууллыг хэрэгжүүлж, тооцоо хийх, Оролцогчийн эрхийг хэрэгжүүлэхэд авах дүнтэй тэнцүү дүнгээр тооцон Урамшууллыг цуцалж бэлнээр, эсхүл хөрөнгөөр төлөх (эргэлзээ төрүүлэхгүйн үүднээс, хэрвээ хэлцэл хийх өдрөөр Урамшууллыг хэрэгжүүлж, тооцоо хийх, Оролцогчийн эрхийг хэрэгжүүлэхэд төлбөр авах нөхцөл үүсээгүй гэж Хөтөлбөрийн зохицуулагч шударгаар үзсэн тохиолдолд Урамшууллыг аливаа нөхөн төлбөргүйгээр цуцалж болно), (iv) эзэмшигчид сөргөөр нөлөөлөхгүй бол ТУЗ-ийн



үзэмжээр сонгосон бусад эрх, хөрөнгөөр тухайн Урамшууллыг солих, эсхүл (v) Дээрх арга хэмжээг хослуулан авах. 10.2(a) хэсэгт зөвшөөрсөн аливаа арга хэмжээг авахдаа Хөтөлбөрийн зохицуулагч бүх Урамшуулалд адил хандах үүрэггүй.

(b) 9.1-т заасныг үл харгалзан, Корпораци, охин компани болон Оролцогчийн хооронд бичгээр байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Хяналт өөрчлөх үр дагавартай хэлцэл хийснээс хойш 12 сарын дотор хэрвээ Оролцогчийн хөдөлмөр эрхлэлт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон ТУЗ-ийн гишүүнээр ажиллахыг Шалтгаангүйгээр Корпораци, охин компани цуцалсан бол:

(i). Цуцлах өдрөөр Оролцогчийн эзэмшээгүй байгаа аливаа Урамшууллыг нэн даруй эзэмшүүлэх, ба

(ii). 5.4(d) ба 6.6(d) дахь хэсэгт заасныг харгалзан Оролцогчийн эзэмшиж байгаа аливаа Урамшууллыг (А) тухайн Урамшууллын дуусгавар болох өдөр эсхүл (В) Цуцлах өдрөөс хойш 90 дэх хоногийн аль түрүүлж тохиосон хугацааны дотор Оролцогч нь хэрэгжүүлэх, буцаан шилжүүлэх болон тооцоо хийж болно. АНУ-ын Татвар төлөгчид олгож эзэмшүүлсэн Урамшууллын тооцоог (Опционоос бусад) Оролцогчийн “үйлчилгээнээс тусгаарлагдсан” гэж үзэх өдрөөс хойш 90 хоногийн дотор хийнэ. Дээрх хугацаа дуусахад хэрэгжүүлээгүй, буцаан шилжүүлээгүй, тооцоо хийгээгүй аливаа Урамшууллыг нэн даруй хурааж, хүчингүй болгоно.

(c) 10.2(a) дахь дэд хэсэгт заасныг үл харгалзан, Хөтөлбөрийн зохицуулагч өөрөөр тодорхойлсноос бусад тохиолдолд хэрвээ Хяналт өөрчлөх үйл явдлаас шалтгаалан Хувьцааг Хөрөнгийн биржид арилжаалахаа больсон бол Корпораци нь Хяналт өөрчлөх хэлцэл хүчин төгөлдөр болох үед энэхүү Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг бүхэлд нь буюу хэсэгчлэн цуцлах ба ингэхдээ Хяналт өөрчлөх хэлцэл хүчин төгөлдөр болсны дараа боломжит хугацаанд Хөтөлбөрийн зохицуулагчийн тодорхойлсон дүн буюу тухайн Оролцогчийн эзэмшиж байгаа Урамшууллын зах зээлийн бодит үнэлгээтэй тэнцүү дүнгээр төлбөр төлнө. АНУ-ын Татвар төлөгчид олгосон Урамшууллын тооцоог Хяналт өөрчлөх үйл явдал болсноос хойг 90 хоногийн дотор хийнэ.

(d) АНУ-ийн Татвар төлөгчид олгосон Урамшуулалтай холбоотойгоор энэхүү 10.2 дахь хэсэгт заасан аливаа арга хэмжээ нь Хуулийн 409А хэсэгт заасан шаардлагад нийцнэ.

### **10.3 Корпорацийн хөрөнгийг өөрчлөн зохион байгуулах**

Хэрвээ Корпораци Хувьцааны дэд ангилал гаргах, Хувьцааг нэгтгэх болон хөрөнгөө бусад төсөөтэй байдлаар өөрчлөн зохион байгуулах, хувьцаагаар ногдол ашгийн төлбөр төлөх (бэлнээр төлөх ногдол ашгийн оронд хувьцаагаар төлөх ногдол ашгаас бусад) бол, эсхүл Хяналт өөрчлөх үйл явдалд тооцогдохгүй Корпорацийн дахин хөрөнгөжүүлэлтээр бусад аливаа өөрчлөлт орсон ба Урамшуулал эзэмшиж байгаа Оролцогчийн эрх үүргийг хувь тэнцүүлэн хадгалах үүднээс Хувьцааны тоог, эсхүл Урамшууллын нөхцөлийг өөрчлөхөөр Урамшууллыг солих, түүнд өөрчлөлт оруулах бол Хөтөлбөрийн зохицуулагч нь

шаардлагатай бол Хөрөнгийн биржээс урьдчилан авах зөвшөөрөл авсныг үндсэн дээр дээрхийг хийхэд зайлшгүй гэж үзсэн аливаа зохих арга хэмжээг авах зөвшөөрлийг олгоно.

#### **10.4 Корпорацид нөлөөлөх бусад үйл явдал**

Нэгдэх, нийлүүлэх болон бусад Корпорацийг хамарсан өөрчлөн зохион байгуулалт хийх Хувьцааг солих, хөрөнгийг худалдах болон түрээслэх зэрэг Хяналт өөрчлөх үйл явдалд тооцогдохгүй үйл явдал болсон тохиолдолд Урамшуулал эзэмшиж байгаа Оролцогчийн эрх үүргийг хувь тэнцүүлэн хадгалах үүднээс Урамшууллыг хэрэгжүүлж авч болох Хувьцааны тоо, ангилал, эсхүл Урамшууллын нөхцөлд өөрчлөлт оруулах бол Хөтөлбөрийн зохицуулагч нь шаардлагатай бол Хөрөнгийн Биржээс урьдчилан авах зөвшөөрөл авсныг үндсэн дээр дээрхийг хийхэд зайлшгүй гэж үзсэн аливаа зохих арга хэмжээг авах зөвшөөрлийг олгоно.

#### **10.5 Урамшууллыг нэн даруй эзэмшүүлэх**

10.3 ба 10.4 дэх хэсэгт заасан аливаа арга хэмжээг авахдаа Хөтөлбөрийн зохицуулагч бүх Урамшуулалд адил хандах албагүй бөгөөд хэрвээ 10.3 ба 10.4-т заасан арга хэмжээ Урамшууллыг эзэмшигч байгаа Оролцогчийн эрх, үнэлгээ, үүргийг хувь тэнцүүлэн хадгалж чадахгүй гэж үзвэл эзэмшүүлээгүй Урамшууллыг нэн даруй эзэмшүүлэх зөвшөөрлийг Хөтөлбөрийн зохицуулагч өгч болох боловч ийм үүрэг хүлээхгүй.

#### **10.6 Корпораци нэмэлт хувьцаа гаргах**

10-р зүйлд тодорхой зааснаас бусад тохиолдолд Корпораци аливаа төрлийн хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, тэдгээрийг хөрвүүлэх, хэрэгжүүлэх нь, мөн ийм зорилгоор хувьцааны тоонд тохируулга хийх нь Урамшууллыг олгосноос үүдэн олж авах Хувьцааны тоонд нөлөөлөхгүй.

#### **10.7 Бутархай хувьцаа**

Урамшууллын дагуу бутархай Хувьцаа гаргахгүй. Хэрвээ энэхүү Хөтөлбөрийн дагуу Оролцогч бутархай Хувьцаа авах эрх үүсвэл тухайн Оролцогч зөвхөн бүхэл тооны Хувьцааг авах эрхтэй бөгөөд бутархайг хүчингүй болгож, бутархайтай холбоотой аливаа төлбөр төлөх болох тохируулга хийхгүй.

### **11 АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ АНУ-ЫН ТАТВАР ТӨЛӨГЧ**

#### **11.1 АНУ-ын татвар төлөгчдөд хамааралтай заалт**

Энэхүү Хөтөлбөрийн дагуу АНУ-ны Татвар төлөгчдөд олгосон Опцион нь Хуулийн 422 дахь хэсэгт хамаарах урамшууллын хувьцааны опцион (“УХО”) эсхүл түүнд хамаарахгүй хувьцааны опцион байж болно. Опцион бүрийг Урамшууллын гэрээнд УХО, эсхүл хуулийн шаардлагад хамаарахгүй хувьцааны опцион гэж тодорхойлон оруулна. Хэрвээ Урамшууллын гэрээнд ийнхүү УХО, эсхүл хуулийн шаардлагад хамаарахгүй хувьцааны опцион гэж тодорхойлон оруулаагүй бол Опцион нь хуулийн шаардлагад хамаарахгүй опцион байна. УХО гэж гаргасан Опцион УХО-ын шаардлагад хамаарахгүй байвал

Корпорац аливаа Оролцогч болон бусад аливаа этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй. Хуулийн шаардлагад хамаарахгүй хувьцааны опционыг зөвхөн дараах тохиолдолд АНУ-ын Татвар төлөгчид олгоно: (i) тухайн АНУ-ын Татвар төлөгч 409А хэсэгт тодорхойлсны дагуу Корпораци, түүний шууд болон шууд бусаар хяналтыг хэрэгжүүлдэг, томоохон ашиг сонирхлыг эзэмшдэг бусад аливаа корпораци, байгууллагад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тухайн Опцион нь 409А хэсэгт заасан “үйлчилгээ үзүүлсний хувьцаа”-г олж авах утгыг агуулсан байх, эсхүл (ii) тухайн опцион бусад байдлаар 409А хэсэг заасан шаардлагаас чөлөөлөгдсөн байх.

## **11.2 УХО**

3.6 дахь хэсгийн хязгаарлалтыг харгалзан УХО олгосонтой холбоотойгоор гаргахаар хадгалах нийт Хувьцааны тоо 5,000,000 ширхэг Хувьцаа байх ба Олгох өдрөөр АНУ-ын Татвар төлөгчид олгосон аливаа УХО-ын нөхцөл болзол нь (УХО авах эрхтэй этгээд зэрэг) Хуулийн 422 дахь хэсэгт болон энэхүү Хөтөлбөрийн дагуу Хөтөлбөрийн зохицуулагчаас тухай бүр гаргах аливаа нөхцөл болзол, хязгаарлалт болон захиргааны журамд нийцсэн байна. Хөтөлбөрийн зохицуулагчийн үзэмжээр УХО-ыг зөвхөн Корпораци, эсхүл Хуулийн 424(e) ба (f) хэсэгт заасан тодорхойлолтод нийцэх Корпорацийн “толгой компани”, “охин компани”-д тус тус ажилладаг хувь хүнд олгож болно.

## **11.3 10% хувьцаа эзэмшигчдэд олгох УХО**

Энэхүү Хөтөлбөрт өөрөөр заасныг үл харгалзан, хэрвээ Олгох өдрийн байдлаар Корпораци, Хуулийн 424 (e) ба (f) хэсэгт заасан тодорхойлолтод нийцэх Корпорацийн “толгой компани”, “охин компани”-ийн бүх ангиллын хувьцааны санал өгөх эрхийн 10-аас дээш хувийг илэрхийлэх хувьцааг эзэмшдэг хүнд УХО-ыг олгосон бол тухайн Опционы хугацаа түүнийг олгосноос хойш таван жилээс хэтрэхгүй байх ба Опционы Хэрэгжүүлэх үнэ хамгийн багадаа Хувьцааны Зах зээлийн үнийн 110% байна.

## **11.4 УХО-ын жилийн \$100,000 хязгаарлалт**

Хэрвээ хуанлийн жилд аливаа этгээд анх удаа УХО-ыг хэрэгжүүлэхэд Хувьцаа олгох өдрийн байдлаар Зах Зээлийн нийт үнэ \$100,000 ам.доллароос хэтэрвэл (Корпораци, Хуулийн 424 (e) ба (f) хэсэгт заасан тодорхойлолтод нийцэх Корпорацийн “толгой компани”, “охин компани”-ийн бүх хөтөлбөрийн дагуу), ийнхүү хэтэрсэн УХО-ыг хуулийн шаардлагад хамаарахгүй хувьцааны опцион гэж үзнэ.

## **11.5 Шаардлага хангахгүй захиран зарцуулалт**

Энэхүү Хөтөлбөрийн дагуу УХО авсан Оролцогч тухайн УХО-ыг хэрэгжүүлсний дагуу олж авсан аливаа Хувьцааг захиран зарцуулж, шилжүүлсэн бөгөөд ингэхдээ (a) Олгосон өдрөөс хойш хоёр жилийн дотор, эсхүл (b) Хувьцааг олж авсан өдрөөс хойш нэг жилийн дотор захиран зарцуулж, шилжүүлсэн бол тухайн өдрийн дараа нэн даруй Корпорацид бичгээр мэдэгдэнэ. Тухайн мэдэгдэлд захиран зарцуулж, шилжүүлсэн өдөр, Оролцогч тухайн шилжүүлгээс бэлнээр, хөрөнгөөр, өр төлбөр болон бусад нөхөн төлбөрөөр олж авсан орлогын дүнг дурдана. Хэрвээ Хөтөлбөрийн зохицуулагч шаардлагатай гэж үзсэн бол холбогдох журмын дагуу Корпораци Оролцогчийн төлөөлөгчийн хувиар УХО-ыг хэрэгжүүлж олж авсан Хувьцааг дээрх (a) ба (b)-д заасан хугацааны аль сүүлд тохиох өдөр

хүртэл эзэмших болох бөгөөд ингэхдээ тухайн Хувьцааг худалдах талаарх Оролцогчийн зааврыг дагаж мөрдөнө.

### 11.6 Хуулийн 409А хэсэг

- (a) Татварын үр дагаврыг хадгалах үүднээс энэхүү Хөтөлбөрийг Хуулийн 409А хэсэгт заасан шаардлагаас чөлөөлөгдсөн гэж, хэрвээ ийнхүү чөлөөлөгдөхгүй бол түүний шаардлагад нийцсэн гэж тайлбарлаж, хэрэглэнэ. Энэхүү Хөтөлбөрт Хуулийн 409А хэсгийг дурдсан нь түүнтэй холбоотойгоор Дотоодын Орлогын Үйлчилгээний газраас гаргасан аливаа дүрэм, журам, албан ёсны удирдамжийг мөн дурдсан гэж тооцогдоно. Аливаа Урамшууллыг (i) Хуулийн 409А хэсгийн шаардлагаас чөлөөлөгдсөн, эсхүл (ii) Хуулийн 409А хэсгийн шаардлагыг хангасан байдлаар тайлбарлаж, зохион байгуулна. Хэрвээ Урамшуулал нь Хуулийн 409А хэсэгт хамаарах бол (A) хуваарилалтыг Хуулийн 409А хэсэгт зөвшөөрөгдсөн байдлаар хийнэ (B) хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээг цуцалсны дараа хийх төлбөрийг Хуулийн 409А хэсэгт заасан “үйлчилгээнээс тусгаарлагдсан” гэдэг шаардлагын дагуу хийнэ (C) Урамшуулалд өөрөөр заагаагүй бол хэсэгчлэн төлөх төлбөр бүрийг Хуулийн 409А хэсэгт заасан зорилгоор тусдаа төлбөр гэж тооцох ба (D) Хуулийн 409А хэсэгт зааснаас бусдаар хуваарилалт хийсэн хуанлийн жилийг Оролцогч нь шууд болон шууд бусаар тогтоохгүй. Урамшуулал, төлбөр, урамшууллыг хэрэгжүүлэх, түүний тооцоо хийх, хойшлуулах зэргийг Хуулийн 409А хэсгийн шаардлагуудын дагуу тухайн олголт, төлбөр, тооцоо, хойшлуулах зэргийг Хуулийн 409А хэсгийн дагуу аливаа нэмэлт татвар, хүү тооцохгүй байхаар зохицуулна. Корпораци нь татварын үр дагаврыг хадгалж үлдэх зорилгоор шаардлагатай бол энэхүү Хөтөлбөрт Хуулийн 409А хэсэгт нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй байна. Ямар ч тохиолдолд Корпораци, түүний охин компани болон Харилцан хамааралтай этгээд Хуулийн 409А хэсгийн дагуу Оролцогчид оноосон аливаа татвар, хүү, торгууль болон уг хэсгийг биелүүлээгүйгээр учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
- (b) Хэрвээ Хуулийн 409А хэсэг нийцүүлэх шаардлагатай гэж үзвэл энэхүү Хөтөлбөрийн тодорхой бус, эсхүл тусгайлан тодорхойлоогүй бүх нөхцөлийг Хуулийн 409А хэсэгт нийцсэн байдлаар тайлбарлана.
- (c) Хөтөлбөрийн зохицуулагч нь Хуулийн 409А хэсэгт зөвшөөрөгдсөн урагшлуулах үйл баримт бий болбол АНУ-ын Татвар төлөгчид Хөтөлбөрийн дагуу эзэмшүүлсэн Урамшууллын төлбөрийн хугацаа, хуваарийг урагшлуулах зөвшөөрлийг өөрийн үзэмжээр олгож болно.
- (d) Хөтөлбөрт өөрөөр заасныг үл харгалзан, Хуулийн 409А хэсгийн “тодорхой ажилтан” гэсэн тодорхойлолтод хамаарах АНУ-ын Татвар төлөгчийн хувьд Хуулийн 409А хэсгийн дагуу “үйлчилгээнээс тусгаарлагдсантай”-тай холбогдуулан төлсөн хойшлуулсан нөхөн төлбөрийн хуваарилалтыг үйлчилгээнээс тусгаарлагдсан өдрөөс хойш зургаан сар өнгөрөхөөс өмнө хийж болохгүй (хэрвээ АНУ-ын Татвар төлөгч нас барсан бол түүнээс өмнө). Дээрх өгүүлбэрийн дагуу төлбөрийн аливаа хоцорсон дүнг үйлчилгээнээс тусгаарлагдсан өдрөөс хойш зургаан сарын дараа аль болох боломжит хугацаанд төлнө.

## **11.7 АНУ-ын Татвар төлөгчдөд 11-р зүйл үйлчлэх талаар**

Тодорхой байлгах үүднээс, энэхүү 11-р зүйл зөвхөн АНУ-ын Татвар төлөгчдөд үйлчилнэ.

## **12 АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ**

### **12.1 Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, цуцлах**

Хөтөлбөрийн зохицуулагч өөрийн үзэмжээр хэрвээ шаардлагатай гэж үзвэл Корпорацийн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж, зөвшөөрөл авахгүйгээр энэхүү Хөтөлбөр болон Хөтөлбөрийн дагуу олгосон Урамшууллыг өөрчлөх, нэмэлт оруулах, солих, түдгэлзүүлэх болон цуцалж болно. Гэхдээ дараах шаардлагыг хангана:

- (a) Хөтөлбөрийн зохицуулагч Үнэт цаасны тухай хууль тогтоомж, Хөрөнгийн биржийн шаардлагыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд Хөтөлбөр болон түүний дагуу олгосон Урамшууллыг өөрчлөх, нэмэх, түдгэлзүүлэх болон цуцлах нь Оролцогчийн эрх ашгийг ноцтой хөндөхгүй бөгөөд Оролцогчийн зөвшөөрөлгүйгээр түүний үүргийг ноцтой нэмэгдүүлэх ёсгүй,
- (b) АНУ-ын Татвар төлөгчийн эзэмшиж байгаа Урамшууллыг өөрчилснөөр Хуулийн 409А хэсэгт заасан орлогод хамаарах бол тухайн өөрчлөлт нь АНУ-ын Татвар төлөгчийн зөвшөөрлийг авахаас бусад тохиолдолд түүний хувьд эхнээсээ хүчин төгөлдөр бус гэж тооцогдоно.

### **12.2 Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл**

Дээрх 12.1 дэх хэсэгт заасны үл харгалзан Хөрөнгийн Биржийн аливаа дүрэм журамд нийцүүлэх дараах өөрчлөлтийг оруулахад Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авна. Үүнд:

- (a) 10-р зүйлд заасны дагуу Корпораци ба түүний хөрөнгөд нөлөөлөх хэлцэл хийх үед зохих өөрчлөлтийг Хөтөлбөрийн зохицуулагч хийж болохыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд Хөтөлбөрийн дагуу гаргахаар хадгалсан Хувьцааны тоог өсгөх,
- (b) 3.7(a) дахь дэд хэсэгт заасны дагуу Дотоод мэдээлэл эзэмшигчид гаргасан буюу гаргах Хувьцааны хувь хэмжээний хязгаарлалтыг өсгөх эсхүл хасах,
- (c) Корпораци ба түүний хөрөнгөд нөлөөлөх хэлцэл хийх үед зохих өөрчлөлтийг Хөтөлбөрийн зохицуулагч хийж болохыг Хөтөлбөрийн заалтуудын дагуу зөвшөөрснөөс бусад тохиолдолд Дотоод мэдээлэл эзэмшигчийн эзэмшиж буй Опционы Урамшууллыг хэрэгжүүлэх үнийг багасгах,
- (d) Дотоод мэдээлэл эзэмшигчийн эзэмшиж буй Опционы хугацааг анхны Дуусгавар болох өдрөөс хойш сунгах, болон
- (e) энэхүү 12-р зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах.

### **12.3 Зөвшөөрөгдсөн нэмэлт өөрчлөлт**

Дээрх 12.1 дэх хэсэгт заасныг хөндөхгүйгээр, гэхдээ 12.2 дахь хэсгийг харгалзан Хөтөлбөрийн зохицуулагч нь Хөтөлбөрт дараах зорилгоор тухай бүр хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Үүнд:

- (a) Урамшуулал тус бүрийг эзэмшүүлэх ерөнхий заалтуудад өөрчлөлт оруулах,
- (b) 9-р зүйлд заасан зохицуулалтад өөрчлөлт оруулах,
- (c) Оролцогчдын эрх, ашиг сонирхолд өөрчлөлт сөргөөр нөлөөлөхгүй гэж Хөтөлбөрийн зохицуулагч шударгаар үзсэн тохиолдолд Оролцогчийг хамгаалахаар Корпорацийн амлалтыг нэмэгдүүлэх өөрчлөлт оруулах,
- (d) 13.9 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулах,
- (e) Оролцогчдын эрх, ашиг сонирхолд өөрчлөлт сөргөөр нөлөөлөхгүй гэж Хөтөлбөрийн зохицуулагч шударгаар үзсэн тохиолдолд Оролцогчийн оршин суух харьяалал, хуулийн өөрчлөлтөөс шалтгаалан хөтөлбөрт нийцээгүй асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах нь оновчтой гэж үзсэн аливаа өөрчлөлтийг оруулах,
- (f) Оролцогчдын эрх, ашиг сонирхолд өөрчлөлт сөргөөр нөлөөлөхгүй гэж Хөтөлбөрийн зохицуулагч шударгаар үзсэн тохиолдолд Корпорацийн зөвлөхийн өгсөн зөвлөгөөнд үндэслэн тодорхойгүй утга санаатай, алдаатай, хоорондоо нийцээгүй заалтууд болон орхигдуулсан зүйлийг засах зорилгоор холбогдох өөрчлөлт, засваруудыг оруулах, болон
- (g) Үндсэн эсэхээс үл хамааран холбогдох хууль, Хөрөнгийн Биржийн дүрэм журмаар хувьцаа эзэмшигчийн зөвшөөрлийг авахгүйгээр аливаа бусад өөрчлөлтийг хийх.

## **13 АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ БУСАД ЗҮЙЛ**

### **13.1 Хуулийн шаардлага**

Хэрэв Хөтөлбөрийн зохицуулагч дараах үйлдлийг гүйцэтгэснээр аливаа засгийн газар, төрийн байгууллагын холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын аливаа заалт, эсвэл Хөрөнгийн биржийн шаардлагыг Оролцогч, эсхүл Корпораци зөрчинө гэж үзвэл Корпораци нь аливаа Урамшуулал, Хувьцаа эсвэл бусад үнэт цаас олгох, ямар нэгэн төлбөр төлөх болон бусад үйлдлийг гүйцэтгэх үүрэггүй.

### **13.2 Бусад олговор байхгүй талаар**

Хөтөлбөрийн дагуу Оролцогчид хувьцааны үнийн бууралтын хэлбэлзлийг нөхөхийн тулд ямар нэгэн төлбөр төлөхгүй ба ийм зорилгоор Оролцогчид болон түүнд хамаарах бусад төрлийн олговрыг өгөхгүй.

### **13.3 Оролцогчийн эрх**

Аль ч Оролцогчид аливаа Урамшуулал авах эрх, баталгаа байхгүй ба Урамшуулал олгох нь Оролцогчийг Ажилтан, Зөвлөх, ТУЗ-ийн гишүүний албан тушаалд үлдэх баталгаа олгохгүй. Аль ч Оролцогч түүнд, эсхүл түүний томилсон этгээдэд Хувьцаа гаргаж, эзэмшүүлэх хүртэл Корпорацийн хувьцаа эзэмшигчийн хувиар Хувьцаатай холбоотой аливаа эрхийг эдлэхгүй.

### **13.4 Байгууллагаас авах арга хэмжээ**

Энэхүү Хөтөлбөр эсвэл аливаа Урамшуулалд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг эс тооцон, Хөтөлбөр болон Урамшууллын гэрээнд тусгагдсан аль ч зүйлийг Корпорациас зохих буюу түүний ашиг сонирхолд нийцсэн гэж үзсэн арга хэмжээ авахаас сэргийлэх үндэслэлтэй хэмээн ойлгохгүй.

### **13.5 Зөрчилдөөн**

Энэхүү Хөтөлбөрийн болон Урамшууллын гэрээний заалтууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Урамшууллын гэрээний заалтыг баримтална. Нэг талд энэхүү Хөтөлбөрийн заалт эсвэл аливаа Урамшууллын гэрээний заалт, нөгөө талд Корпораци эсвэл түүний охин компани болон Оролцогчийн хөдөлмөрийн гэрээний хооронд гарч болзошгүй зөрчилдөөн илэрвэл, Хөтөлбөрийн заалт эсвэл Урамшууллын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **13.6 Хэджингийн эсрэг бодлого**

Урамшууллыг хүлээн авснаар Оролцогч бүр Урамшууллын зах зээлийн үнэ цэнийг бууруулахад чиглэсэн урьдчилан төлсөн хувьсах форвард гэрээ, хувьцааны своп, зах зээл, эсвэл солилцооны сангийн нэгж зэрэг санхүүгийн хэрэгслийг худалдан авах эрх хязгаарлагдахыг хүлээн зөвшөөрсөн болно.

### **13.7 Оролцогчийн мэдээлэл**

Оролцогч тус бүр Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Корпорациас шаардсан бүх мэдээллийг (хувийн мэдээлэл үүнд мөн орсон) Корпорацид өгнө. Оролцогч тус бүр Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Корпорациас шаардсан бүх мэдээлэл нь Хөтөлбөрийн дагуу томилогдсон төлөөлөгч, бусад гуравдагч этгээд, Хөтөлбөрийн удирдлагатай холбоотой (Оролцогчийн оршин суух харьяаллаас бусад харьяалалд байгаа этгээдүүдийг оролцуулан) этгээдэд нээлттэй байхыг хүлээн зөвшөөрсөн. Оролцогч тус бүр уг мэдээллийн нээлттэй байдлыг зөвшөөрч Корпорацид өөрсдийн нэрийн өмнөөс тус мэдээллийг хуваалцах эрхийг олгоно.

### **13.8 Хөтөлбөрт оролцох**

Хөтөлбөрт орсон бүх Оролцогчдын оролцоо нь албан журмынх бус сайн дурынх байх бөгөөд Хөтөлбөрт тодорхой заасан эрх, давуу эрхээс бусад ямар нэгэн эрх, давуу эрх олгох утга агуулаагүй. Тодруулбал, Хөтөлбөрт оролцох нь тухайн Оролцогчийг үргэлжлүүлэн ажиллуулах, ажиллуулахыг баталгаажуулах Корпорацийн зүгээс ажил эрхлэлт, оролцооны нөхцөл бүрдүүлээгүй болно. Хөтөлбөр нь хувьцааны зах зээлийн үнийн хэлбэлзлээс үүдэн гарах аливаа алдагдлаас хамгаалах ямар нэгэн баталгаа өгөхгүй. Оролцогчдын орлогын



болон бусад татварын үр дагаврыг Корпораци хүлээхгүй бөгөөд өөрсдийн татварын зөвлөхүүдтэй ажиллахыг зөвлөж байна.

### **13.9 Олон улсын Оролцогчид**

Канад болон Америкийн Нэгдсэн Улсаас бусад улсад оршин суудаг эсвэл ажилладаг Оролцогчидтой холбоотойгоор Хөтөлбөрийн зохицуулагч хувьцаа эзэмшигчээс зөвшөөрөл авалгүйгээр Хөтөлбөр болон Урамшууллын нөхцөлүүдийг дотоод хууль, тогтоомжтой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба Хөтөлбөрийн зохицуулагч тохиромжтой гэж үзвэл, нэмэлт өөрчлөлт орсон заалтуудад тусгах дэд хөтөлбөр боловсруулж болно.

### **13.10 Эрх залгамжлал**

Хөтөлбөрийг Корпораци болон түүний охин компаниудын эрх залгамжлагчид болон эрх шилжүүлэн авагчид дагаж мөрдөх үүрэгтэй.

### **13.11 Шилжүүлэгт тавих ерөнхий хориг**

Хуульд заасан болон энэхүү Хөтөлбөрт тодорхой заагаагүй тохиолдолд Хөтөлбөртэй холбоотой Оролцогчийн эрхийг бусдад шилжүүлэх, өмчлүүлэх, худалдах, барьцаалах боломжгүй ба Хөтөлбөрийн зохицуулагч өөрөөр зөвшөөрөөгүй бол Оролцогчийн аливаа өр, үүргийг төлөхийн тулд зээлдүүлэгчид шилжүүлэх, хуулийн процесст хамрагдах боломжгүй.

### **13.12 Тус тусдаа үйлчлэл**

Энэхүү Хөтөлбөрийн аливаа заалт хүчин төгөлдөр бус эсвэл хэрэгжих боломжгүй байгаа нь бусад заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд хүчингүй эсвэл хэрэгжих боломжгүй аливаа заалтыг энэхүү Хөтөлбөрөөс хасна.

### **13.13 Мэдэгдэл**

Оролцогчоос Корпорацид өгөх бичгээр үйлдсэн мэдэгдлийг биечлэн, эсвэл цахим шуудан, шуудан, шуудангийн төлбөрийг урьдчилан төлж, Корпорацийн бүртгэлтэй оффис руу илгээнэ, Хаяглах албан тушаалтан: Санхүүгийн Хариуцсан Захирал. Оролцогчид хандсан бүх мэдэгдлийг Корпорацид хадгалагдсан Оролцогчийн үндсэн хаяг руу илгээнэ. Корпораци эсвэл Оролцогчийн аль нэг нь нөгөөдөө бичгээр мэдэгдэх замаар хаягаа өөрчилж болно. Уг мэдэгдлийг ажлын өдөр өөрийн биеэр эсвэл цахим шуудангаар хүргүүлсэн тохиолдолд хүргэсэн өдөр эсвэл тухайн өдрийн дараагийн ажлын өдөр хүлээж авснаар тооцож, шуудангаар илгээсэн бол тухайн өдрөөс хойш ажлын тав дахь өдөр хүлээн авсан гэж үзнэ. Хүлээн авагч Оролцогч эсвэл Корпорацитай өгсөн аливаа мэдэгдлийг хүлээн авах хүртэл биелүүлэх үүрэг хүлээхгүй.

### **13.14 Хүчин төгөлдөр болох өдөр**

Энэхүү Хөтөлбөр нь Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлөөр Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

### **13.15 Үйлчлэх хууль**

Энэхүү Хөтөлбөр болон энд дурдсан бүх асуудлыг Нова Скошиа мужийн хууль тогтоомжийн дагуу зохицуулж, тайлбарлах ба зөрчилдөөний хэм хэмжээг харгалзахгүйгээр Канад улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

### **13.16 Харьяалал**

Корпораци болон Оролцогч тус бүр Хөтөлбөртэй холбоотой (гэхдээ үүгээр хязгаарлахгүйгээр) болон Хөтөлбөрийн дагуу Урамшуулал олгох, аливаа Хувьцаа гаргах арга хэмжээ, үйл ажиллагаанд Нова Скошиа муж дахь эрх бүхий шүүхүүдийн онцгой харьяаллыг эргэлт буцалтгүйгээр дагана.

Энэхүү материал нь англи хэл дээр бэлтгэгдсэн материалын орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

## ХАВСРАЛТ А

### ЭРДЭНЭС РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

#### ХУВЬЦААНД СУУРИЛСАН УРАМШУУЛЛЫН БАГЦ ХӨТӨЛБӨР ("ХӨТӨЛБӨР")

#### СОНГОХ МЭДЭГДЭЛ

Энд ашигласан боловч өөрөөр тодорхойлогдоогүй бүх том үсгээр бичсэн нэр томъёог Хөтөлбөрт тусгасан утгаар ойлгоно.

Хөтөлбөрийн дагуу би Хөтөлбөрийн 7-р зүйлд заасны дагуу ИОХЭ олгох ажиллагаанд оролцож, Бэлэн төлбөрийн \_\_\_\_%-ийг ИОХЭ хэлбэрээр авахаар сонгож байна.

Хэрэв би АНУ-ын татвар төлөгч бол энэ Сонгох Мэдэгдэлд хамаарах аливаа ИОХЭ-ийн тооцоог (i) миний "үйлчилгээнээс тусгаарлагдсан" (409А хэсэгт заасан утгаар) болон (ii) \_\_\_\_\_-ын аль сүүлд тохиох үед хийхийг Би үүгээр сонгож байна.

Миний бие доорх заалтуудыг зөвшөөрч байна:

- (a) Би Хөтөлбөрийн хуулбарыг хүлээн авч, хянаж үзээд Хөтөлбөрийн нөхцөлийг дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.
- (b) Ийнхүү сонгосны үр дүнд тооцсон ИОХЭ-үүдийг Хөтөлбөрийн нөхцөлийн дагуу тооцоо хийхэд шаардлагатай бол орлогын албан татвар болон бусад суутгалууд үүснэ гэдгийг ойлгож байгаа бөгөөд Корпораци холбогдох суутгалыг тухайн тухайн үеийн хууль тогтоомжийн дагуу хийнэ гэдгийг би хүлээн зөвшөөрч байна.
- (c) ИОХЭ-ийн үнэлгээ нь Корпорацийн хувьцааны үнэлгээнд суурилдаг тул баталгаагүй болно.
- (d) Би АНУ-ын татвар төлөгчийн хувьд энэ сонголт хамаарах санхүүгийн жилийн хувьд буцаах боломжгүй ба, сонгосон хугацаа дууссаны дараа энэ сонголтыг хүчингүй болгох, дуусгавар болгох нь миний Корпорацид хүчингүй болгох, дуусгавар болгох тухай мэдэгдлийг ирүүлснээс хойших санхүүгийн жилийн эхний өдөр хүртэл хүчин төгөлдөр болохгүй гэдгийг ойлгож байна.

Дээр дурдсан зүйл бол Хөтөлбөрийн зарим гол заалтуудын зөвхөн товч тойм юм. Илүү бүрэн мэдээлэл авахын тулд Хөтөлбөрийн агуулгаас харна уу.

Огноо: \_\_\_\_\_

\_\_\_\_\_  
(Оролцогчийн нэр)

\_\_\_\_\_  
(Оролцогчийн гарын үсэг)

## ХАВСРАЛТ В

### ЭРДЭНЭС РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

#### ХУВЬЦААНД СУУРИЛСАН УРАМШУУЛЛЫН БАГЦ ХӨТӨЛБӨР ("ХӨТӨЛБӨР")

#### НЭМЭЛТ ИОХЭ -ийг ХҮЛЭЭН АВАХАА ЦУЦЛАХ СОНГОЛТ

Энд ашигласан боловч өөрөөр тодорхойлогдоогүй бүх том үсгээр бичсэн нэр томъёог Хөтөлбөрт тусгасан утгаар ойлгоно.

Хөтөлбөрийн А Хавсралтад миний өмнөх сонгосныг үл харгалзан, Хөтөлбөрийн 7-р зүйлд заасны дагуу энэхүү өдрөөс хойш хуримтлуулсан Бэлэн Төлбөрийн хураамжийн аль ч хэсгийг ИОХЭ-ээр төлөгдөхгүй байхыг би үүгээр сонгож байна.

Хөтөлбөрийн дагуу урьд олгосон ИОХЭ-ийг Хөтөлбөрт өөрөөр зааснаас бусад тохиолдолд буцааж авах боломжгүй гэдгийг би ойлгож байна.

Би Хөтөлбөрийг хуулбарыг хүлээн авч, хянаж үзсэнээ баталж, Хөтөлбөрийн нөхцөлийг дагаж мөрдөхөө зөвшөөрч байна.

Огноо: \_\_\_\_\_

\_\_\_\_\_  
(Оролцогчийн нэр)

\_\_\_\_\_  
(Оролцогчийн гарын үсэг)

**Тайлбар:** Нэмэлт ИОХЭ хүлээн авахаа цуцлах сонголтыг Оролцогч санхүүгийн жилд нэг удаа хийж болно.

## ХАВСРАЛТ С

### ЭРДЭНЭС РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

#### ХУВЬЦААНД СУУРИЛСАН УРАМШУУЛЛЫН БАГЦ ХӨТӨЛБӨР ("ХӨТӨЛБӨР")

#### НЭМЭЛТ ИОХЭ ХҮЛЭЭН АВАХАА ЦУЦЛАХ СОНГОЛТ (АНУ-ЫН ТАТВАР ТӨЛӨГЧ)

Энд ашигласан боловч өөрөөр тодорхойлогдоогүй бүх том үсгээр бичсэн нэр томъёог Хөтөлбөрт тусгасан утгаар ойлгоно.

Хөтөлбөрийн А Хавсралтад миний өмнөх сонгосныг үл харгалзан, Хөтөлбөрийн 7-р зүйлд заасны дагуу энэхүү өдрөөс хойш хуримтлуулсан Бэлэн Төлбөрийн хураамжийн аль ч хэсгийг ИОХЭ -ээр төлөгдөхгүй байхыг би үүгээр сонгож байна.

Нэмэлт ИОХЭ хүлээн авахыг цуцлах энэ удаагийн сонголт нь Корпорацид энэхүү цуцлах мэдэгдлийг ирүүлснээс хойш санхүүгийн жилийн эхний өдөр хүртэл хүчин төгөлдөр болохгүй гэдгийг би ойлгож байна.

Хөтөлбөрийн дагуу аль хэдийн олгосон ИОХЭ-ийг Хөтөлбөрт өөрөөр зааснаас бусад тохиолдолд буцааж авах боломжгүй гэдгийг би ойлгож байна.

Би Хөтөлбөрийн хуулбарыг хүлээн авч, хянаж үзсэнээ баталж, Хөтөлбөрийн нөхцөлийг дагаж мөрдөхөө зөвшөөрч байна.

\_\_\_\_\_

Огноо:

\_\_\_\_\_

(Оролцогчийн нэр)

\_\_\_\_\_

(Оролцогчийн гарын үсэг)

**Тайлбар:** Нэмэлт ИОХЭ хүлээн авахыг цуцлах сонголтыг Оролцогч санхүүгийн жилд нэг удаа хийж болно.